



ОНЦГОЙ БАЙДЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗАР



ГАМШИГ СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

# ГАМШГААС ХАМГААЛАХ ЦАГААН НОМ 2022

УЛААНБААТАР ХОТ  
2023 ОН

---

## ГАМШГААС ХАМГААЛАХ ЦАГААН НОМ 2022

Гамшгаас урьдчилан сэргийлэх газрын  
Олон нийттэй харилцах хэлтэст эх бэлтгэлийг хийв.

### **Хянан тохиолдуулсан:**

Бригадын генерал Б.Ууганбаяр  
Хурандаа Ж.Амгалан (Ph.D)  
Дэд хурандаа П.Чимэдцэрэн (Ph.D)

### **Боловсруулсан:**

ГАМШИГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

Хошууч Б.Батбаяр  
Хошууч С.Солонго  
Ахмад Т.Өсөхжаргал (Ph.D)  
Ахмад Д.Нарантуяа  
Энгийн С.Ренчинханд  
Дэд хурандаа Д.Содномрагчаа  
Дэд хурандаа Б.Энхтуул

### **Хэвлэлийн эх бэлтгэсэн:**

Ахмад Б.Отгон

Улаанбаатар хот. 2023 он  
Онцгой байдлын ерөнхий газар

## АГУУЛГА

<b>ӨМНӨХ ҮГ</b>	6
<b>НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. ГАМШГААС ХАМГААЛАХ УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТ</b>	8
1.1. ГАМШГААС ХАМГААЛАХ ЭРХЗҮЙН ШИНЭЧЛЭЛ	9
1.1.1. Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор батлуулсан баримт бичиг	9
1.1.2. Монгол Улсын шадар сайдын тушаалаар батлагдсан баримт бичиг	9
1.1.3. Онцгой байдлын ерөнхийн газрын даргын тушаалаар батлагдсан баримт бичиг	10
1.1.4. Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газрын даргын тушаалаар баталсан баримт бичиг	11
1.2. ГАМШГААС ХАМГААЛАХ БОДЛОГО, ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ	11
1.2.1. Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн хэрэгжилт	12
1.2.2. Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн Монгол Улсын дунд хугацааны хэрэгжилт	12
1.3. ГАМШГААС ХАМГААЛАХ ОЛОН ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГАА	19
1.3.1. Гадаад хамтын ажиллагаа, айлчлал	19
1.3.2. Онцгой байдлын байгууллагад хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр	24
1.4. ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН ЧАДАВХ	27
1.4.1. Онцгой байдлын байгууллагын бүтэц, зохион байгуулалтын бэхжилт	27
1.4.2. Бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийн талаар	27
1.4.3. Техник хэрэгсэл, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт	35
1.5. ГАМШГААС ХАМГААЛАХ СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦ	38
1.5.1. Онцгой байдлын ерөнхий газрын Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн үйл ажиллагаа	38
1.5.2. Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгийн үйл ажиллагаа	39
1.5.3. Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн үйл ажиллагаа	47
1.5.4. Онцгой тусгай хувцас, хэрэгслийн туршилт үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагаа	48
<b>ХОЁРДУГААР ХЭСЭГ. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ</b>	49
2.1. ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	50
2.1.1. Олон нийтэд зориулсан Гамшгаас урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээ	50
2.1.2. Гамшгаас хамгаалах сургалт	53
2.1.3. Гамшгаас урьдчилан сэргийлэх хэвлэл мэдээллийн сурталчилгаа	55

2.2. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	59
2.2.1. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийсэн байдал	59
2.2.3. Гамшгийн эрсдэлийн үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагаа	62
2.2.4. Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний болон орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагаа	62
<b>ГУРАВДУГААР ХЭСЭГ. ГАМШГИЙН ҮЕИЙН ШУУРХАЙ УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТ</b>	64
3.1. ГАМШГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ /СТАТИСТИК МЭДЭЭ, ЭРЭН ХАЙХ, АВРАХ АЖИЛЛАГАА/	65
3.1.1. Монгол оронд тохиолдсон аюулт үзэгдэл, ослын тойм	65
3.1.2. Монгол Улсад 2022 онд гарсан зарим томоохон аюулт үзэгдэл, ослын тойм:	69
3.1.3. 2022 оны уур амьсгалын жилийн тойм	72
3.2. ГАЛ ТҮЙМРИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	85
3.2.1. Объектын гал түймэр	85
3.2.2. Ой, хээрийн гал түймэр	86
3.2.3. Урьдчилан сэргийлэх, хяналт шалгалт	87
<b>ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ. ХОР УРШГИЙГ АРИЛГАХ, СЭРГЭЭН БОСГОХ АЖИЛЛАГАА</b>	88
4.1. УЛСЫН НӨӨЦ ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖ	89
4.2. УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	90
4.3. ХӨВСГӨЛ НУУРТ ЖИВСЭН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ ЭРЭН ХАЙХ, ИЛРҮҮЛЭХ, ТАТАН ГАРГАХ АЖИЛЛАГАА	95
<b>ТАВДУГААР ХЭСЭГ. НЕФТИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХАД ГАРСАН ГАЛ ТҮЙМРИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ</b>	98
5.1. ҮҮССЭН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААР	99
5.2. ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ	99
5.3. ТУРШЛАГА	104
<b>ХАВСРАЛТ</b>	106

## МЭДЭЭЛЭЛ ИРҮҮЛСЭН ЭХ СУРВАЛЖ

ЦАГААН НОМЫН БҮТЭЦ	МЭДЭЭЛЭЛ ИРҮҮЛСЭН ГАЗАР, ХАРЬЯА БАЙГУУЛЛАГА
<b>1-р хэсэг. Гамшгаас хамгаалах удирдлага</b>	
Бүлэг 1.1. Гамшгаас хамгаалах эрхзүйн шинэчлэл	БТГ, ЭУГ, ГТТГ
Бүлэг 1.2. Гамшгаас хамгаалах бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт	БТГ, УСГ, ГТТГ, САТГ
Бүлэг 1.3. Гамшгаас хамгаалах олон талт хамтын ажиллагаа	БТГ, ГТТГ, 111-р анги
Бүлэг 1.4. Онцгой байдлын байгууллагын чадавх	ЗУГ, БТГ, АУГ, ГТТГ, УНГ, САТГ, 111-р анги
Бүлэг 1.5. Гамшгаас хамгаалах судалгаа, шинжилгээ, инновац	ГСҮХ, ОБСургууль, 121-р анги
<b>2-р хэсэг. Урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах</b>	
Бүлэг 2.1. Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа	УСГ, АУГ
Бүлэг 2.2. Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа	ЭУГ
<b>3-р хэсэг. Гамшгийн үеийн шуурхай удирдлага, зохицуулалт</b>	
Бүлэг 3.1. Гамшгийн нөхцөл байдал /статистик мэдээ, эрэн хайх, аврах ажиллагаа	АУГ, ГТТГ, ШУЗМТ, YAБ
Бүлэг 3.2. Гал түймрийн нөхцөл байдал	ГТТГ
<b>4-р хэсэг. Хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагаа</b>	
Бүлэг 4.1. Улсын нөөц хүмүүнлэгийн тусламж	УНГ, САТГ,
Бүлэг 4.2. Улсын онцгой комиссын үйл ажиллагаа	УОК-ын ажлын алба
<b>5-р хэсэг. Нефтийн бүтээгдэхүүний агуулахад гарсан гал түймрийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлсэн хариу арга хэмжээ</b>	
Бүлэг 5.1. Удирдлага, зохион байгуулалт	ГТТГ, АУГ, ГСҮХ
Бүлэг 5.2. Үүссэн нөхцөл байдал	ГТТГ
Бүлэг 5.3. Учирсан хохирол, хэрэгцээ	ГТТГ, АУГ
Бүлэг 5.4. Туршлага, сургамж	ГТТГ, АУГ
Шифрийн мэдээ	АУГ

## ӨМНӨХ ҮГ

Уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтлоос шалтгаалж байгалийн гамшгийн тоо, тохиолдох давтамж, эрчим улам бүр нэмэгдэж, түүнээс учрах хохирол жил бүр өсөн нэмэгдэж, улс орны нийгэм эдийн засаг, хүн амын амьжиргаа, улс орны дотоод аюулгүй байдалд сөрөг нөлөөлөл үзүүлсээр байна.

Дэлхийн улс орнуудын нэгэн адил Онцгой байдлын байгууллага нь Монгол Улсын хэмжээнд тохиолдсон гамшгийн нөхцөл байдал, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ, түүнээс авсан сургамж, сайн туршлагаа нэгтгэж багтаасан “Гамшгаас хамгаалах цагаан ном”-ыг 2017 оноос жил бүр эмхэтгэн монгол, англи хэл дээр гаргаж байна.

Монгол Улсын хэмжээнд 2022 онд нийт 4321 удаагийн аюулт үзэгдэл, осол бүртгэгдэж, үүний улмаас 400 орчим хүн амь насаа алдаж, 33 тэрбум гаруй төгрөгийн шууд хохирол учирсан. Томоохон гамшгийн түвшинд хүрсэн нөхцөл байдлын хувьд уламжлалт байгалийн аюулт үзэгдлийн зэрэгцээ хүний санаатай болон санамсар болгоомжгүй байдлаас үүссэн үйлдвэрлэлийн томоохон ослууд тохиолдож, эдгээрийн хор уршгийг арилгахад ихээхэн хүн хүч, хөрөнгө нөөцийг зарцуулан ажиллаж, хугацаа алдалгүй таслан зогсоосон.

Тухайлбал; Дархан-Уул аймагт газрын тосны бүтээгдэхүүн хадгалах агуулахад 2022 оны 12 дугаар сарын 1-ний өдөр томоохон гал түймэр гарч, дэлбэрэлт болсон.

Гал түймрийг унтраах үйл ажиллагаа нийтдээ 9 цаг гаруй үргэлжилж, гал түймэр унтраах, аврах 10 анги 140 гаруй алба хаагч, 20 техник хэрэгсэл, 150 тонн ус, 18.2 тонн хөөс үүсгэгч бодис зарцуулан ажиллалаа. Гал түймэрт өртсөн саван дахь шатахуун бүрэн шатсан бол 800,800 кг нүүрсхүчлийн хий агаарт дэгдэж, байгаль экологид ихээхэн хэмжээний хохирол учрахаар байсныг цаг алдалгүй таслан зогсоож чадсан. Энэ осол нь манай улсад тохиолдсон томоохон ослын нэг байсан бөгөөд эндээс чамгүй мэдлэг, туршлага хуримтлуулж, сургамж авсан жил болж өнгөрлөө.

Энэхүү номонд гамшгаас хамгаалах эрх зүйн орчны шинэчлэл, урьдчилан сэргийлэх болон эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа, бодлого хөтөлбөрийн хэрэгжилт, гадаад дотоод хамтын ажиллагаа, онцгой байдлын байгууллагын чадавх, улсын нөөц, хүмүүнлэгийн тусламж, гамшгаас хамгаалах судалгаа, шинжилгээ, инновацын ажил, төсөв, хөрөнгө оруулалтын талаарх бодит мэдээллүүдийг тусгасан болно.

Та бүхэн энэхүү эмхэтгэлээс онцгой байдлын байгууллага, гамшгаас хамгаалах үйл ажиллагааны талаарх 2022 оны мэдээ, мэдээллийг олж авч чадна гэдэгт гүнээ итгэж байна.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,  
ХОШУУЧ ГЕНЕРАЛ Г.АРИУНБУЯН

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ.

**ГАМШГААС ХАМГААЛАХ  
УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТ**



## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. ГАМШГААС ХАМГААЛАХ УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТ

### 1.1. ГАМШГААС ХАМГААЛАХ ЭРХЗҮЙН ШИНЭЧЛЭЛ

#### 1.1.1. Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор батлуулсан баримт

2022 онд ГХТХ болон бусад холбогдох хуульд дараах өөрчлөлтүүд орон байна. Үүнд: Гамшгаас хамгаалах тухай хуулийн 50 дугаар зүйл 50.11 дэх хэсэгт зааснаар “Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа онцгой байдлын байгууллагын алба хаагчид таван жил тутамд 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгоно” гэснийг Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 188 дугаар тогтоолоор батлуулжээ. Тогтоол батлагдснаар аймгийн төвөөс бусад суманд ажиллаж байгаа Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын нийгмийн баталгааг хангаж мөнгөн урамшуулал олгох эрх зүйн орчин бий боллоо.

Улсын Их Хурлаас Гамшгаас хамгаалах тухай хуульд 2022 онд 1 удаагийн нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд тус хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалт, 22 дугаар зүйлийн 22.3, 22.6, 22.8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.1.1 дэх заалт, 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэг, 51 дүгээр зүйлийн 51.2, 51.4 дэх хэсгийг "сум, нийслэл," гэж өөрчилжээ;

Мөн Галын аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн гарчиг, 15.1 дэх хэсэг, 15.1.7 дахь заалтад "сум, нийслэл," гэж; Улсын нөөцийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн "сум, нийслэл," гэж өөрчилж, мөн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалтын "мэргэжлийн хяналтын" гэснийг "төрийн захиргааны төв байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий", 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн, 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалтын "мэргэжлийн хяналтын" гэснийг "холбогдох төрийн захиргааны төв байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий" гэж, 17.1.5 дахь заалтын "чанар, стандарт, эрүүл ахуй болон ургамал хорио цээрийн мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн" гэснийг "холбогдох төрийн захиргааны төв байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын" гэж тус тус өөрчилсөн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн тогтоолоор “Коронавируст халдвар /КОВИД-19/ тархалтын түвшинд үндэслэн хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах” журмыг шинэчлэн баталж коронавируст халдвар /КОВИД-19/ тархалтын түвшин, дархлаажуулалтын хамралт, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалд үндэслэн халдварын үеийн хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулжээ.

#### 1.1.2. Монгол Улсын шадар сайдын тушаалаар батлагдсан баримт бичиг

Монгол Улсын шадар сайдын 2022 оны 92 дугаар тушаалаар “Газар

хөдлөлтийн мэдээ, мэдээллийг дамжуулах, мэдээлэх” журмыг шинэчлэн баталсан. Энэхүү журмаар Монгол орны нутаг дэвсгэр болон хил орчмын бүс нутагт үүссэн газар хөдлөлтийн мэдээ, мэдээллийг мэргэжлийн байгууллагын дүгнэлтэд үндэслэн харилцаа холбооны сувгаар иргэдэд мэдээлэх харилцааг зохицуулсан байна.

### **1.1.3. Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан баримт бичиг**

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2022 оны А/251 дүгээр тушаалаар “Гамшиг судлал, инновац онол аргагүйн мэргэжлийн сэтгүүлийг эрхлэн гаргах” журам батлагдаж Онцгой байдлын ерөнхий газрын Шинжлэх ухаан, технологийн зөвлөл, Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгийн эрхлэн гаргадаг “Гамшиг судлал, инновац” сэтгүүлийг эрхлэн гаргахтай холбогдсон харилцааг зохицуулсан байна.

2022 оны А/190 дүгээр тушаалаар “Онцгой байдлын ерөнхий газрын хөдөлмөрийн дотоод журам” батлагдсан. Тус журмаар Онцгой байдлын ерөнхий газрын дотоод үйл ажиллагааг зохион байгуулах, ерөнхий газрын алба хаагч, төрийн үйлчилгээний ажилчдын хооронд үүсэх хөдөлмөрийн харилцааг зохицуулна.

2022 оны А/169 дүгээр тушаалаар “Онцгой байдлын байгууллагад химийн хорт бодис хадгалах түр журам”-ыг баталсан. Энэхүү журмаар Онцгой байдлын байгууллагад химийн хорт болон аюултай бодисын агуулахад химийн хорт болон аюултай бодисийг хүлээн авах, хадгалах үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулан тусгажээ.

2022 оны А/88 дугаар тушаалаар “Онцгой байдлын байгууллагын харьяа нэгжийн үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт зохион байгуулах” аргачлалыг баталсан. Төрийн бодлого, шийдвэр, хууль тогтоомж, байгууллагын хэтийн болон тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, дэвшүүлсэн зорилтыг хангах чиглэлээр Онцгой байдлын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн болон харьяа салбар, нэгжийн авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, ажил үйлчилгээ, үйл ажиллагаа, алба хаагчдын ажил, гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр нөлөө, бүтээмжийг дээшлүүлэх, үр дүнг үнэлэхэд энэхүү аргачлалыг ашиглана.

2022 оны А/324 дүгээр тушаалаар “Зам тээврийн ослын үед аврах ажиллагаа зохион байгуулах” зааврыг баталсан. Уг заавраар зам тээврийн ослын үед аврах ажиллагаа зохион байгуулах алба хаагчдыг шуурхай удирдлагаар хангах, голомтод үүрэг гүйцэтгэх алба хаагчдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй ажиллах нөхцлийг бүрдүүлнэ.

2022 оны А/300 дугаар тушаалаар “Гал түймэр унтраах дасгал сургуулилтын норматив” аргачлалыг баталсан. Тус аргачлалаар бие бүрэлдэхүүний хөдөлмөрийн аюулгүй байдал, сэтгэлзүй, үр чадвар, багаар ажиллах ажиллагаа,

бие бялдрын хувьд бэлтгэж дадлагажуулах стандартыг тогтоожээ.

2022 оны А/188 дугаар “Гал түймэр унтраах, аврах ангид хөтлөх хэргийн нэрийн жагсаалт”-ын загвар, заавар “Гал түймэр унтраах, аврах ангид хөтлөх хэргийн нэрийн жагсаалт”-ын зааврыг батлуулжээ.

2022 оны А/312 дугаар тушаалаар “Орон сууцны барилга байгууламж”, “Соёл урлаг, шашны байгууллагын барилга байгууламж”, “Газрын тосны бүтээгдэхүүний барилга байгууламж”, “Эмнэлгийн байгууллагын барилга байгууламж”-ийн галын аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудсыг батлуулсан байна.

#### **1.1.4. Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газрын даргын тушаалаар баталсан баримт бичиг**

Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2022 оны С/39 дугаар тушаалаар баталсан “Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх үйл ажиллагаа” MNS 6980:2022 стандарт Онцгой байдлын байгууллагаас гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэл дамжуулах, дадлага сургууль зохион байгуулах, зарлан мэдээллийн системийн техникийн түршилт хийх үйл ажиллагаанд хамаарна.

Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2022 оны С/39 дугаар тушаалаар баталсан “Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх системд тавих техникийн ерөнхий шаардлага” MNS 6979:2022 стандартаар зарлан мэдээллийн системийн төлөвлөлт, ажлын байрны эргономикийн шаардлагыг тогтоох, ажиллах тохиромжтой нөхцөл, шаардлагыг бий болгох, зарлан мэдээллийн тоног төхөөрөмжийг суурилуулах, байршуулах, түүнийг хэвийн ажиллуулах, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, гол өрөөнүүдийн зохион байгуулалт, түүний тоноглол болон туслах хэрэгслүүд, зарлан мэдээллийн системд тавих шаардлагыг тогтоосон.

## **1.2. ГАМШГААС ХАМГААЛАХ БОДЛОГО, ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ**

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээний хийх нийтлэг журам”-ын дагуу “Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 303 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшгийн эрсдэлийг олоннийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр”, Монгол Улсын Шадар сайдын 2016 оны 50 дугаар тушаалаар батлагдсан үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 2022 оны хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн. “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны I үе шат 2016-2020 онд нийт 41 арга хэмжээ хэрэгжиж 91.2 хувийн үнэлгээтэй дүгнэгджээ.

Тус төлөвлөгөө”-нд 6 зорилтын хүрээнд 20 арга хэмжээг 2021-2025 он

хүртэл хэрэгжүүлэхээр тусгагдсан ба 2022 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийг тооцоход биелэлт 97.0 хувьтай үнэлэгдсэн.

### **1.2.1. Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн хэрэгжилт**

Япон Улсын Сендай хотод 2015 онд зохион байгуулагдсан Гамшгийн эрсдэлийг бууруулах Дэлхийн III бага хурлаас НҮБ-ын гишүүн 187 улс “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ 2015-2030” баримт бичгийг санал нэгтэй баталж, энэхүү баримт бичигт дэвшүүлсэн 7 зорилт, үйл ажиллагааны 4 тэргүүлэх чиглэлийг үндэсний хууль тогтоомжид нийцүүлэн өөрийн улсын чадавх, нөөц бололцоонд тулгуурлан хэрэгжүүлэхээр үүрэг амлалт авсан.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 355 дугаар тогтоолоор “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”-ийг 2017-2020, 2021-2025, 2026-2030 он хүртэл 3 үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Дунд хугацааны стратегийн эхний үе шатанд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 2020 онд дуусгавар болж, 94,7 хувьтай дүгнэгдсэн.

Хоёрдугаар үе шат /2021-2025 он/-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Шадар сайдын 2021 оны 51 дүгээр тушаалаар батлуулсан бөгөөд 2021-2022 оны байдлаар хэрэгжилтийн явц 91,4 дүгнэгдсэн байна. II үе шатыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн дэвшүүлсэн тэргүүлэх 4 чиглэлийн хүрээнд нийт 56 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тусгасан.

### **1.2.2. Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн Монгол Улсын дунд хугацааны хэрэгжилт**

Монгол Улс гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр авсан үүрэг амлалтаа биелүүлж, Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийг амжилттай хэрэгжүүлж, тэргүүлэх чиглэлийн дагуу олсон томоохон ололт амжилт, өөрчлөлт, учирч буй хүндрэл бэрхшээл, цаашид анхааран авч хэрэгжүүлэх арга хэмжээг тэргүүлэх чиглэлийн дагуу товчлон танилцуулж байна. Үүнд:

#### **Тэргүүлэх чиглэл 1. Эрсдэлийг ойлгох**

##### **Ололт амжилт:**

- Гамшгийн эрсдэлийн үнэлгээний эрх зүйн орчинг сайжруулах, улсын болон орон нутгийн түвшинд гамшгийн эрсдэлийг тодорхойлох үйл ажиллагаанд томоохон өөрчлөлт ахиц гарч байна.

“Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам, заавар шинэчлэгдэн, гамшгийн эрсдэлийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээг улс, орон нутаг, байгууллага, олон нийт, объектын түвшинд гүйцэтгэн ажиллаж байна. Тухайлбал, 2019-2022 онд сургууль, цэцэрлэгийн багш, сурагч, эцэг эхийн оролцоотойгоор

аймгийн хэмжээнд төрийн өмчийн сургууль, цэцэрлэгийн 76 хувь, нийслэлийн бүх сургуульд 100 хувь буюу улсын хэмжээнд 85 хувьд гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийж гүйцэтгэсэн. Зам, тээврийн салбарын түвшинд олон улс, улсын чанартай авто болон төмөр замд учирч болзошгүй үерийн гамшгийн ерөнхий үнэлгээг улсын хэмжээнд авто замд үерийн усанд өртөж болзошгүй 1250 цэг, төмөр зам дагуу 52 цэг байгааг тодорхойлсон. КОВИД-19 цартахлын үед нөхцөл байдлын үнэлгээг тухай бүр гүйцэтгэжээ.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгад гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд гүйцэтгэхээр тусгасан нь гамшгаас хамгаалах салбарт төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлэх нэгэн шинэ алхам болсон. Хуулийн этгээдэд Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг зохицуулах Гамшгийн эрсдэлийн үнэлгээний мэргэжлийн зөвлөлийг байгуулж, 2019-2022 оны хугацаанд нийт 33 хуулийн этгээдэд гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл олгосон. Эдгээр тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдүүд нийт 398 аж ахуйн нэгж, байгууллагад гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийж гүйцэтгэсэн байна.

Гамшгийн эрсдэлийн үнэлгээний үр дүн нь эрсдэлийн мэдээлэлд суурилсан шийдвэр гаргах, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

- Гамшгийн мэдээллийн сангийн хувьд гамшгийн мэдээллийг 2010 онд 6 хэсэгт хамаарах 21 үзүүлэлтээр гаргаж байсан бол 2020 онд ойролцоогоор 16 хэсэгт хамаарах 300 үзүүлэлтээр гаргах болсон. Мэдээллийн санд бүртгэх хэсгийн агуулга 62%, эдгээр хэсэгт хамаарах үзүүлэлтүүд 14 дахин нэмэгдсэн. ОБЕГ, Үндэсний статистикийн хорооны хамтарсан ажлын хэсэг гамшиг, аюулт үзэгдэл, ослын бүртгэлийн маягт, зааврыг ашиглаж байсан гамшгийн мэдээллийн маягт, Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичигтэй уялдуулан шинэчлэн боловсруулж, Шадар сайдын 2020 оны 22 дугаар тушаалаар батлуулсан. Эдгээр маягт зааварт геологийн гаралтай, биологийн гаралтай, ус, цаг агаарын гаралтай аюулт үзэгдэл, гал түймэр, хүний үйл ажиллагаатай холбоотой осол гэсэн гамшгийн 5 ангилал тус бүрийг бүртгэх маягт, гамшгийн улмаас учирсан бодит хохирол, хэрэгцээний тойм, гамшиг болсон эсэхийг тодорхойлох маягт, заавар багтсан юм.

- Олон нийтийн гамшгийн эрсдэлийг бууруулах мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд Засгийн газрын 2015 оны 303 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр” ихээхэн үүрэг гүйцэтгэж байна. Тус үндэсний хөтөлбөрийг “гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, сургалт, сурталчилгаа, үйл ажиллагаанд

иргэдийг оролцуулан, тэдний мэдлэг, чадварыг дээшлүүлэх, аюулгүй амьдрах ухамсарт соёл болон болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг бэхжүүлэх замаар гамшгийн эрсдэлийг бууруулах” зорилгын дор 2015-2025 оны хугацаанд 2 үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

- Монгол Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах сургалтыг удирдах албан тушаалтны, онцгой байдлын байгууллагын, оюутан, сурагч, сургуульд элсэхийн өмнөх насны хүүхдийн, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн албан тушаалтан, ажилтны, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн болон иргэний гэсэн ангиллаар зохион байгуулж байна. Олон нийтэд чиглэсэн сургалт зохион байгуулсан тоо 2015 онтой харьцуулахад 2021 онд 30 хувь нэмэгдсэн.

- Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын хувьд 2015-2022 онд 53 суурь болон хавсарга судалгаа гүйцэтгэсэн нь шинжлэх ухаанд суурилсан гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн.

#### **Хүндрэл бэрхшээл:**

- Гамшгийн эрсдэлийг иргэд олон нийтэд ойлгуулах, шинэ технологи, арга аргачлал нэвтрүүлэх, ашиглах, үнэлгээний үр дүнд шинжилгээ хийх, шийдвэр гаргагч, бодлого боловсруулагчдад хүргэх, түгээх, аюулын зураглалыг боловсруулж олон нийтэд хүртээмжтэй хялбар аргаар хүргэх, үнэлгээний дараах хяналт мониторинг хийх үйл ажиллагаа хүндрэлтэй хэвээр байна.

- Гамшгийн мэдээллийг иргэд олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй хүргэхэд дэвшилтэт технологи ашиглаж чадахгүй байна.

- Гамшгийн хохирлын ангилсан мэдээллийн хувьд үзүүлэлт нэмэгдсэн хэдий ч гамшигт амь насаа алдсан, нэрвэгдсэн иргэдийг хөгжлийн бэрхшээл, орлогын байдлаар нь ангилсан мэдээлэл цуглуулах ажил хүндрэлтэй.

### **Тэргүүлэх чиглэл 2. Гамшгийн эрсдэлийг удирдах засаглалыг бэхжүүлэх**

#### **Ололт амжилт:**

- Бодлогын хувьд үндэсний хэмжээнд “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр 2015-2025”, “Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги 2017-2030”-ийг Монгол Улсын хөгжлийн баримт бичиг болох “Алсын хараа 2050”, “Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр”-тэй уялдуулан хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр олон нийт, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, алслагдмал нутгийн иргэдийн гамшгийг даван туулах чадавхыг бий болгоход чиглэсэн арга хэмжээ мэдэгдэхүйц өссөн. Мөн түүнчлэн гамшгийн эрсдэлийн үнэлгээний үр дүнд суурилж Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг 21 аймаг, нийслэл буюу бүх орон нутаг шинэчилж, Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн “е” зорилтыг хангасан.

- Эрхзүйн хувьд 2015 онд Галын аюулгүй байдлын тухай хууль, 2017 онд Гамшгаас хамгаалах тухай хуулийг тус тус шинэчилсэн бөгөөд энэ шинэчлэл нь гамшгаас эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд ихээхэн өөрчлөлт, дэвшил авчирсан. Үүний нэг нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 2017 оны шинэчилсэн найруулгаар улсын хэмжээнд Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл байгуулах эрх зүйн орчин бүрдсэн явдал юм. Үндэсний зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд тэргүүлдэг. Энэхүү үндэсний зөвлөл нь яам, төрийн байгууллага, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн нийт 29 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

- Эдгээр хуулиудын шинэчлэлийн хүрээнд 2022 оны 12 дугаар сарын байдлаар Засгийн газрын тогтоолоор 20, Шадар сайдын тушаалаар 28, ОБЕГ-ын даргын тушаалаар 57 дүрэм, журам, заавар, удирдамж зэрэг нийт 105 эрх зүйн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчилсэн батлуулсан байна.

#### **Хүндрэл бэрхшээл:**

- Салбарын түвшинд эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд хүний нөөц, хөрөнгө оруулалтын асуудал, салбар хоорондын хамтын ажиллагаа зарим талаар дутмаг байна.

- Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр холбогдох талуудын мэдлэг ойлголт хангалтгүй байна.

#### **Тэргүүлэх чиглэл 3. Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт хийх**

##### **Ололт амжилт:**

- Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор Улсын Их хурлаас 2017 онд шинэчлэн баталсан Гамшгаас хамгаалах тухай хуульд “гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн байгууллага тухайн жилийн төсвийн 1-ээс доошгүй хувийг, хуулийн этгээд тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг төсөвлөж зарцуулна” гэсэн заалтыг нэмж тусгасан. Үүний үр дүнд Монгол Улсын 21 аймгийн засаг захиргаа нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд зарцуулахаар тусгасан төсвийн хэмжээ 2018 онд 2.3 тэрбум төгрөг байсан бол энэ тоо 2022 онд 10.4 тэрбум төгрөг болж 4 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

- Гамшгийн эрсдэлийг шилжүүлэх зорилгоор малчдын ган, зудыг хохирол багатай даван туулах менежментийн нэг хэсэг нь малын даатгалын асуудал юм. Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль 2014 оноос Монгол Улсад хэрэгжиж эхэлснээс 21 аймгийн 330 сум, нийслэлийн 6 дүүргийн хэмжээнд

малын индексжүүлсэн даатгалын үйлчилгээг үзүүлж байна. 2016-2021 онд нийт малчин өрхийн 11.7-19.8 хувь нь малын индексжүүлсэн даатгалд хамрагдсан. Цаашид нэмэгдүүлэх шаардлагатай.

#### **Хүндрэл бэрхшээл:**

- Гамшгийн эрсдэлийг бууруулахад хөрөнгө оруулалт дутагдалтай байна. Гамшгийн дараа хор уршгийг арилгах ажиллагааны зардал гамшгийн өмнө урьдчилан сэргийлэх зардлаас олон дахин өндөр байна.
- Гамшгийн эрсдэлийг бууруулах санхүүжилтийн стратеги, арга механизмыг тодорхойлоогүй.
- Гамшгийн эрсдэлийг шилжүүлэх даатгалын эрх зүйн орчин дутагдалтай.

**Тэргүүлэх чиглэл 4. Гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд бэлэн байдлыг хангах, гамшгийн дараах сэргээн босгох, нөхөн сэргээх үе шатанд “Сайжруулан барьж байгуулах” үйл ажиллагааг хэрэгжүүлэх**

#### **Ололт амжилт:**

- Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөө болох "Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал, амьтныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөө" нь Засгийн газрын 2015 оны 416 дугаар тогтоолоор батлагдсан. КОВИД-19 халдварын үед энэхүү төлөвлөгөөний дагуу Эрүүл мэндийн улсын алба ажилласан.
- Монгол Улсын барилга байгууламжийн норм, нормативын сангийн үйл ажиллагааны 2019 оны төлөвлөгөөний дагуу 10 төрлийн норм, нормативын баримт бичгийг шинээр болон шинэчлэн боловсруулан мөрдөж байна.
- Өндөр ууланд цасан нурангид дарагдсан томоохон осол 2015, 2017 онд дараалан тохиолдсон сургамжид үндэслэн өндөр ууланд эрэн хайх, аврах ажиллагаа явуулах эрх зүйн баримт бичгийг шинэчилж, дадлага сургалтыг олон улсын аврагчидтай зохион байгуулж байна.
- Газар хөдлөлтийн гамшгийн бэлэн байдлыг хангах зорилгоор Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 94, 2020 оны 17 дугаар тогтоолоор түр цугларах талбай (цэг) 192, нүүлгэн шилжүүлэх 31 байршлыг томилгоожуулсан.
- Сэргээн босгох ажиллагааны сайн жишээ бол Хөвсгөл нууранд живсэн “Сүхбаатар” хөлөг онгоцыг татан гаргасан явдал юм. Хөвсгөл нуур нь Монгол Улсын гадаргын цэнгэг усны 75 хувь, дэлхийн гадаргын цэнгэг усны 2 орчим хувийг бүрдүүлдэг, 2 сая жилийн настай нуур юм. Иймд Хөвсгөл нуурыг хамгаалах, бохирдлыг бууруулах зорилгоор нууранд живсэн хөлөг онгоц, автомашиныг татан гаргаж цэвэрлэх ажиллагаа 2021 онд эхэлсэн. Зарим нь шатахуун тээвэрлэж явсан байна. Судалгаагаар Хөвсгөл нууранд живсэн 50 орчим машин, техник байна.
- КОВИД-19 цартахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах,



халдварыг хумих зорилгоор “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”-ийг Улсын Их Хурлаас 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр яаралтай горимоор хэлэлцэн баталсан. Тус хуулийг амжилттай хэрэгжүүлж, хуулийн хүчинтэй хугацаа 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болсон. КОВИД-19 цар тахлын эсрэг дархлаажуулалтад улсын хэмжээнд иргэд идэвхтэй сайн хамрагдсан. 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар зорилтот бүлгийн 1-р тунгийн хамралт 89.6 хувь, 2-р тунгийн хамралт 85.7 хувь, 3-р тунгийн хамралт 53,6 хувь, нийт хүн амын 1-р тун 68,9 хувь, 2-р тун 65,9 хувь, 3-р тун 31,9 хувь тус тус хамралттай байв.

#### **Хүндрэл бэрхшээл:**

- Гамшгийн аюулыг эрт зарлан мэдээлэх системийг хөгжүүлэхэд Монгол Улс анхаарал хандуулж ирсэн хэдий ч гамшгийн аюулыг эрт зарлан мэдээлэх системийн бэлэн байдлыг хангахад хүндрэл бэрхшээлтэй хэвээр байна. Үүрэн холбооны оператор компаниудаар дамжуулан иргэд, олон нийтэд гамшгийн аюулын тухай багц мессеж, сэрэмжлүүлэг хүргэх үйлчилгээ технологийн дэвшил (4G, 5G)-ээс хамааран хоцрогдолтой болох нөхцөл бий болсон.

- Гамшгийн үед үр дүнтэй, шуурхай хариу арга хэмжээний удирдлага, зохицуулалтаар хангах Гамшгийн шуурхай удирдлагын төв байгуулаагүй нь томоохон хэмжээний хор уршгийг арилгах ажиллагааны үед хүндрэлтэй.

**Цаашид** 2030 он хүртэл олон улсын болон дотоодын бүх холбогдох талуудтай хамтран дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг онцолж байна. Үүнд:

Гамшгийн эрсдэлийн үнэлгээ, мэдээлэл, ойлголтыг нэмэгдүүлэх хүрээнд:

- Иргэд, олон нийтийг гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ, гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгааны ажилд оролцуулах, гамшгаас хамгаалах уламжлал мэдлэг ойлголтыг түгээх замаар гамшгийн эрсдэлийг бууруулах мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулахад иргэн бүрийг хамруулах. Иргэд олон нийтийн гамшгийн бэлэн байдлын чиглэлээр судалгааны ажлыг өргөтгөх.

- Эрсдэлийн мэдээлэлд суурилсан шийдвэр гаргах, төлөвлөх, санхүүжүүлэх, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгаас учирч болзошгүй хохирлыг бууруулахад гамшгийн эрсдэлийн үнэлгээний үр дүнг чиглүүлэх,

- Гамшгийн ангилсан дата мэдээлэл боловсруулах, түүний ач холбогдлын талаар оролцогч талуудын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх,

- Гамшгийн мэдээллийг боловсруулахад дэвшилтэт технологи нэвтрүүлэх, мэдээллийг иргэд олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй хүргэх.

- Гамшгийн эрсдэлийн мэдээллийн санг хөгжүүлэх, гамшгийн төрөл

бүрээр хийгдэж буй үндэсний хэмжээний аюулын зураглалыг гаргах ажлыг эрчимжүүлнэ.

**Гамшгийн эрсдэлийг бууруулах засаглал, удирдлага, зохион байгуулалтын хүрээнд**

- Олон улсын болон үндэсний хэмжээнд авсан сургамж, ололт амжилтад тулгуурлан гамшгийн эрсдэлийг бууруулах засаглалыг бэхжүүлэх,
- Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний болон орон нутгийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг олон улс, бүс нутаг, үндэсний болон орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлэх,
- Хот суурин газрын гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлыг системийн түвшинд авч үзэж, хот төлөвлөлтийн бодлого, үйл ажиллагаанд тусгах.

**Гамшгийг тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтын хүрээнд**

- Гамшгийн эрсдэлийг бууруулах санхүүжилтийн стратеги боловсруулан хэрэгжүүлэх,
- Гамшгийн болзошгүй хохирлыг бууруулахын тулд гамшгийн эрсдэлийг бууруулах улсын болон орон нутгийн төсвийн хэмжээг нэмэгдүүлэх,
- Гамшгийн эрсдэлийг шилжүүлэх чиглэлээр гамшгийн эрсдэлийн даатгалын хуулийн төсөл боловсруулах.

**Гамшгийн бэлэн байдал, хор уршгийг арилгах, сайжруулан сэргээн босгох ажиллагааны хүрээнд**

- Гамшгийн үед үр дүнтэй, шуурхай хариу арга хэмжээ авахын тулд Гамшгийн шуурхай удирдлагын төвийг байгуулах, техник тоног төхөөрөмжөөр хангах,
- Гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөг бүх шатанд сайжруулах, төлөвлөгөөний дагуу дадлага сургуулилт хийх,
- КОВИД-19 цар тахлын дараах сургамжид үндэслэн төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах, гамшгийн үед бизнесийн тасралтгүй ажиллагааны төлөвлөлт хийхэд хамтран ажиллах,
- Гамшиг, аюулт үзэгдэл, ослын дараа барилга байгууламж, дэд бүтцийн гамшигт тэсвэртэй байдал, бодлого төлөвлөлтийн оновчтой байдал, хүн амын гамшгийн бэлэн байдалд хяналт хийж, сайжруулан барьж байгуулах,
- Гамшгийн үеийн нүүлгэн шилжүүлэх түр байрны зохион байгуулалтыг сайжруулах,
- Эрт зарлан мэдээллийн системийн өнөөгийн байдлыг сайжруулах, хүн бүр гамшгийн эрт зарлан мэдээлэл хүлээн авах нөхцөлийг хангах.
- Улаанбаатар хотод Зүүн хойд Азийн хүмүүнлэгийн тусламжийн төвийг байгуулах.

Гамшгийн аюул, өртөнгө, эмзэг байдлыг бууруулах, гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, гамшгийн хоруршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагааг сайжруулж, гамшигтай тэмцэх чадавхыг

бэхжүүлэх замаар гамшгийн эрсдэлийг бууруулж, шинэ эрсдэл үүсэхээс сэргийлэх стратегийн зорилгын хүрээнд төлөвлөгөөг 4 тэргүүлэх чиглэл, 8 зорилтын хүрээнд 56 ажил үйлчилгээг 2021-2025 онд хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

- ГЭБ бүх нийтийн ойлголтыг гүнзгийрүүлэх, мэдлэг олгох тэргүүлэх чиглэлийн хүрээнд 2 зорилт, 16 ажлын хэрэгжилт **93.7** хувь,
- ГЭБ үйл ажиллагаанд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх тэргүүлэх чиглэлийн хүрээнд 2 зорилт, 9 ажлын хэрэгжилт **87.5** хувь,
- ГЭБ үйл ажиллагаанд удирдлагын засаглалыг бэхжүүлэх тэргүүлэх чиглэлийн хүрээнд 3 зорилт, 8 ажлын хэрэгжилт **100** хувь,
- Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах, гамшгийн дараах сэргээн босгох, нөхөн сэргээх, шинээр барьж байгуулах үйл ажиллагааг урт хугацаанд төлөвлөн хэрэгжүүлэх тэргүүлэх чиглэлийн хүрээнд 2 зорилт, 23 ажлын хэрэгжилт **86.5** хувь тус тус үнэлгээтэй дүгнэгдлээ.

### **1.3. ГАМШГААС ХАМГААЛАХ ОЛОН ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГАА**

#### **1.3.1. Гадаад хамтын ажиллагаа, айлчлал**

Онцгой байдлын байгууллага нь Гамшгаас хамгаалах, гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр гадаад улс оронтой гурван гэрээнд гарын үсэг зурж, Олон Улсын хурал тэмцээн уралдаанд оролцох зэргээр олон арга хэмжээ зохион байгуулсан байна. Үүнд:

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Гамшгийн эрсдэлийг бууруулах газраас 2007 онд Женев хотноо Гамшгийн эрсдэлийг бууруулах дэлхийн платформ буюу чуулганыг анх удаа зохион байгуулснаас хойш дэлхий нийтээрээ гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр хоёр жил тутам чуулж, гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр батлан гаргасан Олон Улсын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, явц, санал санаачилга, тэргүүн туршлага, авсан сургамж, тулгамдаж буй хүндрэл бэрхшээл, боломжит шийдлүүдийг хэлэлцдэг уламжлал тогтсон. Гамшгийн эрсдэлийг бууруулах дэлхийн VII чуулган Бүгд Найрамдах Индонез Улсын Бали хотноо 2022 оны 5 дугаар сарын 23-28 өдрүүдэд “Эрсдэлээс гамшгийг даван туулах, гамшигт тэсвэртэй байх чадавх руу: КОВИД 19-ийн улмаас өөрчлөгдсөн Дэлхий нийтийн тогтвортой хөгжилд чиглэх нь” сэдвийн хүрээнд зохион байгуулагдсан байна. Тус чуулганы хуралдаанд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Шадар сайд С.Амарсайхан цахим хэлбэрээр оролцож үг хэлсэн бол Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Г.Ариунбуян тэргүүтэй төлөөлөгчид биечлэн оролцжээ.



Зураг 1. Бүгд Найрамдах Индонез Улс Бали хот

Дэлхийн чуулганд биечлэн оролцсон төлөөлөгчдийн тэргүүнүүд Сайд нарын дугуй ширээний үулзалтад урилгаар оролцон гамшгийн эрсдэлийг бууруулах хөрөнгө оруулалт, санхүүжилтийн сэдвээр санал солилцов. Монгол Улсын гамшгаас хамгаалах үйл ажиллагааны хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хууль эрх зүйн орчин, хэрэгжилт, тулгамдаж буй асуудлыг танилцуулсан байна. Тус үулзалтаар, улс орнууд гамшгийн эрсдэлийг бууруулах санхүүгийн бодлогоо тодорхойлох, шинэчлэх, нэн тэргүүнд авах арга хэмжээг эрэмблэн хөрөнгө оруулалт хийх, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх зэрэг асуудлыг хэлэлцэв. Гамшгаас урьдчилан сэргийлэхэд зарцуулсан хөрөнгө оруулалт гамшгийн дараа учрах хохирлыг бууруулах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгоход зарцуулах зардлын хэмжээг үлэмж бууруулдгийг улс орнуудад дахин сануулж, эрсдэлийг бууруулах санхүүжилт, хөрөнгө оруулалтаа өнөөгийн байгаа хэмжээнээс бууруулахгүй, нэмэгдүүлэхийг зөвлөв. Ази, Номхон далайн бүсийн түншлэлийн хуралдаанд оролцож, НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газар, Монгол Улсын Засгийн газар хамтран 2018 онд Улаанбаатар хотноо зохион байгуулсан Гамшгийн эрсдэлийг бууруулах Азийн сайд нарын бага хурлаас гарсан баримт бичиг гамшгийн хэрэгжилт, гамшгийн эрсдэлийн удирдлагын засаглал, үнэлгээний эрх зүйн шинэчлэл зэрэг олсон ололт амжилт, сургамж, учирсан бэрхшээл сорилтын талаар танилцуулж, Австралийн Брисбан хотноо 2022 оны 9 дүгээр сарын 19-22-ны өдрүүдэд зохион байгуулагдах Гамшгийн эрсдэлийг бууруулах Ази, Номхон далайн сайд нарын бага хурлын сэдэв, онцлон хэлэлцэх асуудлыг дэмжиж байгааг илэрхийлжээ.

2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Гамшгийн эрсдэлийг бууруулах газраас Австралийн Холбооны Улстай хамтран тус улсын Брисбэн хотноо 2022 оны 9 дүгээр сарын 19-22-ны өдрүүдэд Гамшгийн эрсдэлийг бууруулах Ази, Номхон далайн орнуудын сайд нарын бага хурлыг зохион байгуулсан. Гамшгийн эрсдэлийг бууруулах Ази, Номхон далайн орнуудын сайд нарын бага хуралд Монгол Улсаас Шадар сайд С.Амарсайхан, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Г.Ариунбуян, нийслэлийн Иргэдийн


төлөөлөгчдийн хурлын дарга Ж.Батбаясгалан тэргүүтэй төлөөлөгчид оролцлоо. Тус хурал “Хямралаас гамшгийг даван туулах чадавх руу” сэдвийн дор зохион байгуулагдаж “Сендайн дунд хугацааны тайлан” сэдэвт салбар хуралдааныг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан нээж хэлсэн үг хэллээ. Тэрээр хэлсэн үгэндээ:

“Ази-Номхон далайн түншлэлийн форумар 2021-2024 онд хэрэгжүүлэх Ази-Номхондалайн бүс нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө 2021 онд батлагдсан. Уг төлөвлөгөөний дагуу бид гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээг “КОВИД-19” цартахлын нөхцөл байдалд шинэ арга барилаар өөрчлөн хэрэгжүүлэх, өргөжүүлэх, сайн туршлага, шинэ инновацыг нэвтрүүлэхэд зорьж байна. Дээрх баримт бичгийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд Улс орнуудын боловсруулж буй дунд хугацааны тайлан илтгэлд тусна гэдэгт илтгэлтэй байна. Гамшгийн эрсдэлийг бууруулахад хүн бүрийн үүрэг оролцоо чухал. Иймд гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд оролцогч бүх талууд ялангуяа иргэний нийгмийн байгууллага, шинжлэх ухаан судалгааны байгууллага, бизнесийн болон хувийн хэвшлийн байгууллага Улс орны гамшгийг даван туулах чадавхыг бий болгоход ихээхэн оролцоотой. Оролцогч талуудын 2015 оноос хойш хэрэгжүүлсэн санал санаачилга, судалгаа, техник технологи, инновац, ололт, хүндрэл бэрхшээл, цаашид талуудын анхаарах бүх арга хэмжээг энэхүү дунд хугацааны тайлан илтгэлд тодорхойлон оруулж байгаа гэдэгт эргэлзэхгүй байна. Ази, Номхон далайн бүсийн гамшгийн эрсдэлийг бууруулах, түншлэл хамтын ажиллагааг бэхжүүлэхэд Монгол Улсын Засгийн газар бүс нутгийн Улс орнуудтай цаашид ч бүх талаар хамтран ажиллахдаа таатай байх болно” гэсэн юм.



Зураг 2. Австралийн Холбооны Улс Брисбен хот

3. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын “Хил орчмын ой, хээрийн гал түймэртэй тэмцэх талаар хамтран ажиллах тухай” хэлэлцээрийг 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдөр БНХАУ-ын Бээжин хотноо шинэчлэн баталлаа.



Зураг 3. Бүгд Найрамдах Хятад Ард Улс Бээжин хот

Тус хэлэлцээрийг:

- Хэлэлцээрийг анх байгуулахад үйл ажиллагаа явуулж байсан Монгол Улсын Иргэний хамгаалалтын газар нь 2004 оноос эхлэн Онцгой байдлын ерөнхий газар болж үйл ажиллагааны хамрах хүрээ, чиглэл өргөжсөн бол БНХАУ-ын Ойн аж ахуйн газар нь Ойн улсын хороо болж өөрчлөгдсөн;
- Хэлэлцээрийг байгуулах үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Галын аюулгүй байдлын тухай хууль 2015 оны 07 дугаар сарын 02-ны өдөр шинэчлэгдэн батлагдсан;
- Ой, хээрийн гал түймэр унтраах техник тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн тусламжийг шуурхай нэвтрүүлэх шаардлагатай болсон;
- Ой, хээрийн гал түймэр унтраах үйл ажиллагаанд тусламж үзүүлэхээр ирсэн алба хаагчдыг гал түймэр гарсан газар, орны хилийн тэмдэгтээр Улсын хил нэвтрүүлэх асуудал тодорхойгүй байсан;
- Монгол Улс болон БНХАУ-ын ижил төстэй байгууллагууд ой, хээрийн гал түймрийн сансрын хиймэл дагуулын зургийг цаг алдалгүй гаргаж өгөх асуудлыг нарийвчлан тусгаж өгөх шаардлагатай болсон;
- Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газрууд ой, хээрийн гал түймэрт хяналт тавих зорилгоор хил орчмын бүсэд харилцах цэгүүдийг байгуулж, холбоо барих арга замаа харилцан мэдээлэх. Харилцах цэгүүдийг хэрхэн хаана байгуулах зэрэг нөхцөл байдал үүссэн зэрэг шалтгааны үндсэн дээр шинэчлэн баталсан байна.

4. Гамшгаас хамгаалах болон аюулгүй байдлын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Дотоод хэрэг, үндэсний аюулгүй байдлын яам хоорондын “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр байгууллаа.

5. Онцгой байдлын ерөнхий газар, Оросын Холбооны Улсын Онцгой байдлын яамны Бүгд Найрамдах Тува Улс дахь Ерөнхий газар хоорондын

“Гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, тэдгээрийн үр дагаврыг арилгах талаар 2023 онд хамтран ажиллах төлөвлөгөө”-г байгуулах ажлын уулзалтыг Увс аймгийн Онцгой байдлын газарт 2022 оны 08 дугаар сард зохион байгууллаа. Талууд ирэх 2023 онд хамтран хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөгөө хэлэлцэн, “Гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, тэдгээрийн үр дагаврыг арилгах талаар 2023 онд хамтран ажиллах тухай төлөвлөгөө”-д гарын үсэг зурав.



Зураг 4. Увс аймгийн Онцгой байдлын газар

6. Бүгд Найрамдах Узбекистан Улсын Самарканд хотноо 2022 оны 10 дугаар сарын 01-04-ний өдрүүдэд зохион байгуулагдсан аврагч, гал сөнөөгчдийн 17 дахь удаагийн насанд хүрэгчдийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд 13 хүний бүрэлдэхүүнтэй Монгол Улсын шигшээ баг амжилттай оролцлоо. Гал унтраах техникийн олон төрөлт спортын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээний дүнгээр Монгол Улсын баг тамирчид 11 багаас тавдугаар байрт шалгарсан. Тус тэмцээнд нэгдүгээр байрт Бүгд Найрамдах Беларусь улс, хоёрдугаар байрт Оросын Холбооны Улс, гуравдугаар байрт Бүгд Найрамдах Узбекистан Улс тус тус орсон байна.



Зураг 5. Монгол Улсын шигшээ багийн бүрэлдэхүүн

### 1.3.2. Онцгой байдлын байгууллагад хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

2022 онд онцгой байдлын байгууллагад 7 төсөл, хөтөлбөр хэрэгжиж байна. Үүнд:

1. Онцгой байдлын байгууллагад агаараас аврах ажиллагаа явуулах нэгж байгуулах, нисдэг тэрэг, гал унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэх төсөл 2020–2023 онд Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг үндэслэн тус төслийг амжилттай хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд Онцгой байдлын байгууллагад Евро стандартын дагуу Айрбус ЕС-145 маркийн нисдэг тэрэг болон сургалтын Кабри-С нисдэг тэрэг бүхий агаараас эрэн хайх, аврах ажиллагааны нэгжийг байгуулж нисгэгч, инженер-техникийн ажилтан, аврагч нарыг бэлтгэж байна. Эхний ээлжинд нийлүүлэгдсэн 2 нисдэг тэрэг нь угсралт, засварын үйлчилгээ хийгдэж 2022 оны 6 дугаар сараас эрэн хайх, аврах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж, давхардсан тоогоор 15 аймаг, сумын нутаг дэвсгэрт 37 удаагийн ослын дуудлагаар нислэг үйлдэж, 50 хүнийг эрүүл мэндийн байгууллагад хүргэж, амь насыг нь авран хамгаалсан бол төслийн хүрээнд нийлүүлэгдэх 3 дахь нисдэг тэрэг 2022 оны 12 дугаар сард Монгол Улсад нийлүүлэгдсэн. Мөн төслийн хоёрдахь хэсгийн хүрээнд Бүгд Найрамдах Франц Улсад үйлдвэрлэгдсэн химийн болон нефтийн бүтээгдэхүүний гал түймэр унтраах тусгай зориулалтын 42 нэгж тусгай зориулалтын автомашиныг бүрэн хүлээн авч Онцгой байдлын төв орон нутгийн газар, хэлтсүүдэд хуваарилан үүрэг гүйцэтгэж байна. 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Дархан хотод байрлах газрын тосны бүтээгдэхүүний нөөцлүүр саванд гарсан гал түймрийг унтраах ажиллагаанд төслийн хүрээнд нийлүүлэгдсэн хөөсөөр гал түймэр унтраах автомашин голлох үүргийг гүйцэтгэн ажилласан юм.



Зураг 6. 42 нэгж автомашин

Монгол Улсын Онцгой байдлын байгууллагад агаараас аврах ажиллагаа явуулах нэгж байгуулах, нисдэг тэрэг, гал унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэх” төсөл

2. Гамшгийн эрсдэлийн үнэлгээг сайжруулах, Гамшгийн тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэх болон Гамшгийн эрсдэлийн даатгалын тогтолцоог хөгжүүлэх зорилгоор Онцгой байдлын ерөнхий газраас Азийн хөгжлийн банктай хамтран “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ, төлөвлөлт болон эрсдэл шилжүүлэх чадавхыг бэхжүүлэх



техникийн туслалцааны төсөл”-ийг 2020 оноос хэрэгжүүлж байна.

Монгол Улсад зонхилон тохиолддог гамшгийн 10 төрлөөр гамшгийн аюул, өртөнг, эмзэг байдал, эрсдэлийн зураглалыг боловсрууллаа. Уг зураглал нь гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг төлөвлөх, хөгжлийн төлөвлөлтөд тусгах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, иргэд, олон нийтийн гамшгийг даван туулах чадавхыг бэхжүүлэхэд ач холбогдолтой юм. Мөн Гамшгийн эрсдэлийг хуваалцах, эрсдэлийг шилжүүлэх санхүүгийн арга хэрэгслийг өргөжүүлэхээр суурь судалгааг хийж, “Гамшгийн эрсдэлийн даатгалын тухай хууль”-ийн төслийг боловсруулж байна.



“Монгол Улсын Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх төслийн 2 дугаар үе шат” (2022-2026)

1. Барилга байгууламжийн газар хөдлөлтийн тэсвэржилтийн норм дүрмийг боловсронгуй болгох,
2. Боловсон хүчнийг чадавхжуулж, ур чадварыг дээшлүүлэх



“Монгол Улсад Гамшгийн зарлан мэдээллийн нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх” төсөл (2023-2028)

1. Үндэсний хэмжээнд гамшгийн аюулыг зарлан мэдээлэх нэгдсэн систем байгуулах,
2. Гамшгаас урьдчилан сэргийлэхэд онцгой байдлын байгууллага болон бусад оролцогч талууд, иргэд, олон нийтийн чадавхыг бэхжүүлэх.

3. Монгол Улсын Засгийн газар болон Япон Улсын Засгийн газрын “Эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн буцалтгүй тусламж” хөтөлбөрийн хүрээнд хүчилтөрөгчийн аппарат, зүрхний үйл ажиллагааг хянах төхөөрөмж зэрэг шаардлагатай бүх техник хэрэгслээр бүрэн тоноглогдсон туулах чадвар сайтай Ниссан Патрол маркийн 7 автомашин нийлүүлэгдлээ. Төслийн үр дүнд гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтын бүсэд цаг алдалгүй түргэн шуурхай хүрэлцэн очиж эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэх, осолдож, бэртэж гэмтсэн иргэдийн амь насыг аврах, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх бэлтгэл, бэлэн байдал дээшилж байна.

4. “Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн 2 дугаар шатыг Онцгой байдлын ерөнхий газар Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага/ЖАЙКА/-тай хамтран 2022-2026 онд хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Төсөл хэрэгжсэнээр барилга байгууламжийг хүчитгэх хэрэгцээ, шаардлагыг олон нийтэд таниулах,

холбогдох дүрэм, зааврыг боловсруулах, инженер техникийн ажилтнуудын чадавхыг дээшлүүлэх, иргэдийн гамшгаас хамгаалах чадавхыг дэмжих, гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх талаар сургалтын орчинг сайжруулах зэрэг үр дүнд хүрэх юм.

5. Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газрын санхүүжилттэй “Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй орон нутаг” төслийг 2022 оноос Онцгой байдлын ерөнхий газар Дэлхийн Зөн олон улсын байгууллагатай хамтран нийслэл болон 5 аймагт хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд уур амьсгалаас үүдэлтэй гамшигт үзэгдлийн нөлөөллийг бууруулах, төсөл хэрэгжиж буй аймгуудын онцгой байдлын газрын тоног төхөөрөмжийг сайжруулах, гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр “Бэлэн бай” сургагч багш бэлтгэх зэрэг ажлуудыг хэрэгжүүлж байна.

6. Онцгой байдлын ерөнхий газраас Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 2020-2022 онд “Монгол Улсад Гамшгийн зарлан мэдээллийн нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх нь” техникийн туслалцааны төслийг хэрэгжүүлсэн. Монгол Улсын 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний төсөл, төсвийн хүрээний мэдэгдэлд төслийн хоёрдугаар шатыг хэрэгжүүлэх саналыг тусгаж, жагсаалтад оруулаад байна. Мөн төслийг хэрэгжүүлэх зээлийн хэлэлцээрийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан батлуулахаар төлөвлөн саналаа холбогдох байгууллагуудад хүргүүлээд байна. Төсөл хэрэгжсэнээр үндэсний хэмжээнд гамшгийн аюулыг зарлан мэдээлэх нэгдсэн системтэй болж, гамшгаас урьдчилан сэргийлэх чадавх дээшлэх юм.

7. Монгол-Австрали хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойн хүрээнд Австрали Улсын Засгийн газар, Австралийн хөгжлийн хамтын ажиллагааны төсвөөс эрүүл мэнд, хүний эрх, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, гамшгаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, боловсрол, хөдөө аж ахуй гэсэн чиглэлд төсөл хөтөлбөр хэрэгжихээр зарлагдсан байна. Уг төсөл, хөтөлбөрийн сонгон шалгаруулалтад Онцгой байдлын байгууллагаас боловсруулсан “Онцгой байдлын байгууллагын анги, салбаруудад жишиг сургалтын танхим байгуулах төсөл” шалгаран нийт 100,000 Австрали долларын хөрөнгө оруулалт бүхий тоног төхөөрөмжийг 2022 оны 7 дугаар сарын 06-ны өдөр хүлээн авч, төслийн хүрээнд НОБГ-ын “Гамшгаас хамгаалах сургалт, аргазүйн төв”-д явуулын сургалт хийх зориулалттай бага оврын сургалтын автомашиныг хүлээлгэн өгчээ. Мөн Дархан-Уул, Булган, Увс аймгийн Онцгой байдлын газруудад жишиг сургалтын танхимын тоног төхөөрөмж, техник хэрэгслийг гардуулан өгөв.

## 1.4. ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН ЧАДАВХ

### 1.4.1. Онцгой байдлын байгууллагын бүтэц, зохион байгуулалтын бэхжилт

Засгийн газрын 2020 оны 163 дугаар тогтоолоор Говь-Алтай, Увс, Завхан, Архангай, Дундговь аймгуудад Эрэн хайх, аврах бүлгүүд, Булган, Говь-Алтай аймгуудад Эрэн хайх, аврах салбарууд, Төв аймаг, нийслэлийн Баянзүрх дүүрэгт Гал түймэр унтраах, аврах 4-р зэрэглэлийн анги зэрэг 9 анги, салбар, бүлгийн үйл ажиллагааг эхлүүлээ.



Мөн олон улсын хэмжээнд өрсөлдөх чадвартай, шинжлэх ухаан, туршилт судалгаа, инновацид суурилан гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор ОБЕГ-ын дэргэдэх Гамшиг судлалын хүрээлэн нь Гамшиг судлалын үндэсний хүрээлэн боллоо.

Монгол Улсын Шадар сайдын 2022 оны “Албан тушаалын төрөл, ангилал, зэрэглэл, цолны зэрэглэл батлах тухай” мн/04 дүгээр тушаалаар Онцгой байдлын байгууллагын төрийн тусгай албан тушаалын төрөл, ангилал, зэрэглэл, цолны зэрэглэл шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан төв, орон нутаг дахь Улсын нөөцийн анги, салбар, цэгийн төрийн үйлчилгээний 300 гаруй албан хаагчдыг төрийн тусгай албан хаагч болгов.

### 1.4.2. Бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийн талаар

Онцгой байдлын байгууллагаас 2022 онд Гадаад Улс оронд зохион байгуулагдсан 9 удаагийн айлчлалд 26 алба хаагч, 17 удаагийн хурал, зөвлөгөөн, уулзалт, сургалт, семинар, үзэсгэлэн, яармагт 61 алба хаагч, нийт 87 алба хаагчид хамрагдсан байна.

## МЭРГЭЖИЛ ОЛГОХ, МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТ



Хүний нөөцийг бүрдүүлэх, алба хаагчдын чадавх, мэдлэг боловсролыг дээшлүүлэх хүрээнд ДХИС-ийн Удирдлагын академийн докторын сургалтад 1 алба хаагч, ДХИС-ийн Удирдлагын академид 4 алба хаагч, ҮБХИС-ийн Удирдлагын академид 6 алба хаагч, Онцгой байдлын сургуульд нийт 480 сонсогч тус тус суралцаж байна.

Дотоод хэргийн их сургуулийн Ахлагчийн сургуульд Аврагч гал сөнөөгч, Гал унтраах автомашины жолооч, холбооны бага мэргэжилтэн зэрэг мэргэжлүүдээр 315 сонсогч суралцаж төгссөн.

Мөн гадаад улсад нийт 83 алба хаагч суралцаж байгаагаас ОХУ-Иргэний хамгаалалтын академи, Гал эсэргүүцэх албаны академи, Санкт Петербург хотын Гал эсэргүүцэх албаны их сургуульд 62 сонсогч, Польш улсын Цэргийн урлагийн академид-3, Унгар-3, Туркад-2, Японд-2, Солонгост-8 алба хаагч тус тус суралцаж байна.

Алба хаагчдыг мэргэшүүлэн, мэргэжлийн үр чадварыг дээшлүүлэх зорилгоор төрөл мэргэжлийн 29 сургалтад 2.145 алба хаагч, мэргэшүүлэх, мэргэжил олгох 7 сургалтад 849 алба хаагч, Олон улсын хамтарсан 13 сургалтад 235 алба хаагч, нийт 49 сургалтад 3229 алба хаагчийг хамруулсан байна.

**2022 ОНД ХИЙГДСЭН ТОМООХОН СУРГАЛТ:**  
**“Говийн чоно-2022” гамшгийн хор уршгийг арилгах**  
**олон улсын хамтарсан дадлага сургууль**

“Говийн чоно-2022” олон улсын сургалт, дадлага сургууль зохион байгуулах тухай Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2022 оны А/210 дугаар тушаалын дагуу Онцгой байдлын ерөнхий газар, АНУ-ын Элчин сайдын яам, Энэтхэг-Номхон далайн Хуурай цэргийн командлал болон Аляскийн Үндэсний гвардтай хамтран “Газар хөдлөлтийн гамшгийн хор уршгийг арилгах, хариу

**арга хэмжээ”** сэдвийн хүрээнд Академик сургалт, команд штабын дадлага, нурангиас эрэн хайх аврах ажиллагаа, Химийн хортой бодис алдагдах үеийн хариу арга хэмжээ, гамшгийн үеийн 2 дугаар шатлалын хээрийн хөдөлгөөнт эмнэлэг дэлгэх үйл ажиллагаа, Нисдэг тэргээр агаараас аврах ажиллагаа зэрэг таван төрлөөр 2022 оны 9 дүгээр сарын 05-10-ны өдрүүдэд Баянхонгор аймагт зохион байгууллаа.

Дадлага сургуульд Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Эрүүл мэндийн яам, Барилга хот байгуулалтын яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Онцгой байдлын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Одон орон геофизикийн хүрээлэн, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг, Монголын Улаан загалмай нийгэмлэг, Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага, Үндэсний аврах бригад, Агаараас эрэн хайх, аврах 111, Давтан сургалт сэргээн заслын төв-113 дугаар анги, Ар тал 115, нийслэлийн Онцгой байдлын газрын Аврах анги, Өмнөд болон хойд бүсийн аймгуудын Онцгой байдлын газрын алба хаагчид болон АНУ, Шинэ Зеланд, Бангладеш, Непал, Вьетнам, Тайланд, Англи, Шри Ланка зэрэг гадаадын улс орноос төлөөлөгчид оролцжээ.

Энэ удаагийн дадлага сургуульд гамшгийн үеийн 2 дугаар шатлалын хээрийн эмнэлгийг орон нутагт анх удаа бүрэн дэлгэж, АНУ-ын сургагч багш нартай хамтран гамшгийн голомтоос нэрвэгдэгчийг нисдэг тэргээр дараагийн шатлалын эмнэлэг рүү тээвэрлэх, агаараас аврах ажиллагааг зохион байгуулж дадлага хийлгэсэн нь онцлог байлаа.

#### **“Уул, хаданд эрэн хайх, аврах ажиллагаа”-ны хамтарсан сургалт**

ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригад, Уул уурхайн аврах анги, Агаараас эрэн хайх, аврах ангиуд хамтран “Уул, хаданд эрэн хайх, аврах ажиллагаа”-ны сургалт, бэлтгэлийг Налайх дүүргийн VI хороо Тэрэлжийн “Бүүвэйт” хаданд аравдугаар сарын 31-нээс 11 дүгээр сарын 03-ны өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтад харьяа, анги байгууллагуудын нийт 40 гаруй алба хаагч хамрагдаж, эгц ханан хадруу авирах, буух, өндрөөс нэрвэгдэгчдийг буулгах, ачаа хөнгөлж татах зэрэг дадлагыг хийсэн байна.



Зураг 7. “Уул, хаданд эрэн хайх, аврах ажиллагаа”-ны хамтарсан сургалт

### Гал түймэр унтраах, аврах ангийн алба хаагчдын сургалт

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хооронд байгуулсан Иргэний аюулгүй байдлын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийн хүрээнд НОБГ-ын Гал түймэр унтраах, аврах ангийн алба хаагчдын сургалтыг 2022 оны 10 дугаар сард зохион байгууллаа. Сургалтаар Бүгд Найрамдах Франц Улсаас нийлүүлэгдсэн үйлдвэрийн гал түймэр унтраах автомашинуудыг оролцуулан Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Петровис трейдинг” ХХК-ийн газрын тосны бүтээгдэхүүний агуулахад гарсан гал түймрийг унтраах тактикийн дадлагыг зохион байгуулжээ.



Зураг 8. Гал түймэр унтраах, аврах ангийн алба хаагчдын сургалт

### ОХУ-ын Онцгой байдлын яамны байгалийн эрэн хайх, аврах отрядтай хамтарсан гүний усны шумбалтын дадлага

Онцгой байдлын ерөнхий газраас ОХУ-ын Байгалийн эрэн хайх, аврах отрядтай хамтран “Гүний усны шумбалтын дадлага, сургууль”-ийг 2022 оны 9 дүгээр сард зохион байгууллаа. Тус сургалтад ОБЕГ, ОХУ-ын Байгалийн эрэн хайх, аврах отряд, Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Үндэсний аврах бригад, Орхон, Архангай, Булган, Сэлэнгэ, Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газрын 30 орчим алба хаагч хамрагдлаа.



Зураг 9. Гүний усны шумбалтын дадлага, сургууль

### **Гал түймэр унтраах зориулалтын автомашины ашиглалт, автомеханик шатны засвар үйлчилгээний сургалт, дадлага**

Онцгой байдлын ерөнхий газраас БНФУ-ын “Десотел” ХХК-ийн мэргэжилтнүүдтэй хамтран “Рино” загварын хөөсөөр гал түймэр унтраах зориулалтын автомашины ашиглалт, автомеханик шатны засвар үйлчилгээний сургалт, хээрийн дадлагыг 2022 оны 9 дүгээр сард зохион байгууллаа.

“Рино” загварын хөөсөөр гал түймэр унтраах зориулалтын автомашин нь Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд хэрэгжиж байгаа “Онцгой байдлын байгууллагад агаараас аврах ажиллагаа явуулах нэгж байгуулах, нисдэг тэрэг, гал унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэх” төслөөр нийлүүлэгдсэн юм.



Зураг 10. Зураг. Гал түймэр унтраах зориулалтын автомашины ашиглалт, автомеханик шатны засвар үйлчилгээний сургалт, хээрийн дадлага

### **Тогтмол уснаас болон өндөр уулнаас эрэн хайх, аврах ажиллагааны сургалт**

Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газраас АНУ-ын ЭСЯ-ны Иргэн цэргийн дэмжлэгийн бүлэгтэй хамтран ахисан түвшний “Тогтмол уснаас болон өндөр уулнаас эрэн хайх, аврах ажиллагаа” сэдэвт онолын болон дадлагын



сургалтыг 2022 оны 8 дугаар сарын 02-13-ны өдрүүдэд Толбо нуур, Ховд голд зохион байгууллаа.

АНУ-ын Иргэний цэргийн дэмжлэгийн бүлгийн сургагч багш нар удирдан явуулсан тус сургалтад Баян-Өлгий, Ховд, Увс, Завхан, Говь-Алтай аймгийн 11 алба хаагч хамрагдаж, гэрчилгээгээ гардан авсан юм.



Зураг 11. “Тогтмол уснаас болон өндөр уулнаас эрэн хайх, аврах ажиллагаа”-ны сургалт

### Эрэлч нохой хөтлөгчдийн сургалт

ОБЕГ-ын харъяа Үндэсний аврах бригадын эрэлч нохойн сургалтын албанаас төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын нохой хөтлөгчдийн давтан сургалтыг зохион байгууллаа.

Аврагч нохой хөтлөгчийн үр чадварыг дээшлүүлэх, албаны эрэлч нохойн эрэн хайх, аврах ажиллагааны чадварыг нэмэгдүүлэх зорилготой сургалтад Архангай, Хэнтий, Сэлэнгэ, Өмнөговь, Орхон, Өвөрхангай, Булган, Төв аймгийн нийт 10 алба хаагч хамрагдлаа.



Зураг 12. Эрэлч нохой хөтлөгчийн сургалт

### Гүний шумбалт хийх хамтарсан дадлага сургуулилт

Үйлдвэрийн осол, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийн үр дагаврыг арилгах” салбарт хамтран ажиллах тухай Монгол-Оросын хамтарсан комиссын XVIII дугаар хурлын үеэр батлагдсан 2022-2023 онд хамтран ажиллах төлөвлөгөөний дагуу 2022 оны 02 дугаар сарын 28-наас 03 дугаар сарын 03-ны өдөр Эрхүү мужид өвлийн улиралд гүний шумбалт хийх хамтарсан дадлага сургуулилтад Монгол Улсын Онцгой байдлын байгууллагаас Үндэсний аврах бригадын захирагч, хурандаа Д.Намсрайгаар ахлуулсан 10 алба хаагч оролцож туршлага солилцлоо.

Алба хаагчид 10 хүртэлх метрийн гүнд шумбахад тулгарсан бэрхшээлийн талаар харилцан туршлага солилцсоны үндсэн дээр нууранд 25 хүртэлх метрийн гүнд хамтарсан шумбалт хийж гүйцэтгэлээ.





Зураг 13. Оросын Холбооны Улс Байгаль нуурт хийсэн усны дадлага сургалт

### **ОХУ-ын Онцгой байдлын яамтай хамтарсан штабын дадлага, сургалт**

Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын “Үйлдвэрлэлийн осол, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийн хор үршгийг арилгах салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр, Монгол-Оросын хамтарсан комиссын 18 дугаар хуралдааны 3 дугаар хавсралт, ОБЕГ, ОХУ-ын Онцгой байдлын яам хоорондын 2022-2023 оны хамтын ажиллагааны төлөвлөгөөний 2 дугаар хэсэгт заасан “Хил орчмын бүс нутгуудад гарсан ой, хээрийн түймрийн үед ОБЕГ, ОХУ-ын Онцгой байдлын яам хооронд авах хариу арга хэмжээний штабын дадлага, сургалт”-ыг 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгууллаа.

Тус штабын дадлага, сургалтад ОБЕГ-ын Гал түймэртэй тэмцэх газар болон Шуурхай удирдлага зарлан мэдээллийн төвийн алба хаагчид хамрагдлаа. Штабын дадлага сургалтаар алба хаагчид хил орчмын бүс нутгуудад гарсан ой, хээрийн гал түймрийн үед цаг алдалгүй оновчтой хариу арга хэмжээ авч, мэдээллийг боловсруулан, удирдлагыг мэдээ мэдээллээр шуурхай хангах, хоёр Улсын хооронд харилцан дамжуулах дадлагаар мэдлэг чадвараа нэмэгдүүлээ.



Зураг 14. Шуурхай удирдлага зарлан мэдээллийн төв

### Техникийн аврах ажиллагааны олон улсын сургалт

Аврах ажиллагааны сүүлийн үеийн дэвшилтэт техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, тэдгээрийн ажиллагаа, арга зүйгээс суралцах, дэлхийн олон орны аврагчидтай туршлага солилцох, техникийн дэмжлэг үзүүлэх “Аврагчийн өдөр” олон улсын сургалт Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Падерборн хотноо 2022 оны 10 дугаар сарын 05-12-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Тус сургалтад Онцгой байдлын байгууллагын 10 алба хаагчид оролцож, аврах ажиллагааны талаар туршлага солилцсон байна.



Зураг 15 Холбооны Бүгд Найрамдах Герман Улс Падерборн хот

### Авран хамгаалах, тусгай үүргийн болон сургалт, дадлагын нислэгүүдийг үйлдэв

Монгол Улсын Засгийн Газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн Газар хооронд байгуулсан санхүүгийн хэлэлцээрээр “Онцгой байдлын албанд агаараас эрэн хайх, аврах ажиллагааны нэгж байгуулах, нисдэг тэрэг нийлүүлэх төсөл” хэрэгжиж, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 163 дугаар тогтоолоор Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Агаараас эрэн хайх, аврах 111 дүгээр анги байгуулагдаж, иргэдийн амь насыг авран хамгаалах, тусгай үүргийн болон сургалт, дадлагын нислэгүүдийг үйлдэж байна. Үүнд:

Бүгд Найрамдах Франц Улсын Иргэний хамгаалалтын газрын аврах ажиллагааны мэргэжилтнүүдтэй хамтран агаараас аврах ажиллагааны мэргэжилтэн, аврагч, яаралтай тусламжийн багийг бэлтгэх сургалт”-ыг Тэрэлж, Буянт-Ухаа бүсэд 2022 оны 04 дүгээр сарын 14-19-ний өдрүүдэд;

Онцгой байдлын ерөнхий газар, Бүгд Найрамдах Франц Улсын “Хэли-Юнион” компанитай байгуулсан гэрээнд заасан аврах ажиллагааны мэргэжилтэн, аврагч, яаралтай тусламжийн багийг бэлтгэх сургалтын хөтөлбөрийндагуу “Тогтмол болон үрсгал уснаас эрэн хайх, аврах ажиллагааны дадлага сургууль”-ийг Үндэсний аврах бригад, Нийслэлийн аврах ангийн алба хаагч, Бүгд Найрамдах Франц Улсын Иргэний хамгаалалтын газрын аврах ажиллагааны мэргэжилтнүүдтэй хамтран Тэрэлж, Сонсголонгийн бүсүүдэд

2022 оны 09 дүгээр сарын 19-23-ны өдрүүдэд;

Өвөрхангай аймгийн Арвайхээр суманд хээрийн гаралтаар Аврах ажиллагаа, шүхрийн буултын дадлага, сургалтыг 2022 оны 07 дугаар сарын 22-29-ний өдрүүдэд;

Үндэсний аврах бригадтай хамтран шүхэрчин-аврагчдын дадлага сургуулийг Төв аймгийн Батсүмбэр сумын нутаг дэвсгэрт;

Уул уурхайн аврах 09 дүгээр ангитай хамтран аврах ажиллагааны дадлага сургуулийг Буянт-Ухаа бүсэд нислэг, нислэгийн аюулгүй байдлыг ханган тус тус зохион байгуулж, гамшгийн үед харилцан ажиллах, холбоо зохион байгуулах боломжийг бүрдүүлж, алба хаагчдын мэргэжлийн үр чадвар, сэтгэл зүйн чадварыг дээшлүүлээ.

#### **1.4.3. Техник хэрэгсэл, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт**

2022 онд гамшгаас хамгаалах техник, хэрэгслийн чадавхыг бэхжүүлэх зорилгоор төв орон нутгийн Онцгой байдлын байгууллагын хэмжээнд хүний нөөц, хувцас хангалт, архив, эд хөрөнгө бүртгэлийн нэгдсэн программуудыг шинээр нэвтрүүлэн хэрэгжүүллээ.

Мөн албаны бэлтгэл бэлэн байдлыг сайжруулах зорилгоор тусгай зориулалтын чингэлэгтэй болон ачааны нийт 21 тээврийн хэрэгсэл, 27 төрлийн нийт 2628 ширхэг өндрөөс аврах ажиллагааны туслах хэрэгсэл 2 төрлийн агаараас эрэн хайх аврах ажиллагаанд ашиглагдах шүхэр, шүхрийн дагалдах хэрэгсэл, хорт хий илрүүлэгч багаж, маск, амьсгалын бие даасан төхөөрөмж, 13700 литр гал унтраах хөөс үүсгэгч бодис, 3 төрлийн 720 ширхэг галын хоолой, 19 төрлийн гал түймэр унтраахад хэрэглэгдэх дагалдах багаж хэрэгслийг худалдан авч, төв, орон нутгийн онцгой байдлын анги байгууллагуудад хуваариллаа.

#### **Гадаад улсын засгийн газрын нөхцөлт зээлийн хүрээнд:**

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийн дагуу “Онцгой байдлын байгууллагад гал унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэх төсөл” хэрэгжиж байна. Үүнд:

Хөөсөөр гал түймэр унтраах зориулалтын 3 нэгж автомашиныг 2022 онд хүлээн авч нийт 14,985,000 еврогийн өртөг бүхий 4 нэр төрлийн 42 нэгж гал түймэр унтраах тусгай тоноглол бүхий автомашиныг нийлүүлэх “Онцгой байдлын байгууллагад агаараас аврах ажиллагаа явуулах нэгж байгуулах, нисдэг тэрэг, гал унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлж дуусав. Энэхүү төсөл хэрэгжсэнээр Онцгой байдлын байгууллагын Гал түймэр унтраах зориулалтын автомашины хангалт 60 орчим хувьд хүрэв.

2022 онд Онцгой байдлын албаны бэлтгэл, бэлэн байдал, чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор Япон Улсын Засгийн газраас 6 ширхэг түргэн

тусламжийн иж бүрэн тоноглогдсон ланд крусер Y-61 маркийн автомашины буцалтгүй тусламж үзүүлсэн. Тус ланд крусер Y-61 маркийн түргэн тусламжийн иж бүрэн автомашиныг төв, орон нутгийн Онцгой байдлын газар хэлтсүүдэд хуваарийн дагуу олгосон болно.

### Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хүрээнд:

МУ-ын Засгийн газрын 2021 оны 163 дугаар тогтоолоор тус онд шинээр Онцгой байдлын албанд 9 Гал түймэр унтраах аврах анги, Эрэн хайх аврах анги, салбар, бүлгийг байгуулан үйл ажиллагааны зардалд 3.2 тэрбум төгрөг, барилгын үйл ажиллагааг эхлүүлэхэд шаардагдсан засварын ажилд 315.9 сая төгрөгийг шийдвэрлэн салбар, бүлгийн үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлж байнгын ажиллагаанд оруулан ажиллалаа.

Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтсийн барилга байгууламжийн өргөтгөлийн ажилд шаардлагатай 230 сая төгрөгийг шийдвэрлэжээ.

Нийслэлийн онцгой байдлын газар, тус газрын Чингэлтэй дүүргийн онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах, аврах 10 дугаар ангийн барилга угсралтын ажлыг 21.7 тэрбум төгрөгийн Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020-2022 оны хооронд гүйцэтгэж Улсын комисст хүлээлгэн өгч, ашиглалтад оруулжээ.

### Тэмцээн уралдаан

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит “Марш-тусгай бэлтгэлийн цогцолбор-2022” тэмцээнд Онцгой байдлын байгууллагын эрэгтэй баг тамирчид мөнгөн медаль хүртлээ. Ингэснээр Онцгой байдлын байгууллагын алба хаагчид 2013 онд хүртсэн мөнгөн медалиа ихэрлүүлж, амжилтаа бататгасан юм.



Зураг 16. Эрэгтэй баг тамирчид



Зураг 17. Эмэгтэй баг тамирчид

Харин Онцгой бүсгүйчүүдээ түүчээлэн анх удаагаа тус тэмцээнд оролцсон эмэгтэй тасгийн бүрэлдэхүүн IV байрт шалгарсан амжилтыг үзүүлж, ирэх жилүүдийн тэмцээн, уралдаанд ширүүн өрсөлдөгчдийн нэг гэдгээ харууллаа.



Зураг 18 Тэргүүний жагсаалч рот болон тэргүүний жагсаалч эгнээ

Ардын хувьсгалын 100, 101 жилийн ой, Монгол Улсын Төрийн далбааны өдөрт зориулсан цэргийн ёслолын жагсаалд Онцгой байдлын байгууллагаас нийт 209 алба хаагч оролцож ЗХЖШ-аас зарласан “Тэргүүний жагсаалч рот болон тэргүүний жагсаалч эгнээ” шалгаруулах уралдаанд эмэгтэй ротын 4-р эгнээ тэргүүлэв.

Онцгой байдлын байгууллагаас 2022 онд Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн нэрэмжит төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын практик буудлагын тэмцээнд гар бууны сүмтэй автомат ГСК эмэгтэй төрөлд дэд байранд нийслэлийн Онцгой байдлын газрын Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтсийн эрсдэлийн удирдлага, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, гутгаар байранд Хойд бүсийн төв Орхон аймгийн Онцгой байдлын газрын дуудлага хүлээн авагч, Карабины стандарт ангиллын багийн төрөлд гутгаар байранд Онцгой байдлын ерөнхий газрын баг тамирчид тус тус шалгарав.



Зураг 19 Практик буудлагын тэмцээн

## 1.5. ГАМШГААС ХАМГААЛАХ СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦ

### 1.5.1. Онцгой байдлын ерөнхий газрын Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн үйл ажиллагаа

ОБЕГ-ын дэргэдэх Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн бүрэлдэхүүнд 2022 оны А163 дугаар тушаалаар өөрчлөлт орж шинэчлэгдэн батлагдав. Тус хурлаар Гамшиг судлал Инноваци сэтгүүлийн редакцын зөвлөл, Сэтгүүлийн ажиллах журмыг боловсруулж ОБЕГ-ын даргын 2022 оны 9 дүгээр сарын 29-ны өдрийн А/251 дугаар тушаалаар батлууллаа.



Зураг 20. Шинжлэх ухаан технологийн зөвлөл

“Гамшиг судлал, Инновац” сэтгүүлийг тус зөвлөл, Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгээс эрхлэн гаргадаг бөгөөд Шинжлэх ухааны академийн Нийгмийн бага чуулганаар хэлэлцүүлж, Гамшиг судлалын ухааны мэргэжлийн сэтгүүлээр бүртгүүлснээр олон улсад бүртгэлтэй эрдэм шинжилгээний албан ёсны сэтгүүл боллоо.

“Гамшиг судлал, инновац” сэтгүүлийн 2022.№1 (8), 2022.№2 (9) дугааруудыг хэвлүүлж, нийтийн хүртээл болгосон.




Зураг 21 “Гамшиг судлал, инновац” сэтгүүл

### 1.5.2. Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгийн үйл ажиллагаа

Гамшиг судлалын үндэсний хүрээлэн нь байгуулагдсан цагаасаа хойш буюу 2005-2022 онд нийт 133 судалгааны ажлыг хийж гамшиг судлалын шинжлэх ухааныг хөгжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Хүснэгт 1. 2005-2022 он хүртэлх Гамшиг судлалын хүрээлэнгийн гүйцэтгэсэн судалгааны ажлын тоо



Тус хүрээлэнгийн 2022 онд хийж гүйцэтгэсэн ажлаас онцлон дурьдвал:

1. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны мн/65 дугаар тогтоолоор Гамшиг судлалын хүрээлэнг Гамшиг судлалын үндэсний хүрээлэн болж батлагдлаа.

2. Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгийн Галын лаборатори нь олон улсын MNS ISO/IEC 17025:2018 “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага” стандартын шаардлагыг хангаж Үндэсний итгэмжлэлийн төвийн төвийн даргын 2022 оны А/87 дугаар тушаалаар “Үндэсний итгэмжлэгдсэн лаборатори”-оор баталгаажлаа. Тус лаборатори нь 2009 оноос хойш 4 дэх удаагаа итгэмжлэгдэж байгаа юм.



Зураг 22. Итгэмжлэлийн гэрчилгээ гардан авлаа


3. Барилга байгууламжийн хийц, бүтээцийг үл эвдэх багаж тоног төхөөрөмж ашиглан лабораторийн сорилт, туршилт хийж барилга байгууламжийн газар хөдлөлтийн тэсвэржилтийн талаар технологийн үр дүнд суурилсан судалгааны ажил хийдэг боллоо.



Зураг 23. Барилга, байгууламжийн газар хөдлөлтийн тэсвэржилтийг хэмжих тоног төхөөрөмж

4. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ий хүрээнд Онцгой байдлын байгууллагын анги байгууллагын хэмжээнд “Тэрбум мод” ухаалаг төхөөрөмжийн аппликейшныг хөгжүүлж хэрэглээнд нэвтрүүлээ.

5. Монгол Улсын Засгийн газрын ухаалаг засаг төслийн хүрээнд нийслэлийн түргэн тусламжийн 70, Гал түймэр унтраах 130 автомашинд байршил тогтоогч (GPS) суурилуулсан юм. Уг ажлын үр дүнг нэмэгдүүлэх зорилгоор “гамшиг, аюулт үзэгдэл, ослын бүртгэл хүч хэрэгслийн хяналтын систем”-ийг хөгжүүлж өдөр тутмын үйл ажиллагаанд нэвтрүүллээ. Энэ систем нь бүртгэл, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт хийхээс гадна хаана ямар төрлийн дуудлага илүү байгааг дүгнэн тухайн чиглэлд эрсдэлийг бууруулах, авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөхөд дэмжлэг үзүүлэх зорилготой юм. [www.vms.nema.gov.mn](http://www.vms.nema.gov.mn)



Зураг 24. “Тэрбум мод” хаалаг төхөөрөмж, “Гамшиг, аюулт үзэгдэл, ослын бүртгэл хүч хэрэгслийн хяналтын систем”



6. Сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилгуудын гал түймрийн эрсдэлийг бууруулах, гал түймрийн шалтгааныг тодорхойлох зорилгоор “Барилгад ашиглагддаг материалын галын аюулын шинж чанар, тэдгээрийн ашиглалтад хийсэн шинжилгээ” сэдэвт судалгааны ажлыг гүйцэтгэж, дүгнэлт, саналыг Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлж Барилга, хот байгуулалтын яамны төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/147 дугаар тушаалаар цаашид барилгын гадна фасадын дулаалгын материалаар хөөсөн полиуретан хавтанг “Цэцэрлэг, сургууль эмнэлгийн барилга, байгууламж”-д ашиглахгүй байх зохицуулалтыг барилгын норм ба дүрэмд тусгуулж шийдвэрлүүлээ. Ингэснээр хүний амь нас, эд хөрөнгийг гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлж, гамшгийн эрсдэлийг бууруулахад чухал алхам тавигдлаа.

7. Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгээс “Усны ослын эрсдэлийн судалгаа” сэдэвт судалгааны ажил гүйцэтгэж ОБЕГ-т хүргүүлээ. Судалгаанд үндэслэж ОБЕГ-ын УСГ-аас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд усны ослоор амь насаа алдсан иргэдийн тоо 2022 онд 30 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

8. Тус хүрээлэн нь 2022 онд дараах 8 судалгааны ажлыг гүйцэтгэж, явцын болон эцсийн тайланг Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн хүлээн авсан байна.

Хүснэгт 2. ГСҮХ-ээс 2022 онд гүйцэтгэсэн судалгааны ажил

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны захиалгат судалгаа	
1	“Нийтийг хамарсан гамшгийн үе дэх улсын нөөцийн чадавх, бэлэн байдлын судалгаа, цаашид авах арга хэмжээний шийдэл, арга зам”
2	“Цөлжилт, хүчтэй салхи, шуурга, зуд, газар хөдлөлт, ой хээрийн түймэр зэрэг байгалийн гамшгийн эрсдэлийн чиг хандлагад үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийн үнэлгээ, таамаглал”
ОБЕГ-ын захиалгат судалгаа	
1	“Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавх”
2	“Монгол Улсын ой, хээрийн түймрийн 2022 оны урьдчилсан таамаглал”
3	“ОББ-ын чадавхын өнөөгийн байдлын судалгаа”
4	“ОББ-ын алба хаагчдын хандлага, ёс зүй, сэтгэл ханамжын судалгаа”
5	“Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлын үеийн удирдлага, зохион байгуулалт, хариу арга хэмжээний туршлага, сургамж, анхаарах асуудал”
6	“Ганд тэсвэртэй буудайн сорт, сорилт, туршилт судалгаа”

Эдгээр судалгааны ажлын дэлгэрэнгүй тайлан, үр дүнгийн талаар Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгийн “Бүтээлийн эмхэтгэл 2022” номноос дэлгэрэнгүй харж болно.

### Лабораторийн туршилт, шинжилгээ

Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгийн Галын болон химийн лаборатори нь сүүлийн 16 жилийн хугацаанд жилд дунджаар аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ирүүлсэн 139 бодис, материалд галын аюулын үзүүлэлтийг тодорхойлсон дүгнэлт, түүнчлэн шүүх, прокурор, мөрдөгчийн тогтоолын дагуу гал түймрийн хэргийн газраас ирүүлсэн 333 дээжинд дүгнэлт, шинжилгээ хийн ажиллаж байна. Түүнээс гадна жилд дунджаар улсын хэмжээнд гарсан томоохон хэмжээний 170 гаруй гал түймрийн шалтгаан нөхцөлийг тодорхойлоход шинжээчээр ажилласан.

Хүснэгт 3. 2006-2022 онд Галын лабораторид ирүүлсэн материалын галын аюулын үзүүлэлтийг тодорхойлуулах хүсэлт болон шинжилгээ хийсэн бүтээгдэхүүний тоо



2022 онда аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн хүсэлтээр ирсэн 244 дээжинд туршилт шинжилгээ хийж, 244 лабораторийн сорилтын дүгнэлт гаргаж, Шүүх цагдаагийн байгууллага, хэрэг бүртгэгч, мөрдөгчийн 128 тогтоолоор 333 дээжинд шинжилгээ хийж, шинжээчийн 128 дүгнэлт гарган ажиллалаа.

Химийн лаборатори нь цагдаагийн газраас “Шинжээч томилж, шинжилгээ хийлгэх тухай” 116 мөрдөгчийн тогтоолын дагуу гал түймрийн хэргийн газраас шинжилгээнд ирүүлсэн 214 дээжийг хүлээн авч, шинжлэн 116 шинжээчийн дүгнэлт гаргасан байна.

2022 онд нэгдсэн дүнгээр 429 албан бичгээр ирүүлсэн 791 дээжинд холбогдох сорилт, шинжилгээг хийж, 429 шинжээчийн дүгнэлт болон лабораторийн сорилтын дүн гарган шийдвэрлэсэн байна.

### Эрдэм шинжилгээний хурал, сургалт

#### “Байгалийн гамшгаас үүсэх эрсдэл, түүний нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл” сэдэвт онол, практикийн бага хурал:

Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Гамшиг судлалын хүрээлэн, Монголын Улаан Загалмай Нийгэмлэгтэй хамтран “Байгалийн гамшгаас үүсэх

эрсдэл, түүний нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл” сэдэвт онол, практикийн бага хурлыг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдөр зохион байгууллаа.

Хурлаар байгалийн гамшгаас үүсэх эрсдэлийн нийгэм-эдийн засагт үзүүлэх нөлөөллийг ойлгох, түүнийг бууруулах, эрсдэлийг хохирол багатай даван туулахад холбогдох талууд хэрхэн хамтран ажиллах талаар нийт 18 эрдэм шинжилгээний өгүүлэл ирүүлснийг хэлэлцэж, онол практикийн бага хурлаас дараах талуудад чиглэсэн 12 зөвлөмжийг гаргалаа. Үүнд:

- Гамшгаас хамгаалах болон Цаг уур, орчны шинжилгээний газарт:
- Монгол Улсын нийгэм, эдийн засгийн асуудал эрхэлсэн

байгууллагуудад:

- Хөдөө аж ахуйн салбар байгууллагууд

Тусхурлаар хэлэлцэгдсэн илтгэл болон ирүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлүүдийг МУЗН, ГСҮХ-ийн хамтран гаргасан “Онол, практикийн бага хурлын эмхэтгэл 2022-2023”-ээс харж болно.



Зураг 25. "Байгалийн гамшгаас үүсэх эрсдэл, түүний нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл" сэдэвт онол, практикийн бага хурал

### **“Гамшгаас хамгаалах бэлэн байдал, тулгамдсан асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал:**

Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгээс “Шинжлэх ухааны ажилтны өдөр”-ийг тохиолдуулан “Гамшгаас хамгаалах бэлэн байдал, тулгамдсан асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг 2022 оны 11-сарын 23-ны өдөр зохион байгууллаа.

Монгол Улсад тохиолдож болзошгүй гамшиг, аюулын сөрөг үр дагаврыг урьдчилан тооцож, хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, хүрээлэн буй орчин, дэд бүтэц, нийгэм-эдийн засгийн аюулгүй, тогтвортой байдлыг хангах зорилгоор авч хэрэгжүүлж байгаа гамшгаас хамгаалах бэлэн байдлын нэгдмэл

удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалтын цогц арга хэмжээ, гамшгийг даван туулах чадавхын өнөөгийн байдлыг тодорхойлох, түүнд тулгамдсан асуудлыг дэвшүүлэн гаргах, сайжруулах арга замын шийдлийг хэлэлцэв.



Зураг 26. Эрдэм шинжилгээний бага хурал

Хуралд оролцогч эрдэмтэн, судлаач холбогдох талуудын бодлого боловсруулагч, мэргэжилтнүүд илтгэл хэлэлцүүлж, санал солилцож, зөвлөмж гаргалаа. Хурлын илтгэл, зөвлөмжийг Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгийн “Судалгааны ажлын эмхэтгэл 2022”-оос харна уу.



Зураг 27. Судалгааны ажлын эмхэтгэл

**“Гамшгийн эрсдэлийг бууруулахад шинжлэх ухаан, технологи, инновацын ололтыг ашиглаж хамтын ажиллагааг дээшлүүлэх” сэдэвт өдөрлөг:**

Онцгой байдлын ерөнхий газар, Гамшиг судлалын үндэсний хүрээлэн, Шинжлэх ухааны академи, Одон орон, геофизикийн хүрээлэн хамтран “Гамшгийн эрсдэлийг бууруулахад шинжлэх ухаан, технологи, инновацын ололтыг ашиглаж хамтын ажиллагааг дээшлүүлэх” сэдэвт өдөрлөгийг 2022 оны 10 дугаар сарын 31, 11 дүгээр сарын 01-ний өдрүүдэд зохион байгууллаа.



Зураг 28. “Гамшгийн эрсдэлийг бууруулахад шинжлэх ухаан, технологи, инновацын ололтыг ашиглаж хамтын ажиллагааг дээшлүүлэх” сэдэвт өдөрлөг

Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд инновац, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, энэ чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, шинжлэх ухааны байгууллагууд, их дээд сургуулиуд туршлага, мэдээлэл солилцож, харилцан хамтын ажиллагааг дээшлүүлэх зорилгын хүрээнд зохион байгуулагдсан өдөрлөгт ШУ-ы Академи, түүний харьяа хүрээлэн болон бусад хүрээлэнгүүд, их дээд сургуулийн төлөөлөл, нийт 23 байгууллага, 60 гаруй төлөөлөгч оролцож, хэлэлцүүлэг явуулсан юм.

Мөн энэхүү өдөрлөгийн хүрээнд гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд шинжлэх ухаан, технологи, инновацын ололт амжилтыг үрдүнтэй ашиглах, шинжлэх ухааны байгууллага их дээд сургуулиуд дээр хийгдэж буй судалгаа туршилтын ажлууд, судалгааны лабораторийн техникийн хүчин чадал, нөөц бололцоог ашиглах боломжийг судлах зорилгоор өдөрлөгт оролцогчид ШУА, их дээд сургууль, бусад холбогдох байгууллагуудаар танилцах аялалыг зохион байгуулжээ.

### “Гамшгийн эрсдэлийг бууруулах санаачилга” сэдэвт арга хэмжээ:

ОБЕГ-ын дэргэдэх Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгээс “Дэлхийн Зөн Монгол” олон улсын байгуулллагатай хамтран “Гамшгийн эрсдэлийг бууруулах шинжлэх ухаанч санаачлага” арга хэмжээ зохион байгууллаа. Энэ хүрээнд эрдэм шинжилгээний өгүүллийн уралдааныг 2 үе шаттай зохион байгуулав. Нэгдүгээр шатны уралдааныг 2022 оны 04 дүгээр сарын 28-ний өдөр, II шатны шалгаруулалтыг 2022 оны 5 дугаар сарын 13-ны өдөр Онцгой байдлын ерөнхий газрын Соёлын төвд нээлттэй зохион байгууллаа.



Зураг 29. “Шинжлэх ухаанч ГЭБ санаачлага” уралдааны үеэр

Уралдаанд Шинэ Монгол Технологийн Дээд сургууль, Барилга, Архитектурын тэнхимийн эрхлэгч Б.Отгонбаярын “Үерийн аюулаас хамгаалах зурвас газрын хил заагийг тодотгон тогтоох асуудал Улаанбаатар хотын баруун уулын системийн жишээн дээр” сэдэвт илтгэл тэргүүлж, өгүүлийг “Гамшиг судлал, инновац” мэргэжлийн сэтгүүлийн 2022 №1 (8) дугаарт хэвлүүлэн нийтийн хүртээл болгов.

### “Гамшгийн эрсдэлийн үнэлгээний мэргэшүүлэх сургалт:

“Гамшгийн эрсдэлийн үнэлгээний мэргэшүүлэх” 3 дахь удаагийн сургалтыг 2022 оны 06 дугаар сард танхимын 70 цаг, дадлага ажлын 40 цаг нийт 110 цагийн багтаамжтай зохион байгуулж, 39 суралцагчдад сертификат гардууллаа.



Зураг 30. Гамшгийн эрсдэлийн үнэлгээний мэргэшүүлэх сургалт

### 1.5.3. Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн үйл ажиллагаа

Их сургуулийн гамшиг судлалын профессорын баг 2022 онд дамжааны магистрантуудын судалгааны ажил, сэдвийн хэлэлцүүлэг, сэдэв батлах, судалгааны ажлын урьдчилсан хамгаалалт зэрэг хурлыг тус тус зохион байгуулж 16 суралцагч магистрийн судалгааны ажлын хэлэлцүүлцгийг зохион байгуулсан.

Тус сургуулийн Гал түймэртэй тэмцэх албаны тэнхимийн ахлах багш, ахмад Л.Булганхангай Монгол Улсын оюуны өмчийн газрын даргын 2022 оны 5 дугаар сарын 30 - ны өдрийн А/69 дүгээр тушаалаар 20-0003434 улсын бүртгэлийн дугаартай “Давхар эргэх” байнгын шатны ашигтай загварын патентын гэрчилгээ гардан авсан.



Зураг 31 “Давхар эргэх” байнгын шатны ашигтай загварын патентын гэрчилгээ

Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургууль нь 2022 онд эрдэм шинжилгээ, судалгааны ажлын хүрээнд гадаад, дотоодын эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлж 2 ном сурах бичиг, 1 орчуулгын бүтээл, 1 түүхийн ном, 5 эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, 3 гамшигын эрсдэл, судлал сэтгүүл, 18 эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл хэвлүүлэн нийтийн хүртээл болголоо.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын нэрэмжит “Грант олгох төсөл”-ийн уралдаанд Гал түймэртэй тэмцэх албаны тэнхимийн эрхлэгч, доктор, дэд хурандаа Б.Энхтүвшин “Монгол Улсын гэмт хэргийн эрсдэлийг тодорхойлох математик загвар” төслөөр “Тэргүүн байр”, Шилдэг бүтээлийн төрөлд хурандаа С.Баттөмөр, дэд хурандаа Б.Энхтүвшин, ахмад Л.Булганхангай нарын бүтээл “Гал түймэр унтраах үйл ажиллагааны удирдлага” сурах бичиг” 3 дугаар байранд тус тус шалгарсан.

Дотоод гадаадын эрдэм шинжилгээний хуралд оролцсон 18 илтгэл,

өгүүллээс XXXII международной научно-практической конференции “Предотвращение. Спасение. Помощь” олон улсын хуралд Оценка знаний, потребностей, установок и практик первичной медицинской помощи слушателей и курсантов УВД Монголии” сэдвээр илтгэл хэлэлцүүлж, ОХУ-н Онц байдлын яамны харьяа Иргэний хамгаалалтын академиас эрхлэн гаргадаг сэтгүүлд илтгэл нийтлүүлээ.



#### 1.5.4. Онцгой тусгай хувцас, хэрэгслийн туршилт үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагаа

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 81 дүгээр зарлигаар баталсан загварын дагуу Онцгой байдлын байгууллагын цэргийн алба хаагчийн дүрэмт хувцасны 21.9 хувийг, тусгай зориулалтын хувцас, хэрэгслийн нэр төрлийн 20 хувийг тус анги үйлдвэрлэж байна.

Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд сайжруулалт хийх зорилгоор 2022 онд Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо ISO 45001:2018 стандартыг үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлжээ.



Зураг 32. ISO стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлээ



ХОЁРДУГААР ХЭСЭГ.

**УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,  
ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ**

## 2.1. ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 2.1.1. Олон нийтэд зориулсан Гамшгаас урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээ

Нэгдсэн арга хэмжээ, өдөрлөгийг зохион байгуулах Монгол Улсын Шадар сайдаар батлагдсан удирдамжийн хэрэгжилтийн хүрээнд гамшгаас урьдчилан сэргийлэх дөрвөн төрлийн аяныг зохион байгууллаа. Тухайлбал,

2022 он гарсаар улсын хэмжээнд Галын аюулгүй байдлын тухай хууль, тогтоомж, гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүй байдлын стандарт, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилт, айл өрхийн пийшин, зуух, яндангийн галын аюулгүй байдлыг хангуулах ажлыг олон нийтэд өргөн хүрээтэй сурталчлан таниулах, объектын гал түймрийн тоо хохирлыг бууруулах зорилгоор **“Аюулгүй галлагаа”**;

“Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр”, “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дуут дохиогоор ажиллах өдөр”-ийг тохиолдуулан газар хөдлөлтийн талаарх ойлголт, газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, газар хөдлөлтийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар иргэд, олон нийтийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх зорилгоор **“Газар хөдлөлтийн аюулыг таниулах аян”**;

Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, сурталчилгааг иргэдэд өргөн хүрээнд хүргэх, улсын хэмжээнд тохиолдож буй усны ослын тоо хохирлыг бодитой бууруулах, бага насны хүүхдүүдэд тавих эцэг, эхийн хараа хяналтыг сайжруулах, иргэдийн сонор сэрэмжийг дээшлүүлэх, мэргэжлийн байгууллагын хамтын ажиллагааг уялдуулан зохион байгуулах зорилгоор **“Үер уснаас үрсээ хамгаалъя”**;

Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг хүргэх зорилгоор **“Алдвал галдана”** аяныг тус тус зохион байгуулсан байна.

Гамшгаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 2022 онд нийт 7 төрлийн нэгдсэн арга хэмжээ, өдөрлөгийг зохион байгуулах удирдамжийг Монгол Улсын Шадар сайдаар батлуулж, хэрэгжилтийг улсын хэмжээнд хангуулан ажиллаа. Үүнд

- Гэр хорооллын айл өрхүүдийн галын аюулгүй байдал, урьдчилан сэргийлэх арга хэмжээ
- Өвөлжилт, хаваржилт хүндрэх болон зудын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ
- Олон улсын Иргэний хамгаалалтын өдөрлөг

- Шар усны үерээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ
- Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөрлөг
- Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ
- Гамшгийн эрсдэлийг бууруулах Олон улсын өдөрлөг

“2022 онд зохион байгуулах нэгдсэн арга хэмжээ, өдөрлөг”-ийн удирдамжийн хүрээнд хийгдсэн ажлуудаас дурьдвал,

1. “Гэр хорооллын айл өрхүүдийн галын аюулгүй байдал, урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ”-ний удирдамжийг Онцгой байдлын ерөнхий газрын тэргүүн дэд дарга бөгөөд штабын даргын 2022 оны 2/59 дүгээр албан бичгээр орон нутгийн онцлогт тохируулан зохион байгуулах талаар төв, орон нутгийн Онцгой байдлын газрын дарга нарт үүрэг чиглэл өгч, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллаа.

Мэргэжлийн байгууллагуудтай хамтран галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтыг зохион байгуулахад их эрсдэлтэй айл өрхийн 60-70% нь зорилтот бүлгийн өрхүүд байв. Иймд Архангай, Говь-Алтай, Говьсүмбэр, Булган, Дархан-Уул, Дорнод, Орхон, Төв аймгийн зорилтот бүлгийн 175 айл өрхийн цахилгааны утсыг тухайн аймгийн “Цахилгаан түгээх сүлжээ ХК”-аас шинэчлэн засварлажээ. Мөн гэр хорооллын айл өрхүүдэд гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний талаарх сургалтыг зохион байгуулж, учирч болох эрсдэлийг арилгуулан ажилласан нь өндөр ач холбогдолтой арга хэмжээ болсон байна.

2. “Өвөлжилт, хаваржилт хүндрэх болон зудын аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ”-ний хүрээнд танхимын болон цахим сургалтыг 822 удаа 29459 хүнд зохион байгуулж, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх заавар зөвлөмж, сэрэмжлүүлэг, анхааруулга, мэдээ, мэдээллийг олон нийтийн 52 телевизээр 154 удаа ярилцлага өгч, байгууллагын цахим хуудсанд 1089 удаагийн сэрэмжлүүлэг мэдээ, зурагт хуудас, шторкийг бэлтгэн байршуулж, багц мессежийг үүрэн холбооны 4 байгууллагаар дамжуулан 141 удаа 250000 мянган гаруй иргэдийн гар утсанд тухай бүр хүргэн ажиллажээ.

3. Олон улсын Иргэний хамгаалалтын өдөрлөгийг “Гамшиг, хямралын улмаас орон гэргүй болсон иргэдийн иргэний хамгаалал ба менежмент; Сайн дурынхны үүрэг ба цар тахалтай тэмцэх нь” уриалга дор зохион байгуулсан бөгөөд дэвшүүлсэн уриалга, болзошгүй гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх мэдлэг олгох танхимын болон цахим сургалтыг төрийн болон төрийн бус байгууллагын 1800 алба хаагчдыг хамруулж, албаны цахим хуудсанд 950 удаагийн мэдээ, мэдээлэл, сонин, сэтгүүлд нийтлэл 5 удаа, телевизийн ярилцлагад 32 удаа, гар утсанд (багц мессеж) 250,330 иргэнд илгээж сурталчлан олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлэн ажилласан байна.

4. “Шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ”-

ний хүрээнд энэ төрлийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар 2022 онд 12 удаагийн сэрэмжлүүлэг мэдээ, зурагт хуудас, шторк бэлтгэн онцгой байдлын байгууллагын [meta.gov.mn](http://meta.gov.mn) цахим болон “Онцгой байдлын ерөнхий газар” пэйж хуудсанд байршуулж, 107676 хүнд хүргэсэн байна. Мөн байгууллагын [meta.gov.mn](http://meta.gov.mn) цахим хуудсанд нийтлэгдсэн мэдээ, мэдээлэл өдөр бүр тогтмол 34 мэдээллийн сайт, сонингоор дамжуулан иргэд, олон нийтэд хүргэсээр байна. 2022 онд байгууллагын цахим хуудсанд 271275 хүн ханджээ.

Телевиз, сонин, мэдээллийн сайтуудаар дамжуулан 2022 онд шар усны үерын аюулаас урьдчилан сэргийлэх талаар давхардсан тоогоор нийт 110 орчим удаагийн сэрэмжлүүлэг, мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэжээ.

5. “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөрлөг”-ийн хүрээнд танхимын болон цахим сургалтыг 1300 удаа зохион байгуулж нийт 82.904 хүнд урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл өгч, 9 төрлийн зөвлөмж зурагт хуудас, постер, шторк, тараах материалыг олон нийтийн сүлжээ, өдөр тутмын мэдээллийн сайт, сонин, телевиз зэрэг нийт 57 хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын цахим болон пэйж хуудсанд 799 мэдээ, мэдээлэл байршуулж иргэдэд хүргэсэн байна. Мөн гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор аюулгүйн талбайд нүүн шилжих дадлага сургуульд төрийн болон төрийн бус байгууллага, сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын болон их, дээд сургууль нийт 7455 байгууллагын 1003256 иргэд хамрагджээ.

6. “Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ”-ний хүрээнд Хөдөлгөөнт завьт эргүүл хийх хуваарийг аймаг, нийслэлийн Засаг даргаар батлуулан төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсээс 3024 алба хаагч 28 завьтай 37 гол, нуурын эрэг дагуу 50294 км эргүүл хийжээ. Мөн Төв, орон нутгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Цагдаагийн байгууллага, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Монголын Улаан загалмайн нийгэмлэгийн давхардсан тоогоор нийт 12,221 ажилтан, алба хаагч 1606 нэгж техник хэрэгсэлтэйгээр үүрэг гүйцэтгэн гол, нуурын ай сав газарт амарч, зугаалж буй 240,508 иргэнд гол усанд осолдохоос урьдчилан сэргийлэх гарын авлага, тараах материал 146,662 ширхэгийг тарааж, сэрэмжлүүлэг яриаг нийт 49936 иргэнд хийж, голын эрэг дагуу байрласан 7821 тээврийн хэрэгслийг ногоон бүсээс холдуулан урьдчилан сэргийлж, ажилласан байна.

7. Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын өдөрлөгийг зохион байгуулахдаа НҮБ-ын Ерөнхий ассамблейн 2022 онд дэвшүүлсэн “Иргэд, олон нийтэд хүргэх эрт сэрэмжлүүлэг, арга хэмжээ” уриан дор Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаа, Гамшгаас хамгаалах болон Галын аюулгүй байдлын тухай хууль, тогтоомж сурталчлах өдөрлөг, нэгдсэн арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулж, сурталчилж ажиллав.

## 2.1.2. Гамшгаас хамгаалах сургалт

### Гамшгаас хамгаалах ангиллын сургалтын талаар:

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны А/173 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд улсын хэмжээнд 2022 онд гамшгаас хамгаалах ангиллын сургалтыг нийт 7926 удаа зохион байгуулж 341448 хүнийг хамруулсан байна.



Зураг 33 Ангиллын сургалт

Дээрх ангиллын сургалтыг өмнөх оны мөн үетэй харьцуулвал Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль 29 буюу 100 хувиар өссөн, гамшгаас хамгаалах команд штабын сургууль 69 удаа буюу 100 хувиар өссөн, удирдах албан тушаалтны сургалт 72 буюу 17 хувиар өссөн, их, дээд сургууль болон МСҮТөв, коллежийн оюутны сургалт 11 буюу 4 хувиар буурсан, Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын сургалт 293 буюу 100 хувиар өссөн, Ерөнхий боловсролын сургуулийн дунд ангийн сурагчдын сургалт 371 буюу 100 хувиар өссөн, Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдын сургалт 85 буюу 36 хувиар өссөн, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүүхдийн сургалт 385 буюу 100 хувиар өссөн, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн албан тушаалтан, ажилтны сургалт 865 буюу 24 хувиар өссөн, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн сургалт 378 буюу 46 хувиар өссөн, иргэний сургалт 164 буюу 23 хувиар өссөн, цэргийн дүйцүүлэх албаны сургалт 10 буюу 32 хувиар буурсан, сайн дурын бүлэг, хэсгийн сургалт 39 буюу 20 хувиар өссөн, хөгжлийн бэрхшээлтэй иргэний сургалт 2 буюу 7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

### **Гамшгаас хамгаалах иж бүрэн, команд штабын сургууль**

2022 онд Орхон, Сэлэнгэ аймгуудад гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль, Баян-Өлгий, Өмнөговь аймгуудад гамшгаас хамгаалах команд штабын сургуулиудыг зохион байгуулж аймаг, сумын Онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, ерөнхий болон тусгай зориулалтын мэргэжлийн анги, төрийн болон хувийн хэвшлийн нийт 284 байгууллагын 2704 ажилтан, алба хаагч, 189 автомашин, техник хэрэгслийг хамруулсан. Мөн гамшгийн аюулын үед нийт хүн амыг аюулгүй газарт нүүн шилжүүлэх дадлага, сургуульд Орхон аймгийн 19 сум, 6 тосгон, 25 багийн нийт 101,691 иргэн хамрагдан оролцсон.

1. ОБЕГ-ын даргын 2022 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн “Команд штабын сургууль, ISO стандартын аудит хийх” тухай А/60 дугаар тушаал, 4 дүгээр сарын 05-ны өдөр баталсан Гамшгаас хамгаалах команд штабын сургуулийн бодлого, сургуулийг удирдах төлөвлөгөөний дагуу Баян-Өлгий аймагт Гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг 4 дүгээр сарын 10-12-ны өдрүүдэд зохион байгууллаа. Тус сургуульд аймаг, сумын Онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, ерөнхий болон тусгай зориулалтын мэргэжлийн анги, төрийн болон хувийн хэвшлийн нийт 106 байгууллагын 642 алба хаагч, 87 техник хэрэгслийг хамруулан зохион байгуулсан бөгөөд 95,4 буюу Дүүрэн хангалттай үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

2. Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2022 оны 5 дугаар сарын 03-ны өдрийн А/115 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсэг Сэлэнгэ аймагт гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг “Гамшиг, онцгой байдлын үеийн бүх шатны удирдлагын харилцан ажиллагаа, гамшгаас хамгаалах орон нутгийн алба, мэргэжлийн ангийн төлөвлөлт, бэлэн байдал, хариу арга хэмжээ, иргэн, хуулийн этгээдийн аюулгүй амьдрах ухааны мэдлэг ойлголт” сэдвийн хүрээнд 2022 оны 6 дугаар сарын 03-05-ны өдрүүдэд астрономийн 104 цаг, оперативын 648 цагийн багтаамжтай 3 шат, 5 үетэйгээр зохион байгууллаа.

Дадлага, сургуульд аймаг, сумын Онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, ерөнхий болон тусгай зориулалтын мэргэжлийн анги, төрийн болон хувийн хэвшлийн нийт 106 байгууллагын 548 алба хаагч, 27 автомашин, техник хэрэгслийг хамруулжээ.

Мөн гамшгийн аюулын үед нийт хүн амыг аюулгүй газарт нүүн шилжүүлэх дадлага, сургуульд Сэлэнгэ аймгийн 17 сум, 6 тосгоны нийт 32,323 иргэн хамрагдан 95 буюу Дүүрэн хангалттай гэж үнэлэгджээ.


3. Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2022 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн А/215 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсэг Орхон аймагт гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг “Төв суурин газрын газар хөдлөлтийн эрсдэлийг бууруулах, хариу арга хэмжээг сайжруулах, харилцан ажиллагааг боловсронгуй болгох” сэдвийн хүрээнд 2022 оны 10 дугаар сарын 06-08-ны өдрүүдэд астрономийн 72 цаг, оперативын 348 цагийн багтаамжтай 3 шат, 5

үетэйгээр зохион байгууллаа. Дадлага, сургуульд аймаг, сумын Онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, ерөнхий болон тусгай зориулалтын мэргэжлийн анги, төрийн болон хувийн хэвшлийн нийт 17 байгууллагын 646 ажилтан, алба хаагч, 75 автомашин, техник хэрэгслийг хамруулсан. Мөн гамшгийн аюулын үед нийт хүн амыг аюулгүй газарт нүүн шилжүүлэх дадлага, сургуульд Орхон аймгийн 2 сум, 25 багийн нийт 69368 иргэн хамрагдан оролцож 94 буюу Дүүрэн хангалттай үнэлэгдсэн байна.

4. Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн А/279 дүгээр тушаалаар томилогдсон ажлын хэсэг Өмнөговь аймагт гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг “Газар хөдлөлтийн аюулыг зарлан мэдээлэх, эрсдэлийг бууруулах, гамшгийн хор уршгийг арилгах, байгууллага хоорондын харилцан ажиллагаа” сэдвийн хүрээнд 2022 оны 11 дүгээр сарын 03-04-ний өдрүүдэд астрономийн 48 цаг, оперативын 336 цагийн багтаамжтай 3 шат, 4 үетэйгээр зохион байгуулсан. Уг дадлага, сургуульд аймаг, сумдын Онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, ерөнхий болон тусгай зориулалтын мэргэжлийн анги, төрийн болон хувийн хэвшлийн нийт 55 байгууллагын 590 алба хаагч, цахимаар 15 сумдын Шуурхай штабын гишүүд 278, нийт 868 хүнийг хамруулсан сургууль 95 буюу Дүүрэн хангалттай үнэлэгджээ.

### 2.1.3. Гамшгаас урьдчилан сэргийлэх хэвлэл мэдээллийн сурталчилгаа


2022 онд объектын болон ой, хээрийн гал түймэр, газар хөдлөлт, коронавируст халдвар, мөс цөмрөлт, шар усны үер, хүчтэй цасан болон шороон шуурга зэрэг цаг үеийн нөхцөл байдал, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг болон хандив тусламжийн талаарх мэдээ мэдээллүүдийг давхардсан тоогоор 1810 удаа олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим сайтуудаар дамжуулан иргэдэд хүргэж ажиллав.



Зураг 34 Аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан дүн /2021, 2022 он/

Улсын хэмжээнд 2022 онд Онцгой байдлын газар, хэлтсүүдийн бие бүрэлдэхүүн аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор сум, баг, хорооны гамшгаас хамгаалах орон тооны бус штабтай хамтран гэр хорооллын айл өрхүүдэд аюул осол, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг 1595 удаа зохион байгуулж, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх санамж сэрэмжлүүлгийг **539795** айл өрхөд тарааж, **1517648** иргэдэд урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгаа хийж, **954809** ширхэг санамж, тараах материалыг тарааж ажилласан байна.

Аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр орон нутгийн телевизээр **1640** удаа ярилцлага өгч, орон нутгийн болон өдөр тутмын сонинд **771** удаа ярилцлага өгч, **1395** сонинд мэдээлэл байршуулж, байгууллагын цахим сайт болон албаны сонинд **15242** удаа гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл байршуулж, орон нутгийн телевизээр **44517** удаа гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сэрэмжлүүлэг шторкийг явуулсан байна.



Зураг 35. Төв, орон нутагт 2022 онд зохион байгуулсан нэгдсэн арга хэмжээг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулсан үзүүлэлт

### Хэвлэлийн бага хурал

2022 онд “Газар хөдлөлтийн аюулыг таниулах аян” болон “Үер уснаас үрсээ хамгаалъя” аяны хүрээнд 2 удаагийн хэвлэлийн бага хурал зохион байгуулж, Онцгой байдлын ерөнхий газар” пейж хуудсаар шууд дамжуулан, 12 телевиз, 3 өдөр тутмын сонин, 70 гаруй мэдээллийн сайтаар олон нийтэд хүргэсэн.



Зураг 36. Цаг үеийн асуудлаар зохион байгуулсан хэвлэлийн бага хурал



### Цахим сурталчилгаа

Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомж, төрийн бодлого, Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, мэдээллийн ил тод байдлыг хангах, гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээллийг иргэдэд хүргэх зорилгоор [www.nema.gov.mn](http://www.nema.gov.mn) цахим хуудас, “Онцгой байдлын ерөнхий газар” фэйсбүүк хуудас, [www.ontsgoisur.gov.mn](http://www.ontsgoisur.gov.mn) цахим хуудсыг тогтмол ажиллуулж байна.

Онцгой байдлын ерөнхий газрын цахим хуудсанд 2022 онд нийт 1870 удаагийн цаг үеийн мэдээ, мэдээлэл, сэрэмжлүүлгийг байршуулан олон нийтэд сурталчлан ажилласан.

Улирлын онцлогт тохируулан тухай бүр шар усны үер, мөс цөмрөх аюул, ой, хээрийн болон объектын гал түймэр, газар хөдлөлт, хүүхдийн аюулгүй байдал, ахуйн осол, коронавируст халдвар, хүчтэй цасан шуурга, зам даваа хаагдах зэрэг цаг агаарын аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг шторкыг давхардсан тоогоор 850 гаруй удаа байршуулан олон нийтэд түгээж, цахим хуудсанд өдөрт 3000-5000, сард 70000-80000 нийт 5480000 хүн хандсан байна.

Байгууллагын цахим хуудсыг хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийн нэгдсэн группт холбуулсан нь хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчид Онцгой байдлын албаны үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг шууд, цаг алдалгүй шуурхай авах боломж бүрдсэн. Ингэснээр өдөрт тогтмол 30 гаруй мэдээллийн цахим хуудас, сонингоор дамжуулан Онцгой байдлын албатай холбоотой мэдээлэл иргэд, олон нийтэд хүрч байна.




Зураг 37. [nema.gov.mn](http://nema.gov.mn) цахим хуудасны мэдээ, мэдээлэл, хандалтын тоо

### “Онцгой байдлын цаг” нэвтрүүлэг

МҮОНТ-тэй хамтран ажиллах гэрээ байгуулж, иргэдэд болзошгүй аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх мэдлэг, боловсролыг олгох, Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаа, алба хаагчдын ажил, мэргэжлийн онцлогийг олон нийтэд сурталчлан таниулахад чиглэгдсэн “Онцгой байдлын цаг” 15 минутын нэвтрүүлгийг “Аврагч” студидээ бэлтгэн, 14 хоног тутамд давталттайгаар МҮОНТ-ийн 1 дүгээр сувгаар бямба гарагийн 18:20 цагаас, 2 дугаар сувгаар даваа гарагийн 21:20 цагаас, мягмар гарагт “Өлзий ТВ”-ээр 18:40 цагаас тус тус тогтмол нэвтрүүлэн ажиллаж байна.

2022 онд нэвтрүүлгийн нийт 24 дугаар буюу 30 цагийн нэвтрүүлгийг бэлтгэн үзэгчдэд хүргэсэн.



Зураг 38. Онцгой байдлын цаг” нэвтрүүлэг

### “Онцгой мэдээ” сонин

Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаа болон төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, анги байгууллагын ажил, үйлсийг сурталчлах, тэргүүний шилдэг алба хаагчдыг алдаршуулах, байгууллага, хамт олны шинэ санаачлага, тэргүүн туршлагыг алба хаагчидтай хуваалцах, бусдад түгээх зорилгоор 2015 оноос эхлэн нийт 153 дугаарыг эрхлэн гаргаж байна. 2022 онд “Онцгой мэдээ” сонины 154-177 дахь дугаар буюу нийт 24 дугаарыг эрхлэн гаргасан.

Тус сонин 14 хоногт нэг удаа АЗ хэмжээтэй, 12 нүүрээр хэвлэгдэж байсан бөгөөд 2021 оны 9 дүгээр сараас сонины хэмжээг томсгон шинэчилж, А2 хэмжээтэй 8 нүүрээр, 3100 ширхэг хэвлэж төв, орон нутгийн Онцгой байдлын анги, байгууллагын хэмжээнд тараан алба хаагчдад хүргэсэн. 2022 онд тус сонинд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтны ярилцлага-48, орон нутгийн мэдээ-343, албаны үйл ажиллагаатай холбоотой мэдээ, нийтлэл, сурвалжлага-282 буюу нийт 673 материалыг бэлтгэн хэвлүүлэв.

## 2.2. Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа

### 2.2.1. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийсэн байдал

Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр Ядуурлыг бууруулах Японы сангийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ, төлөвлөлт болон эрсдэл шилжүүлэх чадавхыг бэхжүүлэх” техник туслалцааны төслийн хүрээнд Монгол Улсад зонхилон тохиолддог гамшиг, аюулт үзэгдлийн 10 төрлөөр үндэсний болон орон нутгийн түвшинд гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийж, эхний ээлжинд үндэсний хэмжээний болон Улаанбаатар хот, Орхон, Өмнөговь, Ховд, Дорнод аймгийн үнэлгээний тайланг боловсрууллаа.

Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын тамгын газар, Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагатай хамтран сургууль, цэцэрлэгийн гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийж байгаа бөгөөд 2022 оны байдлаар улсын хэмжээнд нийт сургууль, цэцэрлэгийн 76 хувьд хийжээ. Мөн нийслэлийн хэмжээнд төрийн өмчийн нийт 152 сургууль байгаагаас гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг 100 хувь, 9 дүүргийн 41 хороо, 60 өрхийн эмнэлэгт гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийж гүйцэтгэсэн байна.



Зураг 39. Сургууль, цэцэрлэгийн хэмжээнд гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийгдсэн байдал

ЖАЙКА байгууллагын “Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх” төслийн хүрээнд боловсруулсан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн газар хөдлөлтийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх аргачлалын дагуу 2022 онд Архангай, Орхон аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшний газар хөдлөлтийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийж гүйцэтгэжээ.


Монгол Улсын гамшигтай тэмцэх чадавхыг нэмэгдүүлэх, улс орны тогтвортой хөгжлийг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийн эрсдэлийн удирдлагын манлайллыг бэхжүүлэх зорилгоор Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд НҮБ-ын гамшгийн эрсдэлийг бууруулах газрын “Аюулгүй, гамшигт тэсвэртэй хот-2030” санаачлагын хоёрдугаар шатанд 21 аймгийн төв,

нийслэл хотыг шинэчлэн бүртгүүлэв. Батламжийг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга бөгөөд Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн дарга нарт гардуулсан байна.



Зураг 40. Батламж гардуулж буй явц

Дээрх үйл ажиллагааны бэлтгэл ажлын хүрээнд Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн удирдамжийн дагуу “Хотуудын гамшгийг тэсвэрлэх чадавхыг онооны аргаар үнэлэх” аргачлалаар үндсэн 10 чиглэлээр 21 аймгийн төвийн гамшгийг тэсвэрлэх чадавхын үнэлгээг 2022 оны 03 дугаар сарын 09-10-ний өдрүүд хийв. Монгол Улсад тус үнэлгээг анх 2018-2019 онд бүх аймгийн хэмжээнд бүсчилсэн хэлбэрээр хийсэн юм.




Зураг 41. Үндсэн 10 чиглэлийн үзүүлэлт /Харьцуулсан байдлаар/

### Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ


Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйл, Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд 2022 оны байдлаар улсын хэмжээнд нийт 398 аж ахуйн нэгж, байгууллага гамшгийн төрөл тус бүрээр гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг хийлгэжээ.

2022 онд нийт 116 аж ахуйн нэгж, байгууллага гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийлгэсэн байна.



Зураг 42. Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийлгэсэн аж ахуйн нэгж, байгууллагын тоо

Мөн төслийн хүрээнд 5 бүсийн төвийн аймгийн олон нийтийн барилга байгууламж буюу Дорнод аймгийн 10 дугаар цэцэрлэг, Орхон аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Өмнөговь аймгийн 1 дүгээр сургууль, Ховд аймгийн Нутгийн удирдлагын ордонд нийслэлийн СХД-ийн ГТУА 26 дугаар анги газар хөдлөлтийн нарийвчилсан үнэлгээг хийж цаашид авах арга хэмжээ, барилга байгууламжийг хүчитгэх шаардлагатай талаар дүгнэлт гаргасан юм.




Зураг 43. 2022 онд гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийлгэсэн байдал /чиглэл тус бүрээр/

### 2.2.3. Гамшгийн эрсдэлийн үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагаа

Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоолоор “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам”, Шадар сайдын 2021 оны 100 дугаар тушаалаар батлагдсан “Гамшгийн эрсдэлийн үнэлгээний Мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам”-ын хүрээнд гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрлийг олгож, үнэлгээ хийгдэж байна.

Энэхүү Мэргэжлийн зөвлөлийн 2022 оны ээлжит хуралдааныг 12 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулж, 6 хуулийн этгээдийн гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 3 хуулийн этгээдийн гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх чиглэлийг нэмж, 3 хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл шинээр олгосноор нийт 33 байгууллага гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрлийн гэрчилгээ эзэмшиж байна.

Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам”-ын дагуу гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрлийг Уул уурхай, Дэд бүтэц, Хөдөө аж ахуй, Байгаль орчин, түүх соёлын дурсгалт газар, Үйлдвэр үйлчилгээ, Эрүүл мэнд гэсэн 6 чиглэлээр олгодог.



Зураг 44 Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл олгосон байдал

### 2.2.4. Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний болон орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагаа

Засгийн газрын 2020 оны 189 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл”-ийн 2022 оны хуралдааныг 10 дугаар сарын 07-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулсан. Тус зөвлөлийн 2021 оны хуралдаанаас гарсан зөвлөмжийн хэрэгжилт 89.6 хувьтай дүгнэгдсэн байна.

Үндэсний зөвлөлийн 2022 оны хуралдааныг Монгол Улсын Шадар сайд, Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн орлогч дарга удирдаж, үндэсний зөвлөлийн гишүүд болон орон нутгийн зөвлөлд нийт 12 чиглэлээр 27 арга хэмжээний үүргийг өгчээ.

2022 онд Үндэсний зөвлөлийн хуралдааныг 1 удаа, 21 аймаг, нийслэлийн орон нутгийн зөвлөлийн хуралдааныг дунджаар 2 удаа зохион байгуулжээ.

Мөн орон нутгийн зөвлөлийн дарга, гишүүдийн Зөвлөлдөх уулзалтыг Улаанбаатар хотноо зохион байгуулж, гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр холбогдох зөвлөмжийг гаргаж, Гамшгаас хамгаалах улсын албад, төр, захиргааны байгууллагуудад хүргүүлсэн. Гамшгийн эрсдэлийг бууруулах санхүү, хөрөнгө оруулалтад үндэсний болон орон нутгийн зөвлөлийн оролцоог нэмэгдүүлж, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51.2 дахь заалтын дагуу гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд аймаг, нийслэлийн төсвийн 0.2-12.7 хувь буюу улсын дунджаар 1.9 хувийг тусган хэрэгжүүлсэн байна.

ГУРАВДУГААР ХЭСЭГ.  
**ГАМШГИЙН ҮЕИЙН ШУУРХАЙ  
УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТ**













### 3.1. Гамшгийн нөхцөл байдал /статистик мэдээ, эрэн хайх, аврах ажиллагаа/

#### 3.1.1. Монгол оронд тохиолдсон аюулт үзэгдэл, ослын тойм


Монгол Улсын хэмжээнд 2022 онд нийт 4321 удаагийн аюулт үзэгдэл, осол тохиолдож, үүний улмаас 401 /154 Ковид-19/ хүн амь насаа алдаж, 173 хүн гэмтэж бэртэн, 8553 толгой мал, амьтан хорогдож, 33.2 тэрбум төгрөгийн шууд хохирол учирсан.

Эдгээрийн хор үршгийг арилгахад Онцгой байдлын байгууллагын болон бусад байгууллага, орон нутгийн нийт 42208 хүн, 10504 техник хэрэгсэлтэйгээр ажиллаж, 4023 хүний амь нас, төр, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн 274.1 тэрбум төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалж, гамшигтай тэмцэх, хор үршгийг арилгах ажилд онцгой байдлын байгууллага болон орон нутгаас 1.8 тэрбум төгрөг зарцуулжээ.

Хүснэгт 4. Аюулт үзэгдэл, ослын тоо /2021,2022 он/

										
2021	295	72	1		1	2671	91	65	208	671
2022	89	21	4		4	3075	56	179	222	666

Нийт тохиолдсон аюулт үзэгдэл, ослын 75 хувь нь гал түймэр, 5 хувь нь биологийн гаралтай аюулт үзэгдэл, 16 хувь нь хүний үйл, ажиллагаатай холбоотой осол, 2 хувь нь ус, цаг уурын гаралтай аюулт үзэгдэл, 2 хувь нь геологийн гаралтай аюулт үзэгдэл байна.




Зураг 45. 2022 онд нийт тохиолдсон аюулт үзэгдэл, ослын эзлэх хувь /гамшгийн төрлөөр/

Аюулт, үзэгдэл ослын улмаас учирсан нийт хохирлын 91 хувь буюу 30.3 тэрбум төгрөг нь гал түймрийн улмаас, 3 хувь буюу 0.9 тэрбум төгрөг нь ус, цаг уурын гаралтай аюулт үзэгдлийн улмаас, 2 хувь буюу 1.4 тэрбум төгрөг нь биологийн гаралтай аюулт, үзэгдэл ослын улмаас, 4 хувь буюу 0.4 тэрбум төгрөг нь хүний үйл ажиллагаатай холбоотой ослын улмаас учирсан байна.



Зураг 46. 2022 онд аюулт үзэгдэл, ослын улмаас учирсан хохирлын эзлэх хувь, гамшгийн төрлөөр

Аюулт, үзэгдэл ослын улмаас нас барсан иргэдийн ослын шалтгаанаар нь авч үзвэл 38 хувь буюу 154 хүн, 21 хувь буюу 85 хүн усны ослын улмаас, 15 хувь буюу 60 хүн зам тээврийн ослын улмаас, 10 хувь буюу 40 хүн объектын гал түймрийн улмаас, 4 хувь буюу 15 хүн төөрч сураггүй болсоны улмаас, 1 хувь буюу 5 хүн өндрөөс аврах ажиллагаа, 1 хувь буюу 5 хүн бичил уурхайн нурангийн ослын улмаас, аянганы улмаас 2 хүн, 1 хувь буюу 2 хүн үерийн ослын улмаас тарваган тахлын улмаас 1 хүн, 32 хүн бусад төрлийн ослын улмаас амь насаа алдсан байна.



Зураг 47. 2022 онд аюулт үзэгдэл, ослын улмаас амь насаа алдсан хүний эзлэх хувь /гамшгийн төрлөөр/

## **УС, ЦАГ АГААРЫН ГАРАЛТАЙ АЮУЛТ ҮЗЭГДЭЛ:**

### **Аадар бороо, үер:**

Улсын хэмжээнд 12 аймгийн нийт 16 сум, дүүргийн нутаг дэвсгэрийг хамарсан 21 удаагийн аадар бороо орж, үер болсны улмаас 2 хүн амь насаа алдаж, 3740 толгой мал хорогдож, 46 гэр, байшин урсан эвдэрч, Үерийн улмаас 0.5 тэрбум төгрөгийн хохирол учирчээ. Голомтод 529 албан хаагчид, 84 автомашин техниктэй ажиллаж 122 хүний амь насыг авран хамгаалсан байна.

### **Аянга:**

Дөрвөн аймгийн 4 сумын нутаг дэвсгэрт аянга буусны улмаас, 2 хүн амь насаа алдаж, 37 толгой мал хорогдсон байна.

### **Хүчтэй салхи шуурга:**

Нийслэл хот, 15 аймгийн нийт 42 сум, дүүргийн нутаг дэвсгэрийг хамарсан 56 удаагийн хүчтэй салхи, шуурганы улмаас 174 гэр, байшин нурж эвдрэн 0.5 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна. Шуурганд төөрсөн хүмүүсийг эрэн хайх ажиллагаанд Онцгой байдлын байгууллага, орон нутгийн иргэд нийт 216 хүн, 56 автомашин техник ажилласан.

## **ГЕОЛОГИЙН ГАРАЛТАЙ АЮУЛТ ҮЗЭГДЭЛ:**

### **Газар хөдлөлт:**


Монгол Улсын 15 аймгийн 43 сумын нутагт 3.5 магнитудаас дээш хүчтэй газар хөдлөлтийн 89 тохиолдол мэдрэгдсэн. Онцгой байдлын байгууллага, орон нутгийн иргэд нийт 12 хүн, 5 автомашин техник ажилласан.

## **БИОЛОГИЙН ГАРАЛТАЙ ӨВЧИН, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ:**

Онцгой байдлын байгууллагад нийт 204 удаагийн хүн малын халдварт өвчний дуудлага мэдээлэл бүртгэгдэж, 1 хүн амь насаа алдаж, 3317 толгой мал хорогдсон. Хорогдсон мал, амьтдыг бүлж устган, ариутгал халдваргүйжүүлэлт хийж урьдчилан сэргийлэх, вакцинжуулах зорилгоор нийт 8771 хүн, 3015 техник ашиглан ажилласан байна.

## **ХҮНИЙ БУРУУТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ОСОЛ:**


Усны осол, бичил уурхайн нуранги зэрэг хүний үйл ажиллагаатай холбоотой осол нийт 666 удаа тохиолдож, 202 хүн амь насаа алдаж, 1296 хүний амь насыг авран хамгаалж, 132 хүн гэмтэж бэртсэн. Ослын голомтод Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага, орон нутгаас нийт 5081 хүн, 1189 автомашин техниктэйгээр ажилласан.



Зураг 48. Аюулт үзэгдэл, ослын улмаас амь насаа алдсан хүний тоо, учирсан хохирлын хэмжээг өмнөх онтой харьцуулсан үзүүлэлт

### АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСЛЫН ТОО


2022 онд тохилдсон аюулт үзэгдэл, ослыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад гамшиг, аюулт үзэгдэл, ослоос аварсан хүний тоо 221 /5.8 хувь/ өссөн үзүүлэлттэй байна.



Хүснэгт 5. 2021-2022 онд аюулт үзэгдэл, ослын улмаас нас барсан хүн /аймаг нийслэлээр/



Аюулт үзэгдэл, ослын улмаас нас барсан хүний тоогоор Улаанбаатар, Төв, Хөвсгөл аймаг орж байгаа боловч тухайн орон нутгийн 100000 хүн тутамд ногдох нас баралтын графикаар Төв, Завхан аймаг, Дорнод аймгууд өндөр байгаа нь харагдаж байна.



Хүснэгт 6. Аюулт үзэгдэл, ослын улмаас нас барсан хүний тоо  
/өмнөх онтой харьцуулвал/

2022 онд аюулт үзэгдэл, ослын улмаас нас баралтын 35 хувийг усны осол эзэлж байгаа бөгөөд 83.5 хувь нь эрэгтэйчүүд байна. Харин 16 хувийг объектын гал түймэр эзэлж үүний 85 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна.

### 3.1.2. Монгол Улсад 2022 онд гарсан зарим томоохон аюулт үзэгдэл, ослын тойм:

#### СУРАГГҮЙ АЛГА БОЛСОН

Булган аймгийн Сэлэнгэ сумын Тариахтай багийн “Харлагийн гол” гэдэг газар /аймгийн төвөөс зүүн хойд зүгт 134 км, сумын төвөөс баруун хойд зүгт 24 км, Хялганат тосгоноос баруун зүгт 35 км/-т оршин суугч 3 иргэн нь Портер загварын автомашинтай 2022.04.09-ний өдрийн 09:10 цагт гэрээсээ сумын төв орж, Сэлэнгэ сумын төвийн Ингэт багийн айлаас малын тэжээл ачиж 16:47 цагт гэрлүүгээ буцаж гараад сураггүй болсон. 05.18-ны өдөр "Харлагийн голын-Адаг" гэдэг газраас зүүн зүгт 7 км-т "Майхан толгой" гэдэг газар “Сэлэнгэ” мөрөнд “Портер” загварын ачааны автомашиныг илрүүлсэн тухай Цагдаагийн байгууллагын мэдээллийн дагуу тус аймгийн Онцгой байдлын газрын Хангал сумын Хялганат тосгон дахь Гал түймэр унтраах, аврах 50 дугаар ангийн 5 алба хаагч, 1 автомашин, 1 завьтай мөн өдрийн 13:45 цагт, хүч нэмэгдүүлэн Эрэн хайх, аврах салбарын 4 алба хаагч, 1 автомашин, 1 моторт завьтай 21:55 цагт тухайн газарт тус тус очиж, тандалтын ажиллагаа явуулж, голын эргээс 25-30 метрт, 3.5 орчим метрийн гүнд байгаа автомашины байршлыг тогтоосон. 05.19-ний өдрийн байдлаар 16 удаагийн шумбалт хийж, тухайн автомашиныг 05.20-ны өдрийн 13:30 цагт уснаас татан гаргасан бөгөөд ар гэрийнхэнтэй нь зөвшилцөж эрэн хайх ажиллагааг зогсоосон. Ослын улмаас 3 хүн сураггүй алга болсон.



Зураг 49. Булган аймгийн Сэлэнгэ суманд болсон осол

Ослын голомтод Онцгой байдлын байгууллагын 28 алба хаагч, Цагдаагийн байгууллагын 6 алба хаагч, нутгийн захиргааны байгууллагын 2 ажилтан, ар гэрийн 32 хүн, нийт 68 хүн, 24 техник хэрэгсэлтэйгээр нийт 22 хоног эрлийн ажиллагаа зохион байгуулсан.

### УСНЫ ОСОЛ

Завхан аймгийн Тэлмэн сумын Нуур багийн “Их Шийрийн дөрөлж” гэдэг газар /аймгийн төвөөс хойд зүгт 145 км, сумын төвөөс зүүн зүгт 25 км, Тосонцэнгэл сумын төвөөс баруун зүгт 70 км-т/ Завхан аймгийн Эрдэнэхайрхан сумын “Улаагчийн хар” нуурнаас Тэлмэн сумын нуурны чиглэлд зорчиж явсан Дорноговь аймгийн Сайншанд сумын харьяат иргэд усанд осолдсон тухай дуудлагыг 07.13-ны 16:35 цагт хүлээн авсан. Ослын улмаас 3 хүн амь насаа алдсан.



Зураг 50. Завхан аймгийн Тэлмэн нууранд болсон усны осол

Ослын голомтод Онцгой байдлын байгууллагын 12 алба хаагч, Цагдаагийн газрын 9 алба хаагч, нийт 21 хүн, 7 техник хэрэгсэлтэйгээр 21 цаг үүрэг гүйцэтгэсэн.

### ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ

Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Мандал хайрхан багийн “Бор худаг” гэдэг газар /аймгийн төвөөс баруун зүгт 55,6 км, сумын төвөөс баруун урд зүгт 42 км/-т Баян-Өлгий аймгаас Улаанбаатар хотруу зорчиж явсан иргэн “Хонда сивик” загварын суудлын автомашин /5 иргэн/, Улаанбаатар хотоос Ховд аймгийн чиглэлд зорчиж явсан 55-00 ТӨН улсын дугаартай “Норд бенз” загварын том оврийн ачааны автомашинтай замын зорчих хэсэгт мөргөлдсөн тухай дуудлагыг 2022.07.17-ны өдрийн 10:10 цагт хүлээн авсан.



Зураг 51. Баянхонгор аймгийн зам тээврийн осол

Ослын улмаас 5 хүн нас барж, 2 хүн сэтгэл санааны хувьд хүнд гэмтсэн. Уг аврах ажиллагаанд 7 алба хаагч, 1 автомашинтайгаар 5 цаг 20 минут ажилласан.

Мөн Ховд аймгийн Буянт сумын Норжинхайрхан багийн “Дөрөвийн газар” гэдэг газар / аймгийн төвөөс зүүн зүгт 10 км, сумын төвөөс баруун хойд зүгт 20/- т автозамын зорчих хэсгийн замын хажууруу приус 20 загварын, 6 зорчигчтой суудлын автомашин онхолдсон тухай дуудлагыг 2022.05.14-ний өдрийн 23:09 цагт хүлээн авсан. Ослын улмаас 4 хүн нас барж, 3 хүн хүндээр гэмтэж бэртсэн. Уг аврах ажиллагаанд 9 алба хаагч, 1 автомашинтайгаар ажилласан.

### ҮЕР

Сонгинохайрхан дүүргийн 21, 32 дугаар хороонд 2022 оны 07 дугаар сарын 26 ны өдөр 14:00 цагт хүчтэй аадар бороо орсоны улмаас үер бууж байна гэсэн дуудлагаар Онцгой байдлын хэлтсийн ГТУА 26 дугаар ангийн бүрэлдэхүүн 14:10 цагт 7 алба хаагчын бүрэлэхүүнтэй 2 автомашинтай ус сорох 2 мотопомптой, Нийслэлийн аврах анги 7 алба хаагч 1 автомашин 1 завьтай гарч үүрэг гүйцэтгэн ажилласан.



Зураг 52. Үерийн аюулаас үүссэн нөхцөл байдал

Үерийн улмаас 58 айл өрх усанд автаж, 23 хашаа, явган хүний 2 гүүр нурсан ба 9 иргэн амь насыг авран хамгаалсан. Урьдчилсан байдлаар 600 сая төгрөгийн шууд хохирол учруулсан байна. Сэргээн босгох үйл ажиллагаанд дүүргээс нийт 40 алба хаагч үүрэг гүйцэтгэн ажилласан.

Мөн 06 дугаар сарын 17-нд Хөвсгөл, Архангай, Өвөрхангай аймгийн нутгуудаар хүчтэй аадар бороо, мөндөр орж тунадасны нийлбэр хэмжээ 15-34.0 мм, мөндөрийн голч 13-23 мм хэмжээтэй орж ихээхэн хэмжээний хохирлыг учруулсан. Хохирлыг дурьдвал: Архангай аймаг, Эрдэнэмандал сум Хан-Өндөр багийн “Дунд цүүр” гэдэг газар эвдэрсэн гэр 5 ш, хорогдсон мал 5133, Улаанбаатар хотод 8 гэр, 7 байшин усанд автаж, 2 гэр нурж, 5 байшингийн дээвэр хууларсан. Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын төвөөс баруун өмнө зүгт 37 км-т байх 3-р багийн нутаг Тээлийн ам гэдэг газарт ширүүн аадар бороо орсны улмаас ногооны талбай үерт өртөж урссан. Тариалын сумын нутгаар мөндөр, ширүүн аадар бороо орсны улмаас айлуудын хашаа үерт урсаж, усанд автсан. Их-Уулаас хот хоорондын засмал замд зорчиж явсан хэд хэдэн автомашины цонхны шил, толь хагарч, машины их биед хонхорхой үүссэн. Урьдчилсан байдлаар 545 сая 200 мянган төгрөгийн хохирол учруулсан байна.

### 3.1.3. 2022 оны уур амьсгалын жилийн тойм

#### Агаарын температур

Монгол орноор дунджилсан 2022 оны жилийн дундаж агаарын температур 0.8°C буюу уур амьсгалын өөрчлөлт харьцангуй сул илэрч байсан 1961-1990 оны дунджаас 1.43°C-ээр дулаан, 1940 оноос хойш ажиглагдсан 16 дахь дулаан




жил болж өнгөрлөө.

Бүс нутгаар авч үзвэл говийн бүс нутгийн өмнөд, Алтайн өвөр говиор +6.0...+10.0°C, тал хээрийн бүс нутгуудаар болон Их нууруудын хотгор орчмоор +2.0...+5.8°C, Хөвсгөлийн өндөр уулс, Хангайн нуруу, Дархадын хотгор орчмын нутгаар -4.0...-8.0°C, бусад нутгаар -2.0...+2.0°C орчим байлаа.

2022 оны өвлийн улирлын агаарын дундаж температур нутгийн баруун хэсэг болон Увс, Завхан, Баянхонгор, Төв, Архангай аймгуудын зарим нутгаар ОЖД-аас -1.0-ээс -2.9°C-аар, Баян-Өлгийн Баяннуур, Увсын Хар-Ус, Наранбулаг, Ховдын Цэцэг, Зэрэг, Мөст, Завханы Завханмандал орчмоор илүү хүйтэн буюу -3.0 -аас -5.5°C-аар хүйтэрсэн. Харин Говь-Алтайн Тоорой, Хэнтийн Биндэр, ХэрлэнБаян-Улаан Дархан, Сэлэнгийн Зүүнхараа, Ерөө орчмоор олон жилийн дундаж (ОЖД)-аас 1.0 -ээс 2.0°C-аар дулаан, бусад нутгаар дунджийн орчим байсан байна.


Хаврын улиралд агаарын дундаж температур нийт нутгийн 52.2% -д ОЖДаас 1.0-ээс 3.0°C дулаан, 47.8% нь ОЖД-ийн орчим байжээ.

Зуны улирлын агаарын дундаж температур нийт нутгийн дийлэнхи хэсгээр (81.1%) ОЖД-ийн орчим, харин Хөвсгөл, Сэлэнгэ, Дархан-Уул, Хэнтийн зарим нутгаар дунджаас -1.0-ээс -1.8°C -аар хүйтэн, Баянхонгорын Эхийнгол, Өмнөговийн Гурвантэс, Говь-Алтайн Ажбогд, Ховдын Цэцэг, Мөнххайрхан орчмоор 1.0 -ээс 1.4°C-аар дулаан байжээ.




Зураг 53. 2022 оны жилийн дундаж агаарын температурын орон зайн тархалт

Намрын улирлын агаарын дундаж температур нутгийн дийлэнхи хэсгээр (77.2%) ОЖД-ийн орчим, харин Завханы Цэцэн-Уул, Тосонцэнгэл, Өвөрхангайн Богд, Сэлэнгийн Сүхбаатар, Дорнодын Матад, Халхгол, Сүхбаатар, Дорноговь, Өмнөговь аймгуудын ихэнхи нутгаар дунджаас 1.0-ээс 1.5°C-аар дулаан байсан байна.



Зураг 54. 2022 оны улирлын агаарын дундаж температурын ОЖД-аас (норм 1991-2020 он) хазайх хазайлт


Сүүлийн 5 жилийн сар бүрийн агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайлтын утгыг харьцуулж үзэхэд (зураг 33) 2022 оны 1, 3, 5, 6, 9 дүгээр саруудад ОЖД-аас 1.0-ээс 3°C-аар дулаан, 2, 12 дугаар сар -1.0°C-ээс -3.0°C-аар хүйтэн сар болж өнгөрсөн байна. Зун, намрын саруудад агаарын дундаж температур дунджийн орчим байжээ.



Зураг 55. 2018-2022 оны сарын дундаж агаарын температурын олон жилийн дундажтай (норм 1981-2010 он) харьцуулсан утга

## ХУР ТУНАДАС

Монгол орноор дунджилсан 2022 оны жилийн нийлбэр хур тунадас 200.6 мм буюу 1940 оноос хойш тохиолдсон 19 дахь хур тунадас багатай жил байлаа. Жилийн нийлбэр хур тунадасны орон зайн тархалтыг авч үзэхэд (зураг 4) Хөвсгөлийн өндөр уулс, Хэнтийн нуруу, Хангайн нуруу, Онон Балж голын ай сав орчим, Хөвсгөлийн Тариалан, Хэнтийн Биндэр, Дорнодын Баян-Уул сумдын нутгаар 390-517.8 мм, тал хээрийн болон говийн бүс нутгаар 100.0-192.8 мм, Алтайн өвөр говь Тоорой, Эхийн гол орчмоор 10.0-21.6 мм орсон байна. Жилийн нийлбэр тунадасны хамгийн их утга нь Хэнтийн аймгийн Дадал суманд 517.8 мм тунадас оржээ.



Зураг 56. 2022 оны жилийн нийлбэр хур тунадасны орон зайн тархалт


2022 оны өвлийн улиралд нийт нутгийн 39.5%-д олон жилийн дундаж-аас бага, 47.8% -д ахиу, 13.2% -д дунджийн орчим хур тунадас орсон ба Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Баянхонгор зарим хэсгээр, Өмнөговь аймгийн ихэнхи нутгаар дунджаас 40-80%-иар ахиу хур тунадас оржээ.

Хаврын улиралд нутгийн дийлэнхи хэсгээр буюу 72.1% -д олон жилийн дунджаас бага, 17.6% -д ахиу, 10.3% -д дунджийн орчим хур тунадас орсон ба хуурайшилт ихтэй байлаа.

Зуны улиралд нийт нутгийн 52.9%-д дунджаас бага, 30.9%-д ахиу, 16.2%-д дунджийн орчим тус тус тунадас орсон. Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Өмнөговийн ихэнхи нутгаар олон жилийн дунджаас 60% -аас бага тунадас оржээ.


Намрын улиралд нийт нутгийн 63.2% -д дунджаас бага, 21% -д ахиу, 15.4%-д дунджийн орчим хур тунадас орсон бөгөөд Ховд, Говь-алтай, Баянхонгор,

Өмнөговь, Дорноговь аймгуудын ихэнх хэсгээр олон жилийн дунджаас 40-80%-иар бага хур тунадас орсон байна.



Зураг 57. 2022 оны улирлын нийлбэр хур тунадасны олон жилийн дундаж-аас (норм 1991-2020 он) хазайх хазайлт


Сүүлийн 5 жилийн сар бүрийн нийлбэр хур тунадасны олон жилийн дунджаас хазайх хазайлтын утгыг харьцуулж үзэхэд (зураг 6) 2022 оны 2, 4, 5, болон 8, 9 дүгээр саруудад дунджаас 10-40% -иар бага 3, 6, 7, 10, 11 дүгээр саруудад дунджийн орчим, 1, 12 дугаар саруудад 10-40% хувиар ахиу тунадас орсон байна.



Зураг 58. 2018-2022 оны сарын нийлбэр хур тунадсыг олон жилийн дундажтай (норм 1981-2010 он) харьцуулсан утга

### ЭКСТРЕМАЛЬ УТГУУД

2022 онд температурын үнэмлэхүй их утга Баянхонгорын Эхийн голд агаарт 40.0°C, Дорнодын Халхголд хөрсөн дээр 71°C хүрч халсан бол үнэмлэхүй бага утга Завханы Баян-Уул суманд агаарт -46.8°C, Отгонд хөрсөн дээр -50°C хүрч хүйтэрсэн байна. Нэг хоногт хамгийн ихдээ Хэнтийн Биндэр суманд 6 дугаар сарын 04-нд 61.9 мм тунадас оржээ. Даралтын үнэмлэхүй их утга Сэлэнгийн Сүхбаатарт 965.1 гПа, бага утга Баянхонгорын Баянбулагт 756.8 гПа хүрч тус тус ажиглагдсан. Салхины хурдны үнэмлэхүй их утга Төв аймгийн Баянчандмань суманд 40 м/с хүрсэн байна.




Зураг 59. Тус жилд ажиглагдсан экстремаль утгууд

### ЦАСАН БҮРХҮҮЛИЙН ЗУЗААН

Монгол орны хэмжээнд 2022 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар нийт нутгийн 70 гаруй хувьд цастай байгаагаас Алтай, Хангай, Хэнтэй, Хөвсгөлийн өндөрлөг уулсаар 20.1 см-ээс их, Увсын Давст, Улаанбаатарын Багануур, Төвийн Эрдэнэд 22-26 см, Увсын Тэс, Баруунтуруун, Малчин, Хяргас, Ховдын Булган, Алтай, Үенч, Завханы Цагаанчулуут, Баянтэс, Улиастай, Баянхайрхан, Тэс, Баянхонгорын Заг, Хөвсгөлийн Цагаан-Үүр, Алаг-Эрдэнэ, Эрдэнэбулган, Цагаануур, Чандмань-Өндөр, Булганы Хангал, Орхоны Баян-Өндөр, Сэлэнгийн Орхон, Ерөө, Хүдэр, Түшиг, Хушаат, Орхонтуул, Төвийн Мөнгөнморьт, Эрдэнэ, Цээл, Угтаалцайдам, Алтанбулаг, Жаргалант, Хэнтийн Баян-Овоо, Батширээт, Норовлин, Баян-Адрага, Хэрлэн, Цэнхэрмандал, Өмнөдэлгэр, Жаргалтхаан, Сүхбаатарын Асгат, Дорнодын Булганд 10.1-20.0 см, Увс, Завхан, Баянхонгор, Өвөрхангай, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Дархан-

Уул, Орхон, Төв, Хэнтий, Сүхбаатар, Дорнодын зарим, Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Архангайн ганц нэг сумдын нутгаар 5.1-10.0 см, бусад нутагт 1-5 см, гуу жалга, хунгарласан газартаа 15-30 см зузаан цастай байна.



Зураг 60. 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар цасны зузаан (см)

### ЦАГ АГААРЫН АЮУЛТАЙ БОЛОН ГАМШИГТ ҮЗЭГДЭЛ

2022 онд улсын хэмжээнд 85 цаг агаарын гаралтай аюулт болон гамшигт үзэгдэл болсноос аюултай үзэгдэл 64, гамшигт үзэгдэл 9 удаа болж, үүний улмаас 4 хүн амь насаа алдаж 7402 толгой мал хорогдож, 2 удаа төмөр зам, 1 удаа авто зам эвдэрч, 330 гэр, байшин нурж, 42 хашаа нурж, 110 барилгын дээвэр хуурч, 9 холбооны шон унасан ба 2795 га тариалангийн талбай өртсөн бөгөөд улс нийгэмд 2 тэрбум 358 сая 404 мянган төгрөгийн шууд хохирол учирсан байна.

2022 онд нийт 9 төрлийн аюулт, гамшигт үзэгдэл болсноос хүчтэй салхи шуурга болон уруйн үер, аадар бороо, мөндөр хамгийн олон удаа болсон бөгөөд нийт аюулт, гамшигт үзэгдлийг харгалзан 14-27%-ийг эзэлсэн байна.

Хамгийн их хохирол учруулсан фронтын гаралтай аюултай үзэгдлийг дурьдвал:

2022 оны 04 дүгээр сарын 24-25-ны өдрүүдэд баруун аймгуудын нутаг Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд аймгийн нутгаар хүчтэй салхи, шороон шуурга шуурч байгаль цаг агаарын аюулт үзэгдэл ажиглагдаж ихээхэн хэмжээний хохирлыг учруулсан. Цаг агаарын аюултай үзэгдлийн улмаас 5 аймгийн 7 суманд нийт 10 гэр, 17 хашаа нурж, 14 том жижиг нийлсэн байшингийн дээвэр хуурч, өндөр хүчдэлийн 3 шон, хашааны цементэн 4 шон унасан. Урьдчилсан байдлаар 67 орчим сая төгрөгийн хохирол учирсан байна.

## МАЛ, АМЬТНЫ ГОЦ ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ГАРАЛТ, ТАРХАЛТ, ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ, ҮР ДҮН

Монгол улсад 2022 онд мал, амьтны гоц халдварт шүлхий, бог малын мялзан, хонины цэцэг, үхрийн арьс товруутах зэрэг 4 төрлийн гоц халдварт өвчний нийт 562 голомт бүртгэгдэж 370,645 толгой мал ил шинж тэмдэгтэйгээр өвчилсөн байна.

Хүснэгт 7 Гоц халдварт өвчний гаралт 2018-2022 он

	2018				2019				2020				2021				2022			
	Аймаг тоо	Сум тоо	Голомт тоо	Өвчилсөн малын тоо	Аймаг тоо	Сум тоо	Голомт тоо	Өвчилсөн малын тоо	Аймаг тоо	Сум тоо	Голомт тоо	Өвчилсөн малын тоо	Аймаг тоо	Сум тоо	Голомт тоо	Өвчилсөн малын тоо	Аймаг тоо	Сум тоо	Голомт тоо	Өвчилсөн малын тоо
Шүлхий	7	31	25	11,190	4	5	7	348	3	3	3	22	20	170	301	147,337	20	204	462	359,836
Бог малын мялзан	3	5	5	1,280	2	2	2	122	-	-	-	-	6	18	36	5,038	9	44	64	8,160
Хонины цэцэг	1	1	1	114	1	1	1	47	-	-	-	-	3	4	4	277	3	11	15	903
Гахайн африкийн мялзан	-	-	-	-	11	16	30	3,575	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Үхрийн арьс товруутах өвчин	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	3	20	60	2,682	5	11	21	1,746


Дээрх мэдээллээс харахад шүлхий өвчин жил бүр, бог малын мялзан, хонины цэцэг өвчин 2020 оноос бусад жил, гахайн африкийн мялзан өвчин 2019, үхрийн арьс товруутах өвчин 2021-2022 онд бүртгэгдсэн байна. Гахайн африкийн мялзан (2019), үхрийн арьс товруутах (2021) өвчин шинээр бүртгэгджээ.

Өвчин жил бүр гараад байгаа нь дараах хэд хэдэн хүчин зүйлээс хамааралтай байна. Үүнд:

- малын тоо жил бүр нэмэгдэж байгаа (2010 онд 32,7 сая 2022 онд 71,1 сая);
- байгаль цаг агаарын гамшигт үзэгдэл (ган, зуд), бэлчээрийн доройтол нэмэгдэж байгаа, машин техник, холбоо харилцаа сайжирснаас үүдэлтэй бүс, аймаг дамжсан хүн, малын шилжилт хөдөлгөөн харьцангуй ихэссэн;
- малчид иргэдийн хариуцлага суларсан;
- мал эмнэлгийн салбарын чадавх хангалттай бүс зэрэг олон хүчин зүйлээс хамааралтай байна.


### Шүлхий:

Монгол улсад уг өвчний тохиолдол 2022 онд нийт 20 аймгийн 204 суманд нийт 462 голомт бүртгэгдэж 359,836 толгой мал ил шинж тэмдэгтэйгээр өвчилснөөс 708 толгой мал үхэж, хорогдон 359,128 толгой малын шинж тэмдэг бүрэн арилсан байна. Шүлхий өвчний гаралт 2021 оны 12-р сараас 2022 оны 01-р арын 01-ний өдрүүдэд нийт 16 аймгийн 92 сумын 151 голомтод хорио цээрийн арга хэмжээ үргэлжлэн хэрэгжиж байсан болно.



Зураг 61. 2021-2022 онд үргэлжилсэн голомтын зураглал

Энэ нь 2021-2022 онд шилжих шинэ жил, 2022 оны 02-р сард тохиосон уламжлалт цагаан сар зэргийн үед хүн малын бөөгнөрөл, шилжилт хөдөлгөөн ихэссэн үеэр шүлхий өвчний гаралт огцом нэмэгдсэн болохыг харуулж байна (Хүснэгт 7). Отор, нүүдэл, шилжилт хөдөлгөөнийг хянах, хорио цээрийн дэглэмийг хэрэгжүүлэхэд мал эмнэлгийн байгууллага дангаар зохион байгуулахад хүндрэлтэй бөгөөд ОБЕГ, цагдаа хүчний байгууллагуудын оролцоог түлхүү оролцуулан хэрэгжүүлэх шаардлагатай болохыг харуулж байгаа тул УОК-д асуудал оруулан хамтарч хэрэгжүүлэх саналыг удирдлага, холбогдох байгууллагуудад уламжилж тэмцэх арга хэмжээг хамтран хэрэгжүүлсэн нь тодорхой үр дүнд хүрсэн ажил байв.



Зураг 62. Шүлхий өвчний тархварзүйн муруй

Дээрх тархварзүйн үечлэлээс харахад 2022 онд шүлхийн 2 удаагийн томоохон дэгдэлт гарсан бөгөөд хамгийн том дэгдэлт нь 1,2 дугаар сард улсын хэмжээнд бүх аймгуудад халдвар бүртгэгдээгүй сумдад дамжин тархсан. Хүйтэн сэрүүний улиралд халдваргүйтгэл хийх боломж хязгаарлагдмал, дархлаажуулалтад шаардагдах вакцины нөөцийг бүрэн бүрдүүлээгүй, хорио цээрийн арга хэмжээг чангатган хэрэгжүүлэх, халдварын хүрээг хязгаарлах дархлаажуулалтын арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатай үүссэн байна.

Шүлхий өвчний гаралт 2021-2022 онд нийт 20 аймгийн 204 сумын нутаг дэвсгэрийг хамран тархсан хүндрэлтэй нөхцөл байдал, вакцины хязгаарлагдмал




нөөц зэргийг харгалзан сүргийн дунд халдвар тархаах хамгийн өндөр идэвхтэй мал болох үхэр, гахай, цаа бугын сүргийг хамруулан хавар, намар 2 удаагийн давтамжтайгаар дархлаажуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх шийдвэрийг гарган ажиллажээ.



Зураг 63. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөлт

ОХУ-ын үйлдвэрлэгчтэй 2021 оны 12-р сард байгуулсан 83/12 дугаартай гэрээний дагуу 4 цуврал бүхий 9,8 тэрбум төгрөгийн өртөг бүхий нийт 12,0 сая тун вакциныг хүлээн авч дархлаажуулалтад шаардагдах вакцины нөөцийг бүрдүүлсэн.

Шүлхий өвчний сүргийн төвшний халдварлалтыг тогтоох тандалт судалгааг улсын хэмжээнд гүйцэтгэсэн байна.




Зураг 64. Халдвар илрүүлэх тандалтын сорьц бэлтгэсэн байршил

Халдварлалтын хувь буюу шүлхийн тархалтын түвшинг улсын хэмжээнд гаргахад 33.1% (95% -ийн үнэн магадтай: 28-36%) -тай байна. Энэ нь 3 хот айл тутмын 1, 12 мал тутмын 1 халдвартай байна гэдгийг илтгэнэ. Энэхүү ийлдэс судлалын лабоарторийн шинжилгээ нь Монгол улсын хэмжээнд шүлхийн өндөр халдварлалттай (тархалттай) байгааг нотолж байна.

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг өвчний

гаралтын нөхцөл байдалтай холбоотойгоор 2 үешаттайгаар зохион байгуулсан.

Эхний ээлжинд өвчний голомтыг хумих, улсын хэмжээнд тархалтыг зогсоох зорилгоор МЭГ-ын даргын тушаалаар зорилгоор 17 аймагт нийт 1,4 сая тун вакциныг 2022 оны 03 дугаар сард хуваарилан олгож эрсдэлд суурилсан дархлаажуулалтын арга хэмжээг 2022 оны 03-04 дүгээр сард нийт 17 аймгийн 62 сумын 2,2 сая толгой мэдрэмтгий мал, амьтан хамруулан 95,8 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн байна.




Зураг 65 Дархлаажуулалтын зураглал

**Хонины цэцэг:**

ОХУ-ын манай улстай хил залгаа мужууд болон БНХАУ-д уг өвчний гаралт бүртгэгдээгүй бөгөөд Монгол улсад 2021, 2022 онд зүүн бүсийн Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгуудын уулзвар орчмын сумдад давтан оношлогдож байгаа нь энэ өвчинтэй тэмцэх арга хэмжээг хууль, журам, зааврын дагуу хэрэгжүүлээгүй, голомтыг бүрэн таслан зогсоогоогүй зэрэг нөхцөл байдлын улмаас эндемик гэж хэлж болохоор тасралтгүй дотооддоо гарсаар байгааг харуулж байна.

Хонины цэцэг өвчин зүүн болон төвийн бүсийн 4 аймгийн 10 сумын 15 голомтод 903 толгой хонь өвчилсөн. Өвчний тохиолдол Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Төв аймгийн нутагт оношлогдсон.



Зураг 66. Хонины цэцэг өвчний гаралтын зураглал


Урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээ: Уг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээнд “Биокобинат” ТӨХХК-д үйлдвэрлэсэн 2021 оны нөөц, 2022 онд худалдан авсан 165,0 сая төгрөгийн өртөг бүхий 3,0 сая тун вакцинаар дархлаажуулалтын арга хэмжээг хэрэгжүүлсэн.

Хонины цэцэг өвчний гаралт Монгол Улсын зүүн бүсийн Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудын үулзвар сумдад орогномол байдлаар эргэлдсээр байгаа тул цаашид устгал болон хорио цээр, халдваргүйтгэлийн арга хэмжээг эрчимжүүлэх, дархлаажуулалтын арга хэмжээг өргөн хүрээтэй хэрэгжүүлэх шаардлага тулгараад байна. Вакцины үйлдвэрлэлийн хугацаа хойшлогдсон, бусад өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа давхардсан зэрэг нөхцөл байдлын улмаас вакцин таригдах хугацаа 10 дугаар сард хойшлогдсон байна.

Дархлаажуулалтын арга хэмжээнд нийт 4 аймгийн 14 сумын 4,661 өрхийн 2,3 сая толгой мэдрэмтгий мал сүргийг хамруулсан.

#### **Бог малын мялзан:**


Монгол Улсад бог малын мялзан өвчин 2021 онд говийн бүсийн аймгуудад гарч байсан бол 2022 онд урьд жилүүдэд дархлаажуулалт хийгдэж байгаагүй төвийн бүсийн аймгуудыг хамран нийт 12 аймгийн 54 суманд 99 голомтод 292 өрхийн 13,909 толгой мал ил шинж тэмдэгтэйгээр өвчилж, 3,453 толгой мал үхэж, устгасан байна. Өвчний гаралт 2021 оны сүүлээр намжмал байдалд орсон ч 2022 оны 03-р сараас дахин говийн болон төвийн бүсийн аймгууд улмаар 08 дугаар сараас хангайн бүсийн аймгуудад тархан гарсан.




Зураг 67. Тархварзүйн муруй

Уг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад шаардлагатай вакцины худалдан авалтыг 2021 онд хийгээгүй, вакцины нөөц бүрдүүлж

чадаагүй зэрэг нөхцөл байдлаас шалтгаалан 2022 оны 07-р сар хүртэл өвчний гаралтыг хязгаарлах дархлаажуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх боломж бүрдээгүйгээс өвчлөл аймаг, сум дамжин тархах эрсдэлийг үүсгэсэн.



Зураг 68. Баримжаалсан тархалт (2022.06)



Зураг 69. Баримжаалсан тархалт (2022.10)

Дээрх зураглалаас харахад өвчний тархалт 06-р сард говийн бүсийн аймгуудад өргөн тархалттай байсан бол 10-р сараас төв болон ханган бүсийн аймгуудад дамжин тархсан болох нь харагдаж байна.

Өвчний гаралт 2022 оны 12-р сарын байдлаар нийт 8 аймгийн 16 сумын 21 голомтод 5,865 толгой мал өвчилж, 1,666 толгой малыг устгаж, 2,574 толгой мал тусгаарлалтад байна.

Аймаг нэрс	Өвчлөл бүртгэгдсэн сурдан нэрс	Голом тус	Оршил тус	Өвчлөл анх бүртгэгдсэн өдөр	Хамгийн сүүлч өвчлөл бүртгэгдсэн өдөр	Өдөрт хэмжээ	Хонь	Хурга	Ямаа	Ишг	Өвчлөсөн нийт малын тоо толгой	Тусгаарлалт өнд	Үхэл, хоргодсон, устгасан	Шөвж тэвдэг арилсан	Дэглэм
Архангай	Жаргалант	1	7	12/09/2022	12/30/2022	2	139		49	28	216	150	66	0	Хорио цээр
Архангай	Цэндэрэг	3	30	09/29/2022	12/23/2022	515	268	271	797	408	1744	729	733	282	Хорио цээр
Архангай	Ордажмандан	1	1	12/14/2022	12/26/2022		22	23	31	20	96	50	42	4	Хорио цээр
Булган	Баян-Агт	4	29	12/06/2022	12/30/2022	17	50	254	366	487	1157	827	118	212	Хорио цээр
Булган	Сайхан	1	8	12/15/2022	12/30/2022	8		53	27	37	117	82	30	5	Хорио цээр
Булган	Орхон	1	3	12/17/2022	12/30/2022	27	2	5	37	33	77	30	6	41	Хорио цээр
Дорноговь	Айраг	1	4	12/09/2022	12/26/2022		22	46	32	320	420	0	19	401	Хорио цээр
Дорноговь	Сайнцагд	1	3	12/14/2022	12/26/2022			45		188	233	92	87	54	Хорио цээр
Дундговь	Говь-Утгаал	1	1	09/01/2022	11/22/2022			1	2	20	23	0	2	21	Холгоорлалт
Дундговь	Дэлгэрцэцэг	1	1	12/30/2022	12/30/2022	18		2	16	18	19	1	7	7	Хорио цээр
Өвөрхангай	Хамбо	1	2	12/13/2022	12/16/2022			3		20	23	0	9	14	Хорио цээр
Өвөрхангай	Манлай	1	10	12/16/2022	12/26/2022		3		21	424	448	291	0	157	Хорио цээр
Сүхбаатар	Түвшинтэрээ	1	1	11/17/2022	11/23/2022			8	3	6	17	0	17	0	Холгоорлалт
Сэлэнгэ	Сайхан	1	1	11/19/2022	11/25/2022		6	10	19	47	82	0	82	0	Холгоорлалт
Сэлэнгэ	Бэрүүнбуран	2	3	11/25/2022	12/01/2022			27	5	33	65	0	65	0	Холгоорлалт
Хэнтий	Баянбулаг	1	1	12/17/2022	12/19/2022			6		7	13	0	13	0	Хорио цээр
Хөвсгөл	Тосгондигал	1	7	10/28/2022	12/30/2022	19	47	25	55	31	156	41	49	68	Хорио цээр
Хөвсгөл	Иш-Уул	1	2	12/02/2022	12/30/2022	85	104	55	200	112	471	255	72	144	Хорио цээр
Хөвсгөл	Төмөрбулаг	1	6	12/19/2022	12/30/2022	7	44		174	38	256	17	24	215	Хорио цээр
Увсхангай	Хан-Уул	1	1	11/19/2022	12/08/2022		34		197		231	0	231	0	Хорио цээр
<b>Нийт</b>		<b>20</b>	<b>26</b>	<b>132</b>			<b>671</b>	<b>741</b>	<b>832</b>	<b>2017</b>	<b>2275</b>	<b>5865</b>	<b>2574</b>	<b>1666</b>	<b>1625</b>

Хүснэгт 8. Өвчний гаралт, хорио цээрийн мэдээлэл

**Урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээ, үр дүн:** Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцины худалдан авалт 2021 онд хийгдээгүй. Үүний улмаас голомтыг хумих, халдвар тархахаас урьдчилан сэргийлэх вакцины нөөцгүй тул уг өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зааврын дагуу шинж тэмдгийн эмчилгээ хийж, хорио цээрийн болон халдваргүйтгэлийн арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан.

Дэлхийд бог малын мялзан өвчнийг 2030 онд устгах хөтөлбөр гарган ажиллаж байгаатай уялдуулан ХХААХҮ-ийн сайдын 2022 оны А/204 дүгээр тушаалаар “Бог малын мялзан өвчинтэй тэмцэх стратеги”-ийг баталгаажуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. Дээрх Дэлхийн болон Монгол улсын стратегид зааснаар өвчлөл гарсан бүс нутгийн мэдрэмтгий мал сүргийг 2 жил толгой дараалан дархлаажуулж, 3 дахь жилээс төл малыг дархлаажуулах байдлаар урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан. Энэ стратегийн дагуу сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд 25-30,0 сая тун вакцин шаардагдахаар тооцоо гаргасан байна.

## 3.2. ГАЛ ТҮЙМРИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

### 3.2.1. Объектын гал түймэр

Улсын хэмжээнд 2022 онд 2918 удаагийн дуудлага бүртгэгдэж өмнөх оноос 16.7 хувиар өссөн, гал түймэрт 39 хүн өртөж нас барсан, том хүн 35, хүүхэд 4 өртсөн байна. Нас барсан хүний тоог өнгөрсөн онтой харьцуулбал 36 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

2022 онд улсын хэмжээнд объектын гал түймрийн 2918 тохиолдол

бүртгэгдсэнээс 2303 дуудлагад гал түймэр унтраах, аврах анги ажиллаж унтраасан бол, зөрчилийн дуудлага 411, мэдээлэл 204 удаа бүртгэгдсэн. Гал түймрийн аюулаас 2499 хүний амь насыг, иргэд, аж ахуйн нэгж байгууллагын 189 тэрбум төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгааллаа. Аварсан хүний тоог өнгөрсөн онтой харьцуулбал 33,1 хувиар, аварсан хөрөнгө 9,7 хувиар буурсан, 2022 онд гал түймрийн улмаас 22,5 тэрбум төгрөгийн хохирол учирсан, хохирлыг өнгөрсөн онтой харьцуулбал 70 хувиар өссөн байна.

Гал түймэр гарсан шалтгаан нөхцлийн хувьд ил гал, цахилгаан угсралт, ашиглалтын буруугаас, пийшин зуух, яндангийн цонолтоос үүдэж гарсан гал түймэр дийлэнх хувийг буюу 70 орчим хувийг эзэлж байна.

### **3.2.2. Ой, хээрийн гал түймэр**

Улсын хэмжээнд 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн байдлаар Архангай, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорнод, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий зэрэг 16 аймгийн 75 суманд 174 удаа, Нийслэлийн 4 дүүрэгт 5 удаа, нийт 179 удаагийн ой, хээрийн гал түймэр бүртгэгдсэн.

Ой, хээрийн гал түймрийн дуудлагын тоог 2021 оны мөн үетэй харьцуулахад 68 %-иар өсөж, дээрх түймэрт урьдчилсан байдлаар ойн 16,401 га, хээрийн 1,16,694 га, нийт 1,183,322 га талбай түймэрт өртсөн байна. Түймэрт өртсөн нийт талбайн хэмжээг 2021 оны мөн үетэй харьцуулахад 63%-иар өссөн байна.

Монгол Улсаас БНХАУ-руу Дорнод аймгийн Матад, Халх гол сумаар тус бүр 1 удаа, Чойбалсан сумаар 2 удаа, Сүхбаатар аймгийн Дарьганга сумаар 1 удаа, нийт 5 удаа, Монгол Улсаас ОХУ-руу Сэлэнгэ аймгийн Алтанбулаг 1 удаа, Завхан аймгийн Баянтэс сумаар тус бүр 1 удаа, нийт 7 удаагийн ой, хээрийн гал түймэр Монгол Улсын хил давж гарсан.

ОХУ-аас Монгол Улс руу Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумаар 1 удаа, Завхан аймгийн Баянтэс сумаар 1 удаа, нийт 2 удаагийн ойн түймэр хил давж орж ирсэн.

Ой, хээрийн түймэр унтраах ажиллагаанд Онцгой байдлын байгууллагын 2372 алба хаагч, 258 автомашин, Зэвсэгт хүчний 21 алба хаагч, Хил хамгаалах байгууллагын 490 алба хаагч, 70 автомашин, 40 морь, Цагдаагийн байгууллагын 66 алба хаагч, 28 автомашин, орон нутгаас 4931 иргэн, 749 автомашин, 171 мотоцикл, 83 морь, нийт 7880 хүн, 1105 автомашин, 171 мотоцикл, 123 морьтой ажилласан.

ЗХЖШ-ын МИ-171 нисдэг тэргээр 1 удаа /Булган аймгийн Тэшиг/, Агаараас эрэн хайх, аврах 111 дүгээр ангийн ЕС-145 нисдэг тэргээр 9 удаа /Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сум Минжийн застав/, нийт 10 удаагийн нислэг үйлдсэн байна.

### **3.2.3. Урьдчилан сэргийлэх, хяналт шалгалт**

Улсын хэмжээнд 2022 онд Монгол Улсын Шадар сайдын баталсан 4, Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан 5 удирдамжит төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгууллаа. Хяналт шалгалтад 17,923 аж ахуйн нэгж байгууллагын объект, 362,015 айл өрхийг хамруулан 109,872 зөрчлийг илрүүлж, илрүүлсэн зөрчлийн 55.6 хувь буюу 61,159 зөрчлийг газар дээр нь арилгуулж, зөрчлийг арилгуулахаар гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 5293, мэдэгдэл 5094, танилцуулга 192, зөрчлийн тэмдэглэл 1567 боловсруулж иргэн, хуулийн этгээдэд хүргүүлж галын аюулгүй байдлыг хангуулан ажилласан байна. Хяналт шалгалтад хамруулсан айл өрх, объектын тоог өнгөрсөн онтой харьцуулбал 90 хувь, арилгуулсан зөрчлийн тоо 44.2 хувь өссөн үзүүлэлттэй байна.

Гал түймрийн улсын хяналтын байцаагч нар 7 хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоож, нийт 256.137.000 сая төгрөгийн торгуулийн шийтгэл оногдуулж, нийт 1490 Барилгын зураг төсөл хянаж, Улсын комисст 2696 удаа тус тус ажилласан байна.

ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ.  
**ХОР УРШГИЙГ АРИЛГАХ,  
СЭРГЭЭН БОСГОХ АЖИЛЛАГАА**




#### 4.1. Улсын нөөц хүмүүнлэгийн тусламж

Монгол Улсын хэмжээнд 2022 онд тохиолдсон хүчтэй цасан болон шороон шуурга, үер усны улмаас орон гэргүй болсон айл өрх, иргэд болон аж ахуйн нэгж, байгууллагад учирсан хохирлыг арилгах, коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх тэмцэх, төрийн болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээг шүүрхай үзүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 407, 461 дугаар бүхий 2 удаагийн тогтоолоор улсын нөөцөөс бараа, материал олгох ажлыг зохион байгууллаа.

Улсын нөөцөөс зарцуулсан бараа, материалыг төрөл тус бүрээр нь авч үзвэл:

- 929,6 сая төгрөгийн 1,171 тонн өвс,
- 6.7 тэрбум төгрөгийн 8,024 тонн тэжээл,
- 48 сая төгрөгийн цахилгаан үүсгүүр,
- 1.9 тэрбум төгрөгийн УАЗ маркийн машин,
- 1.1 тэрбум төгрөгийн тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл,
- 334.8 сая төгрөгийн иж бүрэн гэр
- 48,6 сая төгрөгийн халдвар хамгааллын хэрэгсэл
- 2.1 тэрбум төгрөгийн техник хэрэгсэл,
- 2,2 тэрбум төгрөгийн газрын тосны бүтээгдэхүүн нийт 15.3 тэрбум төгрөгийн бараа, материал техник хэрэгслийг зарцуулж хүмүүнлэгийн тусламж үзүүлжээ.

УОК-ын 2022 оны 05 дугаар хуралдааны шийдвэрийг үндэслэн дизель түлний нийлүүлэлт тасалдах эрсдэлд орсон “Багануур” ХК, “Шивээ Овоо” ХК, “Шарын гол” ХК, “Монкоул Петро Майнинг” ХХК-д нийт 463.08 тонн дизель түлшийг улсын нөөцөөс олгов.



Зураг 70. Гамшиг ослын хор уршгийг арилгахад зарцуулсан зардал

Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхтэй холбогдуулан 2022 онд 11,5 сая төгрөгийн /500 ширхэг хамгаалах

хувцас/ хандивын бараа ирүүлсэн бөгөөд 2021 онд ирүүлсэн хандиваас 188 сая төгрөгийн бараа, материалын үлдэгдэлтэй буюу өнөөдрийн байдлаар нийт 199,5 сая төгрөгийн хандив, тусламжийн бараа, материалын үлдэгдэлтэй байна.

Улсын нөөцийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш /2007 он/ улсын нөөцийн харилцаа, зохицуулалттай уялдсан Монгол Улсын бусад хууль, УИХ, ЗГ-ын тогтоол түүнчлэн эрх бүхий албан тушаалтны шийдвэрүүдийг хамруулан нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх, хадгалах, тээвэрлэж хүргэх, шинэчлэх, захиран зарцуулах, санхүүжүүлэхтэй холбогдсон харилцааны эерэг, сөрөг үр дагавар, холбогдох нөхцлийг тогтоож, тэдгээрийг хооронд нь харьцуулах ажиллагаан дээр үндэслэн Улсын нөөцийн тухай хуулийн 4 бүлэг 19 зүйлд хэрэгжилтийн үр дагаварт үнэлэлт, дүгнэлт хийжээ.

Нийгэм, эдийн засгийг тогтвортой байлгах, үндэсний аюулгүй байдал, хүн амыг хангахад зориулагдах болон гамшиг, эдийн засгийн хүндрэл бэрхшээл зэрэг онцгой байдлын үедашиглах улсын нөөцийн бараа, материалын байршил, нэр төрөл, тоо хэмжээг шинэчлэн батлуулахаар боловсруулсан байна.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 7.3.15-д “Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалт, хүч хэрэгслийн бэлэн байдлыг сайжруулж, гамшгийн голомтод эрэн хайх, аврах, хор үршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох чадавхыг бэхжүүлнэ” гэж, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 7.3.4, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.14-т Үндэсний аюулгүй байдлыг хангах үүднээс стратегийн зориулалттай нөөцийн бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлж, бараа, материалын хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, хөргүүр бүхий автоматжуулсан махны зоорь, хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалт бүхий иж бүрэн механикжуулсан агуулах, газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах зориулалттай агуулахын цогцолбор байгуулна” гэж тус тус заасны дагуу дээрх 2 төслийн газар, зураг төсөв, холбогдох техникийн нөхцөл, ТЭЗҮ зэрэг шаардлагатай баримт бичгүүдийг боловсруулан санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэхээр саналыг холбогдох талуудад хүргүүлээд байна.

## **4.2. УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

2022 онд Улсын онцгой комисс нь Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, хүний эрхэд тодорхой хязгаарлалт хийх, холбогдох шийдвэрийг шуурхай гаргах, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, зохион байгуулалтын асуудлыг Засгийн газар онцгой журмаар шийдвэрлэхтэй холбогдуулан Улсын онцгой комисс дараах бодлогын баримт бичгийг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллажээ.



Зураг 71. Улсын онцгой комиссын ээлжит хуралдаан

Халдварын тархалтын сүүлийн үеийн нөхцөл байдалтай холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 66 дугаар тогтоолоор гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлыг зэргийг цуцалж, "Хилийн боомтын талаар авах арга хэмжээний тухай" 2021 оны 386 дугаар тогтоол, "Хилийн зарим боомтыг түр хаах, нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлах тухай" 2020 оны 39 дүгээр тогтоолыг 2022 оны 67 дугаар тогтоолоор тус тус хүчингүй болгов.

#### **Улсын онцгой комиссын шуурхай штабын оператив бүлгийн үйлжиллагаа**

Монгол Улсын Шадар сайд Улсын онцгой комиссын Нэгдсэн шуурхай штабын бүтцийг 2022 оны 03 дугаар тушаалаар оператив бүлгийн зохион байгуулалтад шилжүүлж улсын хэмжээнд хүн, малын болон нийгмийн халдварт өвчнийг бууруулах, төв орон нутгийн шуурхай штаб, холбогдох мэргэжлийн байгууллагуудыг мэдээлэл, хяналт удирдлага, зохицуулалтаар хангах зорилгоор үүрэг гүйцэтгэжээ.

#### **Коронавируст халдвар (КОВИД-19)-ын нөхцөл байдал:**

Улсын хэмжээнд тохиолдлын тодорхойлолтын дагуу нийт батлагдсан тохиолдол 1007400 болж, батлагдсан тохиолдлын 560,281 (55.6%) нь Улаанбаатар хотод бүртгэгджээ.

**Хүүхдийн өвчлөл:** 2022 оны 12-р сарын 27-ны өдрийн байдлаар Монгол улсад коронавируст халдвараар 0-17 хүртэлх насны 1 шинэ тохиолдол бүртгэгдэж, нийт 218419 тохиолдол бүртгэгдсэн ба нийт тохиолдлын 21.7%-ийг эзэлжээ.

Насны бүлгээр харьцуулахад 0-4 нас 27.6%, 5-11 нас 44.4%, 12-15 нас 19.6%, 16-17 нас 8.4% тус тус эзэлж байна.

Улсын хэмжээнд 2022 оны 12 дугаар сарын 23-ны байдлаар КОВИД-19-ийн эсрэг вакцины зорилтот бүлгийн 1-р тунгийн хамралт 89,6 хувь, 2-р тунгийн хамралт 85,7 хувь, 3-р тунгийн хамралт 53,7 хувь, нийт хүн амын 1-р тунгийн хамралт 68,9 хувь, 2-р тунгийн хамралт 66,0 хувь, 3-р тунгийн хамралт 32,0 хувь байна.

Өссөн дүнгээр 3-р тунд 1,058,930 хүн, 4-р тунд 139,638 хүн хамрагдсан

байна. Өссөн дүнгээр 5-11 насны 3,454 хүүхэд, 12-15 насны 158,950\*\* хүүхэд, 16-17 насны 79,547\* хүүхэд, жирэмсэн эмэгтэй 6,428, хөхүүл эмэгтэй 8,020 тус тус 1-р тунд хамрагдаад байна.

2022 онд Улсын онцгой комиссын даргын шийдвэрээр коронавируст “Омикрон” халдварын тархалтаас сэргийлэх, халдварын давалгааг богино хугацаанд даван туулах зорилгоор гадаад орноос 55 удаагийн нислэгээр ирсэн 5266 (монгол 4563, гадаад 703) зорчигчийн 5255 иргэнийг тусгаарлан ажиглах байранд, 11 иргэнийг эмнэлэгт шилжүүлжээ.

**“Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлын үеийн удирдлага, зохион байгуулалт, туршлага, сургамж, цаашдын чиг хандлага” сэдэвт хурал**

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэх, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд гамшгийн бэлэн байдал, тэр дундаа эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдал, салбарын болон салбар дундын уялдаа холбоо, хамтын ажиллагаа, тулгарсан хүндрэл бэрхшээл, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцохоор Онцгой байдлын ерөнхий газар, НҮБ-ын хүүхдийн сан хамтран “КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ТУРШЛАГА, СУРГАМЖ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА” сэдэвт хурал, хэлэлцүүлгийг 2022 оны 10 дугаар сарын 4-ний өдөр зохион байгууллаа.

Тус хуралд хариу арга хэмжээнд оролцсон яам, агентлагууд болон 21 аймгийн Онцгой комиссын төлөөлөл нийт 190 гаруй ажилтан, албан хаагч оролцлоо.



Зураг 72. “Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлын үеийн удирдлага, зохион байгуулалт, туршлага, сургамж, цаашдын чиг хандлага” сэдэвт хурал

Хуралд оролцохоор 15 аймаг, 18 байгууллагаас нийт 33 илтгэл ирүүлсэнээс нийт 13 илтгэл хэлэлцүүлж, хурлаас гарсан санал, дүгнэлт, шийдвэрийг цаашид анхаарах шаардлагатай байна. Үүнд:

Нэг. Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр Улсын онцгой комиссын гишүүд, Эрүүл мэндийн яам, Онцгой байдлын ерөнхий газар:

1.1. Гамшгаас хамгаалах тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль болон бусад салбарын хууль, тэдгээртэй холбогдож гарсан эрх зүйн баримт бичгүүдэд нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн салбар хоорондын зохицуулалтыг оновчтой болгох, уялдаа холбоог сайжруулах;

1.2. Нийгмийн эрүүл мэнд, халдварт өвчинтэй тэмцэх чиглэлээр бие даасан хууль боловсруулж батлуулах, салбарын хуулиудад гамшгийн үеийн зохицуулалтыг тусгах;

1.3. Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний зохион байгуулалт, хэрэгжилтийг үнэлэх журам, шалгуур үзүүлэлт, хяналт-шинжилгээ үнэлгээний аргачлалыг боловсруулж, эрх зүйн орчныг бий болгох;

1.4. Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн салбар хоорондын мэдээлэл солилцох, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах журмыг шинэчлэх;

1.5. Салбаруудын хууль тогтоомжид заасан гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбоотой нэр томъёог нэг стандартад оруулж, нийтэд ойлгомжтой болгох;

1.6. Хөл хорио, хязгаарлалтын үед нийгэм, эдийн засаг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тогтвортой, хэвийн үйл ажиллагааг хангах “Хариуцлагын гэрээ”-ний эрх зүйн орчинг бүрдүүлэх,

1.7. Улсын болон орон нутгийн хэмжээнд гамшгийн эрсдэлийн сантай болох асуудлыг судалж, шийдвэрлүүлэх.

Хоёр. Төлөвлөлт, зохион байгуулалтын чиглэлээр Эрүүл мэндийн яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Онцгой байдлын ерөнхий газар, Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхим, аймаг, нийслэлийн Онцгой комисст:

2.1. Хүн амыг халдварт өвчин, цар тахлаас хамгаалах бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх улс, орон нутгийн төлөвлөгөөг салбар дундын оролцоотой боловсруулж батлуулах;

2.2. Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн хариу арга хэмжээний төлөвлөгөөнд судалгаанд суурилсан нарийвчилсан тодотгол хийж, эрүүл мэндийн байгууллагын чадавхыг бүрдүүлэх чиглэлээр үе шаттай арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх;

2.3. Гамшгийн үеийн удирдлага, зохицуулалтад ослын үеийн удирдлагын системийг нэвтрүүлэх, үйл ажиллагааг тогтвортой байлгахад чиглэсэн шаардлагатай төлөвлөлт, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2.4. Гамшгийн үеийн мэдээллийн урсгалыг сайжруулах, салбар дунд мэдээлэл солилцох цахим мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгох, олон

нийтэд мэдээлэл хүргэх менежментийг боловсронгуй болгох, иргэний нийгмийн болон бизнесийн байгууллагын оролцоог хангах;

2.5. Гамшгийн үед бизнесийн байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах чиглэлээр төлөвлөлт, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх, бизнесийн байгууллагын хөгжлийн стратегид гамшгийн эрсдэлийг тооцох, эрсдэлийг бууруулах чиглэлд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх.

Гурав. Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах чиглэлээр Засгийн газрын яам, агентлаг, Гамшгаас хамгаалах улсын алба, орон нутгийн Онцгой комисст:

3.1. Салбар бүрийн мэргэжлийн боловсон хүчнийг чадавхижуулах, мэргэшүүлэх, тэдгээрийг тогтвор сууршилтай ажиллуулах, бэлтгэл болон шинэ боловсон хүчний судалгааг гаргаж, тогтмол тодотгож, шаардлагатай үед дайчлан ажиллуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх;

3.2. Халдварт өвчинтэй тэмцэх бүтцийг орон нутаг, дүүргийн хэмжээнд бий болгож, хүний нөөцийг сургаж бэлтгэх;

3.3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд гамшгийн үед ашиглах нэн шаардлагатай нөөцийг бүрдүүлэх;

3.4. Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ашиглах шуурхай удирдлагын байр, цартахлын үед ашиглах тусгай зориулалтын байгууламжууд, тэдгээрт шаардлагатай техник, тоног төхөөрөмж, эд зүйлийн нөөцийг бүрдүүлж;

3.5. Хэрэгцээнд суурилсан, богино хугацааны мэргэшил олгох болон хосолмол мэргэжил олгох боломжтой (дайчлагдан ажиллах салбарын мэргэжилтнүүд хамрагдах) нэгдсэн, тусгай сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

3.6. Улс, бүс, аймаг, нийслэлийн хэмжээнд нийгмийн эрүүл мэнд, халдварт өвчний чиглэлээр эрх зүйн баримт бичиг, төлөвлөлт, удирдлага, зохион байгуулалт, нөөц хоорондын зохицол, уялдаа холбоог шалган туршсан сургалт дадлагын ажлуудыг шат дараатай зохион байгуулах.

Хуралд хэлэлцүүлсэн илтгэлийн хураангуйг нэгтгэж, эмхэтгэх гарган Улсын онцгой комиссын гишүүд 21 аймагт хүргүүлж ажиллалаа.

### 4.3. ХӨВСГӨЛ НУУРТ ЖИВСЭН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ ЭРЭН ХАЙХ, ИЛРҮҮЛЭХ, ТАТАН ГАРГАХ АЖИЛЛАГАА

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн санаачлагаар “Хөвсгөл нуурыг хамгаалах” үндэсний чуулганы 4 дүгээр салбар хуралдааныг 2022 оны 3 дугаар сарын 2 дугаар сарын 23-24-ний өдрүүдэд “Төрийн ордон”-д зохион байгуулж зөвлөмж гаргасан. Хөвсгөл нуурыг хамгаалах үндэсний чуулганаас гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэхээр ажлын хэсэг 9 удаа хуралдаж төлөвлөсөн ажлуудаа тодотгож, цаашид хийх ажлуудаа ярилцан шийдвэрлэлээ.



Зураг 73. “Хөвсгөл нуурыг хамгаалах” үндэсний чуулганы IV салбар хуралдаан

Мөн Уул уурхайн гүнд хэмжилт, судалгаа, шинжилгээ хийдэг **“НБАР Инженеринг ХХК”, “Геомастер ХХК”**-тай хамтран ажиллах, санал солилцох уулзалт зохион байгуулж, 2022 оны 3 дугаар сарын 21-27-ны өдрүүдэд живсэн тээврийн хэрэгслийг эрэн хайх, илрүүлэх туршилтийг Шведийн MALA брэндийн Георадарын судалгааны багажаар 240:260 метр талбайд RTA50 мегагерцийн антеннаар хайлт хийхэд объектыг илрүүлэх боломжгүй нь туршилтын ажиллагаагаар тогтоогдсон.




Зураг 74. Шведийн MALA брэндийн Георадарын судалгааны багажаар Хөвсгөл нуурт живсэн тээврийн хэрэгслийг эрэн хайх, илрүүлэх туршилтын ажиллагаа

Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 117 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн 2 дугаар хурал 2022 оны 5 дугаар сарын 30-ны өдөр БХЯ-ны хурлын танхимд зохион байгуулагдсан. Тус хурлаар тээврийн хэрэгслийг эрэн хайх, илрүүлэх, суурь судалгаа хийх, татан гаргах ажлын явцын талаар танилцуулсан.

Монгол Улс, Япон улс хоорондын хамтын ажиллагааны хүрээнд тус улсын “НИППОН САЛВЕЙЖ” группын салбарын захирал ноён АРАКИ ВАТАРУ ажлын хэсгийн гишүүдэд Хөвсгөл нуурт ажилласан талаарх мэдээлэл өгсөн.



Зураг 75. Хөвсгөл нуурт живсэн тээврийн хэрэгслийг татан гаргах тооцоо боловсруулах, туршилт судалгааны ажил



Зураг 76. Суурь судалгааны ажлын явцын талаар

ОБЕГ-ын захиалгаар “Геомастер” ХХК 2022 оны 7 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн Хөвсгөл нуурт живсэн тээврийн хэрэгслийг эрэн хайх, илрүүлэх, суурь судалгааны ажлыг хийж, урьдчилсан байдлаар 5 объектын загвар, байршил зэргийг тогтоосон.


Хөвсгөл нуурт живсэн тээврийн хэрэгслийг татан гаргах инженерийн тооцоо, туршилт судалгааны ажлын хүрээнд 2022 оны 10 дугаар сарын 26-30-ны өдрүүдэд Хөвсгөл аймагт ажиллаж, татан гаргах газар орны байршил, усаар болон хуурай газраар тээврийн хэрэгсэл хөдөлгөөн үйлдэх боломжит



хувилбар, ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө, техник хэрэгслийг татан гаргах ажиллагааны инженерийн шийдэл, гаргахад зориулсан нэгдсэн тооцоолол, туршилт хийх санал, дүгнэлт зэргийг ОБЕГ-ын даргаар батлуулав.



Зураг 77. Батлан хамгаалахын сайдын 2021 оны А/199 дүгээр тушаалаар байгуулагдсан дэд ажлын хэсгийн хурал



Зураг 78. Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 117 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн хурал

Тус хурлаар Хөвсгөл нуурт живсэн тээврийн хэрэгслийг татан гаргах ажиллагааны бодлого, төлөвлөлт, инженерийн тооцоолол, технологийн шийдлийн талаар хэлэлцэж, үүрэг чиглэл өглөө.

Цаашид шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг олон улсын байгууллагуудтай хамтран худалдан авах ажиллагааг зохион байгуулж, живсэн тээврийн хэрэгслийг эрэн хайх, илрүүлэх, судалгааны ажлыг үргэлжлүүлэн татан гаргах ажиллагааг үе шаттай зохион байгуулахаар ажиллаж байна.

ТАВДУГААР ХЭСЭГ.

**НЕФТИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ  
АГУУЛАХАД ГАРСАН  
ГАЛ ТҮЙМРИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ,  
АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН  
ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ**

## 5.1. Үүссэн нөхцөл байдлын талаар

Дархан сумын 3 дугаар баг “Тэс петролиум” ХХК-ны газрын тосны бүтээгдэхүүний агуулахад дэлбэрэлт үүсэж гал гарч шатаж байна гэсэн дуудлагыг 2022 оны 12 дугаар 01-ний өдрийн 09:21 цагт иргэн Г Онцгой байдлын газрын 7037101 дугаарт ирүүлсэн.

Дуудлагаар тус агуулахын 2000 тонны багтаамжтай АИ-92 шатахуун нөөцлөх босоо ган савны дээр гал түймэр гарахаас өмнө резервуарт хэмжилт хийхээр 3 ажилтан /нягтлан, нярав, харуул/ ажиллаж байсан гэсэн мэдээллийг өгсөн.

## 5.2. Гал түймэр унтраах үйл ажиллагаа, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Дархан-Уул аймгийн Дархан сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Тэс Петролиум” ХХК-ийн газрын тосны бүтээгдэхүүн хадгалах агуулахад 2022 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 09:21 цагт гал гарч дэлбэрэлт болсон тухай дуудлагыг хүлээн авсны дагуу Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газрын гал түймэр унтраах, аврах 22, 54 дүгээр анги, Эрэн хайх аврах бүлэг эхний дуудлагаар гарч үүссэн нөхцөл байдал дээр ажилласан.



Зураг 79 “Тэс Петролиум” ХХК-ын газрын тос бүтээгдэхүүн хадгалах босоо ган савны харагдах байдал

Гал түймэр гарсан тухай анхны мэдээллээр дуудлага 09:21 цагт ирсэн бөгөөд шатаж буй бүтээгдэхүүний хэмжээ – 650тн, унтраах хөөсний нөөц - 800л /аймагт/, резервуарын өндөр 12 метр, 650тн шингэн нь резервуарын 1/3 хувьд дүүрэн, цагт 30 см шатвал 13.3 цаг шатаж дуусна гэж тооцоолсон. Дээрх тооцоолол болон үүсэн нөхцөл байдлыг үнэлэн Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газраас Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газрын гал түймэр унтраах, аврах 19, 36, 40, 61 дүгээр анги, Орхон аймгийн Онцгой байдлын газрын гал түймэр унтраах, аврах 56 дугаар ангиудыг тус тус нэмэлтээр ажиллуулсан.



Зураг 80. Үүсэн нөхцөл байдал дээр ажиллаж байгаа үе

Гал түймэр унтраах, аврах ангиудын томилгоот хуваарьт үүрэг гүйцэтгэж байсан автомашин дахь хөөс үүсгэгч бодисыг ашиглан агаар механикийн хөөсний атак өгсөн боловч хөөс үүсгэгч бодис болон усны нөөц хангалтгүй байсны улмаас тархалтыг зогсоож чадаагүй тул шаардлагатай хүн хүч, бодисын тооцооллыг хийсэн. Үүнд:

### 1. Гал түймрийг унтраахад шаардлагатай хөөс үүсгэгч генераторын хушууны тоог тодорхойлох нь:

$N_{ггс}$  (хөөсний атак явуулахад шаардлагатай хошууны тоо)

$$N_{ггс-600} = S_{ш} * J_{шаар} = 181 * 0.08 = 2,89 \approx 3 / \text{Пурга} - 5 \text{ хушуу} / q_{ггс}$$

Үүнд:  $S_{ш} = 181 \text{ м}^2$  – резервуарын шатах шингэний толин гадаргуугийн талбай;

хөөсний уусмалын эрч ( $J_{ш}$ ) –  $0.08 \text{ л/с} * \text{м}^2$

$q_{ггс}$  – хөөсний хушууны зарцуулалт  $\text{л/с}$

### 2. Шаардлагатай хөөс үүсгэгч бодисын хэмжээг тодорхойлох нь – $V_{хөөс}$

$$V_{хөөс} = N_{ггс} * q_{хөөс ггс} = 3 * 0.36 * 15 * 60 * 3 = 2916 \text{ литр} / \text{шаардлагатай} /$$

$$V_{хөөс} = N_{ггс} * q_{хөөс ггс} = 15 * 0.36 * 3 = 16.2 \text{ л/с} / \text{шаардлагатай} /$$

Үүнд: тнорм /унтраах атак/ = 15 мин – нефть, нефтийн бүтээгдэхүүнд гарсан галыг унтраахад

15 минут тасралтгүй хөөсний атак өгөхөд

$$V_{нийт хөөс} = V_{хөөс} * q_{хөөс ггс} = 16.2 * 900 = 14580 \text{ литр хөөс шаардлагатай.}$$

### 3. Гал түймэр унтраахад шаардагдах хөөсний автомашины тоо

$$N_{ГУАМ} = 4.98 > 5$$

$$N_{ГУАМ} = V_{хөөс} / V_{ГУАМ-ны хөөс} = 16.2 / 4.98 = 3,2 \approx 3 \text{ автомашин, нэмэлтээр пурга 5}$$

хөөсний гар хушуу – 1;

### 4. Нийт шаардлагатай усан хангамжийн тооцоо

$$V_{нийт ус} = V_{нийт хөөс} * 100 / q_{ггс} = 14580 * 100 / 5 = 243000 \approx 243 \text{ тонн}$$

Уг газрын тосны бүтээгдэхүүн хадгалах агуулахын гал түймэрт өртсөн сав, саванд байсан шатахууны хэмжээ, далангийн хэмжээ, шаардлагатай хөөс үүсгэгч бодис, усны нөөцийн хэмжээнд тооцоолол хийж үзэхэд 14580 литр хөөс үүсгэгч бодис, 243000 литр ус шаардлагатай байв. Иймд Нийслэлийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 10, 26, 63 дугаар ангиуд тус бүр 5 тонн хөөс үүсгэгч бодис бүхий хөөсөөр гал түймэр унтраах зориулалтын 3 автомашин, томилгоот бүрэлдэхүүний хамт Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын Гал түймэр унтраах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хэлтсийн дарга, дэд хурандаа П.Соронзонболдоор ахлуулан Дархан-Уул аймаг руу 11:23 цагт хөдөлсөн. Шаардлагатай усны нөөцийг бүрдүүлэх зорилгоор Гал түймэртэй тэмцэх газрын дарга, хурандаа Ц.Нямбаярын шийдвэрээр УБТЗ-ын Мандал сум дахь Цэрэгжүүлсэн хамгаалалттай Онцгой байдлын албаны 60 тонны усны багтаамжтай гал унтраах галт тэрэг 10:51 цагт, “Дархан төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн 40 тонн усны багтаамжтай “Белаз” автомашин 11:52 цагт тус тус гал түймрийн голомт руу хөдөлсөн байна. Хөөсөөр гал түймэр унтраах зориулалт бүхий автомашинууд болон нэмэлтээр гарсан ус тээвэрлэх зориулалттай галт тэрэг, автомашиныг гал түймрийн голомтод очих хүртэлх хугацаанд гал түймэр унтраах, аврах 7 ангийн 15 автомашин, 129 алба хаагч гал түймэрт өртсөн 2000 тонны багтаамжтай сав болон уг савнаас 15 метр зайтай байрлах тус бүр 400 тонны багтаамжтай 6 савыг гал унтраах бодисоор тасралтгүй хөргөлт хийж тухайн саван дахь шатахуун дэврэх, хальж асгарах, саванд задрал үүсэж, гал түймэр тархан дэлгэрэхээс урьдчилан сэргийлэх ажиллагааг оновчтой зохион байгуулж ажилласан байна.



Зураг 81. “ТЭС петролиум” ХХК-ийн газрын тосны бүтээгдэхүүний агуулахад гал гарч дэлбэрэлт үүссэн нөхцөл байдал

Монгол Улсын Шадар Сайдын 2016 онд баталсан “Гал түймэр унтраах дүрэм”-ийн гуравдугаар бүлгийн 140.8 дахь хэсэгт заасны дагуу гал унтраах шийдвэрлэх чиглэл буюу агаар механикийн хөөсний атак өгөх бэлтгэл ажлыг хангуулж, гал түймэр унтраах хүч хэрэгслийг тооцооллын дагуу байрлуулан

хөөсөөр гал түймэр унтраах зориулалт бүхий автомашинууд, ус тээвэрлэгч галт тэрэг, автомашин гал түймрийн голомтод очиж, хүч хэрэгслийг байрлуулж шийдвэрлэх чиглэлийн дагуу 3 ширхэг суурин лафетны хошуу, автомеханик шатыг сунгаж байрлуулан 2 дунд өсөлтийн хөөсний хошуугаар нэгэн зэрэг агаар механикийн хөөсний атакыг 16:33 цагт өгч эхлэн 30 минутын турш ажиллуулан 17:18 цагт гал түймрийн тархалтыг зогсоож, 18:44 цагт гал түймрийг бүрэн унтраасан байна.

Гал түймрийг унтраах үйл ажиллагааг нийтдээ 9 цаг 17 минутын турш зохион байгуулж, Гал түймэр унтраах, аврах 10 ангийн 140 алба хаагч, 20 автомашинтай ажиллаж, 150 тонн ус, 2.7 тонн шатахуун, 18.2 тонн хөөс үүсгэгч бодис зарцуулсан.

Ослын голомтод Нийслэлийн Онцгой байдлын газарт 40 албан хаагч, Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газарт 96 алба хаагч, Орхон аймгийн Онцгой байдлын газарт 4 албан хаагч, нийт 140 алба хаагч нэмэлтээр гал түймэр унтраах, аврах ангиудад үүрэг гүйцэтгэн ажилласан.

Гал түймэрт өртсөн 2000 тонны багтаамжтай шатахууны саванд үлдсэн 350 тонн АИ-92 шатахуун шатсан тохиолдолд 800,800 кг нүүрсхүчлийн хий агаарт дэгдэж, байгаль экологид ихээхэн хэмжээний хохирол учрахаас урьдчилан сэргийлж ажилласан.

Шаталт 8 цаг үргэлжилсэн гэж үзвэл 2.4 метр шатаж 1.6 метр буюу 260 метр.куб шатахууныг хамгаалсан байна.

Тооцоонд үндэслэн агаарт цацагдсан нүүрс хүчлийн хийг тодорхойлбол:

$CO_2 = 390,000 * 3.08 = 1,201,200$  кг нүүрс хүчлийн хий агаарт цацагдсан

$CO_2 = 260,000 * 3.08 = 800,800$  кг нүүрс хүчлийн хийг агаарт цацагдахаас урьдчилан сэргийлсэн байна.

Гал түймэр унтраах үйл ажиллагаанд Дархан-Уул аймгийн Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Дархан-Уул сумын ЗДТГ, Дархан-Ус суваг, УБТЗ-ын Мандал сум дахь Цэрэгжүүлсэн хамгаалалтай Онцгой байдлын алба, “Дархан төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК зэрэг нийт 8 байгууллага аж ахуйн нэгж, байгууллагын 152 алба хаагч, 30 автомашин, 1 галт тэрэгтэй ажиллаж дэмжлэг үзүүлсэн.

### **Хор уршгийг арилгах үйл ажиллагааны талаар:**

Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан аймгийн Онцгой комиссыг 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 20:00 цагт хуралдуулан Дархан сумын 3 дугаар баг “Тэс петролиум” ХХК-ны газрын тосны бүтээгдэхүүний агуулахад гарсан гал түймрийн үүссэн нөхцөл байдалд шат дараалалтай авах арга хэмжээ авах ажлын хэсгийг байгуулан цаг алдалгүй мэргэжлийн байгууллагуудын заавар, зөвлөгөөг боловсруулан үлдсэн холимгийг баталгаат саванд шилжүүлэх, буцалтгүй нэрвэгдэгсдийг эрэн хайх зэрэг асуудлыг шийдвэрлэн иргэд олон

нийтийг үнэн зөв бодит мэдээллээр хангаж ажилласан.

Тус газрын тосны бүтээгдэхүүн хадгалах агуулахын техникийн инженерийн өгсөн мэдээллээр гал түймэр гарахаас өмнө босоо ган саванд хэмжилт хийхээр 3 ажилтан /нягтлан, нярав, харуул/ ажиллаж байсан бөгөөд дэлбэрэлт болоход нэг ажилтан газрын гадаргууд шидэгдсэн байсныг олж, эмнэлгийн байгууллагад хүлээлгэн өгсөн боловч эмнэлэгт хүргэгдэх замдаа нас барсан. Хоёр иргэнийг босоо ган савны дотогш унасан байх магадлалтай гэж таамаг дэвшүүлэн эрэн хайх ажиллагааг үргэлжлүүлсэн.

Аймгийн Онцгой комиссын шийдвэрийн дагуу Онцгой байдлын ерөнхий газар, Хойд бүсийн төв, Дархан-Уулаймгийн Онцгой байдлын газар, Нийслэлийн Онцгой байдлын газар, “Тэс петролиум” ХХК, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газрын нийт 50 гаруй алба хаагчид 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 21:00 цагаас 2022 оны 12 дугаар сарын 03-ны 00:20 цаг хүртэл Дархан сум 3 дугаар багт байрлах “Тэс петролиум” ХХК-ны шатахууны агуулахын устай холилдсон 352тн АИ-92 холимгийг 10 автомашинд татан авч шилжүүлэх үйл ажиллагааг тасралтгүйгээр зохион байгуулж босоо ган савны люүкийг аюулгүй ажиллагааны зааварчилгааны дагуу онгойлгон шалгахад буцалтгүй 2 нэрвэгдэгсдийн байгаа газрыг тодорхойлж, савны ёроолын үлдэгдэл, лагийг соруулах, шавхалт хийх ажлыг гар насосоор хийж 00:20 цагт бүрэн дуусч, Цагдаагийн газрын бүрэлдэхүүнд хэргийн газрыг хүлээлгэн өгч ажилласан.

### **Буцалтгүй нэрвэгдэгсдийг татан гаргах ажиллагааны талаар:**

2022 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 10:00 цагт аймгийн Онцгой байдлын газрын офицер бүрэлдэхүүний шуурхай хуралдаан зохион байгуулж Онцгой байдлын газрын дарга, хурандаа С.Пүрэвсамдан буцалтгүй нэрвэгдэгсдийг татан гаргах талаар тактикийн үйл ажиллагааг боловсруулж Хойд бүсийн захирагч, хурандаа Г.Ганбаатар, Онцгой байдлын ерөнхий газрын дэд хурандаа П.Соронзонболд, Онцгой байдлын газраас 2 нэгж техник, 10 алба хаагч, Гал түймэр унтраах, аврах 22 дугаар ангиас 3 нэгж техник, 12 алба хаагч, Гал түймэр унтраах, аврах 54 дүгээр ангиас 3 алба хаагч, Эрэн хайх, аврах бүлгээс 1 техник, 5 алба хаагч, Гал түймэр унтраах, аврах 10 дугаар ангиас 1 нэгж техник, 2 алба хаагч нийт 7 техник, 33 алба хаагч ослын голомтод үүрэг гүйцэтгэхээр болж Онцгой байдлын газрын даргын А/84 тушаалаар Эрэн хайх ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг томилон аврах ажиллагаанд оролцож байгаа 33 алба хаагчийг удирдлага зохион байгуулалтаар ханган ажилласан байна.

Шатсан /резервуар/ босоо ган саванд үүссэн хийн холимгийг тодорхойлох /хэмжигч багаж/-оор Дархан-Уул аймгийн НИК ХК-ний лаборантаар Т.Солонгоор хэмжилт хийлгэхэд зөвшөөрөгдсөн хэмжээнээс 1800 дахин их байсан тул тухайн орчныг саармагжуулахаар Автомеханик шат ашиглан өндөр даралтын хөөсөөр агаарыг саармагжуулж 12:52 цагт босоо ган савны

люүкээр Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, дэд хурандаа Х.Энхнасангаар ахлуулсан эрэн хайх, аврах бүлгийн 4 аврагч орж буцалтгүй 2 нэрвэгдэгсдийг ослын голомтоос гаргах ажлыг зохион байгуулан ажилласан ба 13:01 цагт эхний буцалтгүй нэрвэгдэгчийг, 13:17 цагт 2 дахь буцалтгүй нэрвэгдэгчийг тусгай албаны автомеханик шат ашиглан олсоор бэхлэн татан гаргах ажиллагааг амжилттай зохион байгуулан аюулгүй талбайд гарган цагдаагийн байгууллагад тус тус хүлээлгэн өгсөн.

Ослын голомтод Онцгой байдлын байгууллагаас 7 нэгж техник, 36 алба хаагч, Цагдаагийн газраас 4 нэгж техник, 17 алба хаагч, Эрүүл мэндийн газраас 1 нэгж техник, 2 эмч, Прокурорын газраас 1 нэгж техник, 2 алба хаагч нийт 13 техник 57 алба хаагч эрэн хайх, татан гаргах ажиллагааг зохион байгуулсан.

### **Ар тал санхүүгийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар:**

